

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2020 №02 (72)
18 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун Бат-Эрдэнэ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D)

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД
ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237
ISBN 978-99929-62-31-3

СЭТГҮҮЛИЙН ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D)

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D)

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D)

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

Бэгзсүрэн Жамсран

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хийсэн дүн шинжилгээ	<i>Б.Энхболд С.Гантулга</i>	5
Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд гэмт хэргийн индексийн аргачлалыг нэвтрүүлэх нь	<i>С.Буянжаргал Б.Энхболд</i>	14
Эдийн засгийн аюулгүй байдлын сургалтын тогтолцооны өнөөгийн байдал	<i>М.Даваадулам Д.Булган</i>	17
Шинэ титэм вирус ба биотерроризм	<i>Г.Мөнгөншагай</i>	26
Гэр бүл дэх хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд боловсролын үзүүлэх нөлөө	<i>А.Номундарь</i>	30

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

БНАСАУ-ын Эрүүгийн хууль, түүний онцлог	<i>Г.Гантөмөр</i>	35
---	-------------------	-----------

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулга, мөн чанар, хууль зүйн учир холбогдол	<i>Б.Эрдэнэбилэе</i>	41
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал	<i>А.Амарсайхан</i>	61
Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний хэрэгжилт, анхаарах асуудал /БНХАУ, ОХУ-тай байгуулсан гэрээний тухайд/	<i>Б.Батцэрэн</i>	69

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Цагдаагийн албан хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх аргачлал, анхаарах асуудал	<i>Ш.Чулуун</i>	72
---	-----------------	-----------

ТӨР, ЗАХИРГАА, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Сонгуулийн маргааны харьяаллын асуудал	<i>Н.Мөнхзул</i>	83
Шүүх болон арбитраг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэх онолын асуудал	<i>Ж.Нямдулам</i>	94

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ АЛАХ БОЛОН ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Удиртгал

Судалгааны үндэслэл: Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны тоон мэдээллээс үзэхэд гэмт хэргийн улмаас 127 хүүхэд нас барж, 745 хүүхэд гэмтэж, 187 хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болжээ.¹ Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага болох “Хүүхдийг ивээх сан”-гаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүүхдийн эрх чөлөөний төлөв байдал” судалгаагаар 2018 онд Монгол Улс 100,000 хүн амд 1.4 хүүхдийн амь нас хохирсон үзүүлэлтээр 176 орноос 76-д орсон байна.² Уг судалгаагаар гэмт хэргийн улмаас хүүхдийн амь нас хохирч буй нөхцөл байдалд үндэслэн тухайн улс дахь хүүхдийн аюулгүй байдлын түвшнийг тодорхойлдог.

Иймд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээнд дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

Судалгааны зорилго: Энэхүү судалгааны хүрээнд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх талаар санал, зөвлөмж боловсруулахыг зорилгоо.

Судалгааны арга зүй Судалгааны хүрээнд бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийх, ярилцлага хийх аргыг ашигласан.

Түүвэрлэлтийн хэмжээ: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дахь хэсэг (2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.15 дахь хэсэг), Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт (2002 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэг) заасан хэргүүдийг хамааруулан бага насны хүүхдийг алсан 40, бага насны хүүхдийг хүчиндсэн 68, шүүхийн нийт 108 шийтгэх тогтоолыг түүвэрлэн авсан. Түүвэрлэлтэд хамрагдсан хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бага насны хүүхэд байх шалгуурыг тавьсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд “бага насны хүүхэд” гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно”³ гэсэн тодорхойлолтыг удирдлага болгов. Энэ төрлийн гэмт хэрэг нь хүнийг алах болон хүчиндэх нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин бага бөгөөд ихэвчлэн онц харгис хэрцгий аргаар, өөр гэмт хэргийг нуун далдлах зорилгоор үйлдэгддэг санаатай гэмт хэрэг тул нийгмийн хор аюул ихтэйд тооцогддог.

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, оногдуулсан ялын үндэслэлийг тодруулах зорилгоор хийсэн фокус ярилцлагын судалгаанд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэг мөрдөх хэлтсийн 11 мөрдөгч, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын 6 прокурор, Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 9 шүүгчийг түүвэрлэн ярилцлага хийсэн. Түүвэрлэлтэд хамрагдсан мөрдөгч, прокурор, шүүгчдийг сонгохдоо бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэж байсан туршлага, ажилласан жилийг харгалзав.

Судалгааны баг: Нээлттэй нийгэм форум төрийн бус байгууллагын санхүүжилтээр Судалгааны ажлыг Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор Б.Энхболд удирдаж, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор С.Гантулга, хууль зүйн магистр Б.Мөнхзул нар хамтран ажиллалаа.

¹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. УБ., 2018. 112 дахь тал


² Global childhood report 2019- Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report

³ Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг

1.Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал

Нэг.Хүнийг алах гэмт хэргийн нөхцөл байдал

График 1.1-Хүнийг алах гэмт хэргийн түвшин (2009-2019), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд⁴ дунджаар 212, сард 18 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.⁵ Үүнээс 2018 онд хүнийг алах гэмт хэрэг улсын хэмжээнд 192 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3 хэргээр буюу 1.6 хувиар өсч, нийслэлийн хэмжээнд 8 хэргээр буюу 6.8 хувиар буурч, орон нутгийн хэмжээнд 11 хэргээр буюу 15.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1.1 Хүнийг алах гэмт хэргийн гаралт (нутаг дэвсгэр, хүний тоогоор)

	Хэргийн тоо		Өсөлт, бууралт (хувиар)	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2017	2018		2017	2018
Орон нутагт	71	82	15.5	37.6	42.7
Нийслэлд	118	110	-6.8	62.4	57.3

Орон нутгаас Сэлэнгэ (10), Дорнод (9), Орхон (8), Өмнөговь (6), Хөвсгөл (5), Сүхбаатар (5), Төв (5) аймгуудад хүнийг алах гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Увс (1), Хэнтий (2), Дорноговь (2), Баян-Өлгий (2), Завхан (2), Өвөрхангай (2), Баянхонгор (2), Говь-Алтай (2), Завхан (2), Говьсүмбэр (2) аймгуудад хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Нийслэлийн дүүргүүдээс Сонгинохайрхан (30), Баянзүрх (22), Чингэлтэй (19) дүүргүүдэд хүнийг алах гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Багануур (1), Налайх (4), Хан-Уул (6) дүүргүүдэд цөөн гэмт хэрэг бүртгэгджээ.

⁴ 2009-2018 он

⁵ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 169 дэх тал

Хүнийг алах гэмт хэрэгт холбогдсдын нас, хүйсийн байдал

2018 онд хүнийг алах гэмт хэрэгт 201 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 буюу 2.6 хувиар өссөн байна. Холбогдогчдын 22 буюу 11 хувь нь эмэгтэй, 179 буюу 89 хувь нь эрэгтэй, тэдний 1 буюу 0.5 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс эрэгтэй 4.7 хувиар өсөж, эмэгтэй 12, хүүхэд 85.7 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм.




График 1.2



График 1.3

Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирогчдын статистик үзүүлэлт

2018 онд хүнийг алах гэмт хэргийн улмаас 196 хүн хохирч, үүнээс 168 нь нас барж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барса хүний тоо 1 буюу 0.6 хувиар буурсан байна.⁶ Хүснэгт 1.2

№	Үзүүлэлт	Он				Өсөлт, бууралт ⁷		Хугацаа		Өсөлт, бууралт	
		2015	2016	2017	2018	Хүний тоо	Хувь	2018 оны эхний 4 сар	2019 оны эхний 4 сар	Хүний тоо	Хувь
1	Хүнийг алах гэмт хэрэг	204	174	189	192	3	1.6	58	73	15	25.9
2	Хүнийг алах гэмт хэргийн хохирогч	214	184	191	196	5	2.6	58	74	16	27.6
3	Хүүхэд хохирсон хүнийг алах гэмт хэрэг	7	2	8	3	-5	-62.5	0	1	1	100
4	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/	9	2	9	3	-6	-66.7	-	1	1	100
5	Үүнээс	0-7 нас	5	1	7	3	-4	-57.1	-	-	-

⁶ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 171 дэх тал

⁷ Сүүлийн 2 жилийн байдлаар

6	8-13 нас	2	-	1	-	-1	-100.0	-	-	-	-
7	14-17 нас	2	1	1	-	-1	-100.0	-	1	1	100


Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Сүүлийн 4 жилд хүнийг алах гэмт хэргийн халдлагад 785 хүн өртөж, хохирогчдын 92 хувь нь нас барсан байна. Хүнийг алах гэмт хэрэг болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо сүүлийн 3 жил тогтвортой өсөж, хохирогчдын олонх энэ төрлийн гэмт хэргийн улмаас нас барж, эрүүл мэндэд нь хүнд хохирол учирчээ. Энэ гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх боломжгүй буюу хүний амьд явах эрх зөрчигддөг тул нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт тооцогддог. Энэ ч үүднээс дэлхийн улс бүр эрүүгийн хууль тогтоомждоо хүнийг алах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, энэхүү гэмт үйлдэлтэй ялын хатуу чанга бодлогоор тэмцдэг.

Сүүлийн жилүүдэд хүнийг алах гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал, 2015 онд 7 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2016 онд 2 гэмт хэрэгт 2 хүүхэд, 2017 онд 8 гэмт хэрэгт 9 хүүхэд, 2018 онд 3 гэмт хэрэгт 3 хүүхэд, 2019 оны эхний 4 сарын байдлаар 1 гэмт хэрэгт 1 хүүхэд тус тус хохирсон байна. **Үүнээс 2015 онд 7, 2016 онд 1, 2017 онд 8, 2018 онд 3 бага насны хүүхэд хохирч, нас баржээ.**

Хоёр. Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал

График 1.4-Хүчиндэх гэмт хэргийн түвшин (2009-2019), хүний тоогоор



Сүүлийн 10 жилд⁸ дунджаар 345, сард 29, хоногт 1 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.⁹ Үүнээс 2018 онд хүчиндэх гэмт хэрэг улсын хэмжээнд 519 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 143 хэргээр буюу 38 хувиар өсжээ. Нийслэлийн хэмжээнд 75 хэргээр буюу 38.6 хувиар, орон нутгийн хэмжээнд 67 хэргээр буюу 37 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 1.3-Хүчиндэх гэмт хэргийн гаралт (нутаг дэвсгэрээр, хүний тоогоор)

	Хэргийн тоо		Өсөлт, бууралт (хувиар)	Тухайн хэрэгт эзлэх хувь	
	2017	2018		2017	2018
Орон нутагт	182	249	36.8	48.4	48.0
Нийслэлд	194	269	38.7	51.6	51.8

⁸ 2009-2018 он

⁹ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019. 176 дахь тал


Бусад		1		0.2
-------	--	---	--	-----

Орон нутгаас Орхон (22), Хөвсгөл (20), Сэлэнгэ (18), Дорноговь (18), Хэнтий (17), Баянхонгор (17), Дорнод (16), Төв (16) аймгуудад үчиндэх гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Говь-Алтай (2), Завхан (2), Говьсүмбэр (3), Дундговь (4), Булган (5) аймгуудад хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Нийслэлийн дүүргүүдээс Сонгинохайрхан (69), Баянзүрх (77), Баянгол (43) дүүргүүдэд үчиндэх гэмт хэрэг хамгийн их бүртгэгдсэн бол Налайх (4), Багануур (8) Хан-Уул (17) дүүргүүдэд цөөн гэмт хэрэг бүртгэгджээ.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн байдал

2018 онд 338 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 буюу 11.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Холбогдогчдын 3 буюу 0.9 хувь нь эмэгтэй, 335 буюу 99.1 хувь нь эрэгтэй, тэдний 24 буюу 7.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс хэрэгт холбогдсон эрэгтэй 10.9 хувиар, эмэгтэй 50.5 хувиар тус тус өсөж, хүүхэд 20 хувиар буурсан байна.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал



Хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогсдын тоон үзүүлэлт

2018 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 487 хүн хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 119 буюу 32.3 хувиар өссөн байна. Үүнээс 2 хүн нас барж, 89 хүний эрүүл мэндэд хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 1 буюу 2 дахин өсөж, эрүүл мэндэд хохирол учирсан хүний тоо өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Хүснэгт 2.5

№	Үзүүлэлт	Хугацаа				Өсөлт, бууралт ¹⁰		Хугацаа		Өсөлт, бууралт	
		2015 он	2016 он	2017 он	2018 он	Тоо	Хувь	2018 оны эхний 4 сар	2019 оны эхний 4 сар	Тоо	Хувь
1.	Хүчиндэх гэмт хэрэг	279	290	376	519	143	38.0	193	217	24	12.4

¹⁰ Сүүлийн 2 жилийн байдлаар

2.	Хүчиндэх гэмт хэргийн хохирогч	287	295	368	487	119	32.3	178	210	32	18.0	
3.	Хүүхэд хохирсон хүчиндэх гэмт хэрэг	134	140	183	235	52	28.4	75	110	35	46.7	
4.	Үүнээс хохирогч хүүхдийн тоо /0-17 нас/	139	143	187	238	51	27.3	77	112	35	45.5	
5.	Үүнээс	0-7 нас	7	18	20	20	0	0.0	6	9	3	50.0
6.		8-13 нас	47	45	59	91	32	54.2	26	39	13	50.0
7.		14-17 нас	85	80	108	127	19	17.6	45	64	19	42.2

Эх сурвалж: ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

Хүчиндэх гэмт хэрэг нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж, улмаар хүний амьд явах эрх, эрүүл амьдрахын халдашгүй байдалд ихээхэн хохирол, хор уршиг учруулдаг нийгэмд хор аюул их учруулдаг гэмт хэрэг юм. Сүүлийн 4 жилд хүчиндэх гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийн улмаас 1437 хүн хохирчээ. Ялангуяа хохирогчдын тоо сүүлийн 3 жилд огцом өсжээ. Үүний дотор энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд, тэр дундаа бага насны хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тухайлбал 2015 онд 134 гэмт хэрэгт 139, 2016 онд 140 гэмт хэрэгт 143, 2017 онд 183 гэмт хэрэгт 187, 2018 онд 235 гэмт хэрэгт 238, 2019 оны эхний 4 сарын байдлаар 110 гэмт хэрэгт 112 хүүхэд тус тус хохирчээ. **Үүнээс 2015 онд 54, 2016 онд 63, 2017 онд 79, 2018 онд 111 бага насны хүүхэд хохирсон байна.**

2.Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Судалгааны үр дүнгээс үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 98.5 хувийг эрэгтэй, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 55 хувийг эрэгтэй, 45 хувийг эмэгтэй хүн үйлдсэн байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 50.0 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэрэг үйлдсэн хүний 62.5 хувийг 19-30 насны хүн эзэлж байгаа бол 51-74 насны хүмүүс бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдол 6 орчим хувь байна. Харин бага насны хүүхдийг 51-ээс дээш насныхан алсан тохиолдол бүртгэгдээгүй байна.
2. Судалгаанаас үзэхэд, бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүний 90 орчим хувь нь бүрэн дундаас доош, 60 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой, 85 орчим хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 70 орчим хувь нь орон нутагт төрж, өссөн, 19 орчим хувь нь урьд нь ял шийтгэгдэж байсан хүн байна.
3. Хорих ял биечлэн эдэлсэн хүн зан байдлын хувьд засарч хүмүүжээгүй байхад хугацаанаас нь өмнө тэнсэн сулласан, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, өршөөгдсөн үед цагдаагийн байгууллага хяналт сул тавьсан нь энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болсон тохиолдол цөөнгүй байна. (Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг түүвэр судалгаа №2, 4, 5, 10)
4. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 90 орчим хувь нь сургууль, цэцэрлэгт хамрагддаг, сэтгэц, бие махбодын хувьд эрүүл, хүчиндэх гэмт хэргийн хувьд 13-14 насны хүүхэд халдлагад өртсөн тохиолдол 47 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 8-10 насны хүүхэд хохирсон тохиолдол 37.5 хувь, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын хамгийн бага нь 1 настай хүүхэд байна. Мөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 97.1 хувь эмэгтэй хүүхэд байхад хүүхдийг алах гэмт хэргийн хувьд 65 хувь мөн эмэгтэй хүүхэд байгаа нь анхаарал татаж байна.
5. Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд ялангуяа хохирогч өөрийн амьдардаг гэртээ болон төрөл садангийн хүний гэрт халдлагад өртөж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 38.2 хувь, хүүхдийг алах гэмт хэргийн 40 хувь нь хүүхэд өөрийн амьдардаг гэртээ халдлагад өртсөн бол

- бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн 30.9 хувь, бага насны хүүхдийг алах гэмт хэргийн 27.5 хувь нь хамаатан садан, эцэг, эхийн найзын гэрт халдлагад өртжээ.
6. Гэр бүл салалт, гэр бүлийн тогтворгүй байдал, хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа зэрэг нь бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болж байна. Судалгаанаас үзэхэд, өөрийн төрсөн хүүхдээ хүчиндсэн тохиолдол 2.9 хувь, төрсөн хүүхдээ алсан тохиолдол 42.5 хувийг тус тус эзэлж байна. Харин дагавар хүүхдээ хүчиндсэн тохиолдол 19.1 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг хүчиндсэн тохиолдол 17.6 хувийг эзэлж байгаа бол дагавар хүүхдээ алсан тохиолдол 15 хувь, төрөл, садангийн хүний хүүхдийг алсан тохиолдол 12.5 хувийг тус тус эзэлж байна. Тухайлбал, гэр бүл салж, хоёр дахь амьдрал зохиосонтой холбоотойгоор дагавар хүүхдээ үзэн ядаж удаан хугацаанд зоддог байснаас хүүхдийг алсан тохиолдол 25 хувь, өөрийн төрсөн хүүхэд биш гэсэн шалтгаанаар бага насны хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 40.2 хувийг эзэлж байна. Эцэг эх нь салсан, эцэг эхийн аль нэг нь өөр хүнтэй гэр бүл болсон гэсэн шалтгаанаар эмээ, өвөөгийн гэрт байхдаа бусад хүмүүст хүчиндүүлсэн тохиолдол 27.9 хувийг тус тус эзэлж байна. (Бага насны хүүхдийг алах гэмт хэрэг түүвэр судалгаа №8, 10, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг түүвэр судалгаа №3 үзнэ үү)
 7. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх, удаан хугацаанд үргэлжлэх шалтгаан, нөхцөл болж байна. Судалгаанаас үзэхэд, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл төрөл, садангийн хүний халдлагад өртсөн бага насны хохирогч тэр даруй бусдад мэдэгдсэн тохиолдол 16 буюу 23,5 хувьтай байгаа анхаарал татаж байна. Хохирогч жирэмсэн болсон, эсхүл бэлгийн замын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, үйлдэл дээрээ баригдсанаас бусад тохиолдолд хохирогч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байна. Удаан хугацаанд нуун далдалсан шалтгаан нь 40,4 дарамтад өртсөн, 20,3 хувь хууртагдсан, 17 хувь гэр бүлийн гишүүдээсээ санаа зовсон /ээж, дүү/, 19,1 хувь бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгоогүй зэрэг байна. Харин үл таних хүнд хүчиндүүлсэн тохиолдолд хохирогч ойролцоо байгаа хүн болон өөрийн эцэг, эх ойр дотнын хүндээ шууд мэдэгддэг байна. (Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг түүвэр судалгаа №4, 9)
 8. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийн хувьд хохирогчийн буруутай үйл ажиллагаа бараг тогтоогдоогүй, харин гэнэн итгэмтгий зангаасаа болж гэмт хэрэгт хохирсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, “Ухаан алдахаар гоё мөдрэмж төрдөг” гэсэн үгэнд хууртаж, өөрийгөө боолгуулсан байна. Харин хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мөнгө шаардлагатай болсон, зочид буудал, гэмт хэрэг үйлдсэн хүний ажлын байранд очсон, тээврийн хэрэгслээр зугаалсан, ажил, хөдөлмөр эрхлэх нэрээр садар самуун явдалд орж биеэ үнэлсэн, бусдаас тусламж хүсэх боломж байсаар байтал тусламж аваагүй зэрэг нь хохирогч болоход нөлөөлсөн байх боломжтой байна. Эдгээр нөхцөл байдлын цаана гэр бүлийн таагүй орчин, эцэг, эхийн хараа хяналт сул, гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл байгааг анхаарах нь зүйтэй. Судалгаанаас үзэхэд, 12 настай охин ажил хийж байгаа нэрээр гэртээ нэг сар орчим ирээгүй байхад эцэг, эх нь хайгаагүй байх, хойд эцэгтээ хүчиндүүлсэн охин нэгэнт хүчиндүүлсэн гэсэн шалтгаанаар бусад хүнтэй төлбөртэй бэлгийн харьцаанд орсон тохиолдол байна.
 9. Бага насны хүүхдийг биеэ хамгаалж чадахгүй гэдгийг нь мэдсээр байж зодох, боох, шидэх зэрэг аргаар алсан тохиолдол дийлэнх хувийг эзэлж байна. Бага насны хүүхдийг алах гэмт хэргийг үйлдсэн хүн өмнө үйлдсэн гэмт хэргийг бага насны хүүхэд харсан тохиолдолд гэмт хэргээ нуун далдлах, хялбарчлах зорилгоор тухайн бага насны хүүхдийг алсан үйлдсэн тохиолдол 25 хувь, хүүхдийн хийсэн үйлдэлд зэвүүцэх, үзэн ядах, үгэнд орсонгүй гэсэн үл ялих зүйлээр шалтгаглаж алсан тохиолдол 35 хувь, тэжээн тэтгэхээс зайлсхийх сэдэлт, зорилготой 20 хувь байгаа нь анхаарал татаж байна. Хүчиндэх гэмт хэргийн хувьд бэлгийн харьцааны учир холбогдлыг ойлгохгүй байгааг далимдуулж, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглүүлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах, хууран мэхлэх зэрэг аргаар ихэвчлэн үйлдэгдсэн байна.
 10. Хүчиндэх гэмт хэргийн улмаас бага насны хохирогч болон түүний ойр дотны хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаанд ихээхэн хохирол учирч байна. Тухайлбал,

хохирогч нас барсан, амиа хорлосон, сэтгэцийн эмгэгтэй болсон, жирэмсэн болсон, ураг хөндүүлсэн, бэлгийн замын халдварт өвчтэй болсон, сургууль завсардсан, гэр бүлээсээ дайжсан, гэр бүл салсан, биеэ үнэлэх болсон, бэлгийн замбараагүй харьцаанд орж эхэлсэн зэрэг сөрөг үр дагавар бий болжээ.

11. Хүчиндэх гэмт хэргийн хохирогч 10-14 насны хүүхдийн хувьд сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, өөрийн гэсэн үзэл бодол тогтоогүй байдаг учир сониуч зан, адал явдалд дурлах, итгэмтгий байх, хөөрч сагсуурах, шинэ нөхцөл байдалд дасах чадавхгүй байх, хайр халамж дутагдах, зарим тохиолдолд биеийн хөгжлийн онцлог зэрэг нь хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Зөвлөмж

Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр:

1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөх эрсдэлийн судалгааг жил бүр хийж, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бодлого боловсруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхдөө судалгааны үр дүнг ашиглах;
2. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтийн байдалд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх;
3. Хүүхэд гэмт хэрэгт хохирох, ялангуяа хүнийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жинг бууруулах чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, гэр бүлийн харилцаа, гэр бүл төлөвлөлт, эцэг, эхийн хариуцлага, үлгэр дуурайлал, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
5. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгэм, хамгааллын яам, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, батлан хамгаалах яам хамтран гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, гэр бүл салалтаас үүсэх үр дагаврын талаар сургалтын хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутан, хугацаат цэргийн алба хаагч нарт сургалт явуулах ажлыг тогтмолжуулах;
6. Хүүхдийн эрхийн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн үйл ажиллагааг хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг илрүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахад чиглүүлэх, ажлын үр дүнг тооцож, ажиллах;
7. Садар самуун явдал, биеэ үнэлэх, хардалт, эцэг эхээ үл тоомсорлох зэрэг хүүхдийн сэтгэхүй, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх агуулга бүхий насанд хүрэгчдэд зориулсан телевизийн нэвтрүүлэг, кино, ярилцлага, цэнгээт үзүүлбэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараахгүй байхад анхаарах, бага насны хүүхэд интернет орчинд чөлөөтэй нэвтрэх нь зохистой эсэх, хязгаарлалт тогтоох боломж нөхцөлийн талаар судлах;
8. Бага насны хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрх бүхий байгууллага, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан, гэр бүлийн гишүүдэд цаг алдалгүй хандах талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар мэдээлэл хүргэх;
9. Энэ төрлийн гэмт хэргийг түгээмэл үйлдэж буй 19-25 насны бүрэн дундаас доош боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилгүй, ял шийтгэл эдэлж байсан, тэнсэгдсэн, ял хойшлогдсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шийтгэгдсэн этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах, гэмт хэргийн хор уршиг, эрүүгийн хариуцлагын талаарх болон зан үйлд нөлөөлөх сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулах;
10. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж суллагдсан хүнд тавих хяналтыг сайжруулах, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх;
11. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг эрүүл мэндийн үзлэг, хүүхдийн хөгжлийн ерөнхий байдлын судалгаанд тогтмол хамруулах;

Ном зүй

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017. УБ., 2018
- Global childhood report 2019- [Savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report](https://www.savethechildren.org/us/about-us/resource-library/annual-report)
- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2017. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2018
- Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2018. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. УБ., 2019

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГЭМТ ХЭРГИЙН ИНДЕКСИЙН АРГАЧЛАЛЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

*С.Буянжаргал
Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын дарга,
цагдаагийн хурандаа*

*Б.Энхболд
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Гэмт хэргийн албан ёсны статистикт тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх гадаад орны туршлагыг судалж, Монгол Улсад нэвтрүүлэх боломж, ач холбогдлыг тодорхойлсон.

Түлхүүр үг: Гэмт хэргийн статистик, индекс, гэмт хэрэг, индекс бус гэмт хэрэг.

Удиртгал

Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлэхэд Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоох, нийт гэмт хэрэгт эзлэх тодорхой төрлийн гэмт хэргийн хувийн жинг тодорхойлж, хэмжих шаардлагатай.

Гэмт хэргийг хэмжих гэдэг нь үйлдэгдэж байгаа гэмт хэргийн бодит түвшинг тогтооход чиглэгдсэн шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан мэдээлэл цуглуулах үйл явц юм. Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд, гэмт хэргийг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих аргачлал түгээмэл ашиглагдаж байна.

Гэмт хэргийг хэмжих тооны аргачлал гэдэг нь статистикт үндэслэн гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт өгдөг бол чанарын аргачлал нь статистик үзүүлэлтээр шууд тодорхойлох боломжгүй гэмт хэргийн түвшинг судалгааны нарийвчилсан арга зүйгээр шалган тогтоодог аргачлал юм.

Энэхүү өгүүллийн зорилго нь гэмт хэргийн албан ёсны статистикт тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх боломж нөхцөлийг тодорхойлоход чиглэгдэнэ. Судалгааны ажлын хүрээнд 2009-2018 онд Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, Баянгол дүүргийн хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлтийг ашиглаж дүгнэлт хийсэн.

Үндсэн хэсэг

Гэмт хэргийн албан ёсны статистик гэж эрх бүхий байгууллагаас баталсан аргачлал, үзүүлэлтээр гэмт хэрэг, гэмт хэргийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүн, оногдуулсан ялын төрөл, хэмжээний талаар статистикийн үйл ажиллагааны хөтөлбөр аргачлалаар гаргасан мэдээллийг ойлгоно.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад жилд дунджаар 25297 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 0.8 хувь нь хүнийг алах, 25 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 4.4 хувь нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 34 хувь нь хулгайлах, 14.8 хувь нь залилах, 4.1 хувь нь дээрэмдэх, 3.4 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг тус тус байжээ. Эдгээр 7 төрлийн гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 86.5 хувийг эзэлж байсан бол бусад гэмт хэрэг 14.5 хувийг эзэлж байна.¹¹

Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газарт 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзвэл, 90 орчим хувь нь хулгайлах, залилах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь бусад дүүрэг, орон нутгийн нөхцөл байдалтай төстэй байна.¹² Харин гэмт хэргийн индекс гаргадаг олон улсын байгууллагын судалгаагаар Монгол Улсын иргэдийн 70.5 хувь эд хөрөнгөө хулгайд алдах, 60.1 хувь нь бусдын хүч хэрэглэсэн халдлагад өртөж болзошгүй гэж түгшиж байгаагаа илэрхийлжээ.

¹¹ Цагдаагийн ерөнхий газар. "Монгол Улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал /2009-2018". УБ., 2019

¹² Баянгол дүүрэг дэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2019

Дээрх судалгаанаас дүгнэхэд, Монгол Улс дахь гэмт хэргийн гаралтад хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хулгайлах болон залилах гэмт хэргүүд шууд нөлөөлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг алдагдуулж, иргэдийн цагдаад итгэх хандлагад сөргөөр нөлөөлж байна.

Гэтэл хулгайлах, хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг нийгмийн үзэгдэл болж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, засгийн зүгээс тогтвортой арга хэмжээ авч, хүний нөөцийг бэхжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй байгаагаас цагдаагийн байгууллагын алба хаагчид энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, мэргэших хүсэл сонирхолгүй, харин шинэ төрлийн гэгдэх мансууруулах бодис, хүн худалдаалах, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагууд нэмэгдэж, энэ чиглэлээр ажиллах албан хаагчдын тоо нэмэгдэж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 5.4.4-т “Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж заасан.¹³ Энэ ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын бүтцэд тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх дагнасан албадыг шат дараатайгаар байгуулж, сүүлийн 3 жилийн хугацаанд хар тамхи, хүн худалдаалах, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын болон дотоодын санхүүжилтээр томоохон төсөл хэрэгжиж, 1000 орчим цагдаагийн албан хаагчийг мэргэшүүлэн сургажээ.

Харин гэмт хэргийн бүтцэд 85-аас дээш хувийг тогтвортой эзлэх болсон хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, хулгайлах, залилах зэрэг тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бодлогын шинжтэй ажил, арга хэмжээ хийгдэхгүй явсаар байна.

Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг шинэ төрлийн гэмт хэргээс дутуугүй түвшинд авч үзэх шаардлага тулгарч байна. Энэ нь зөвхөн манай улсад төдийгүй гадаадын бусад улсад ч тулгардаг нийтлэг бэрхшээл боловч бодлогын гадна хэзээ ч орхидоггүй сайн туршлага байна.

Гадаадын дийлэнх улсын туршлагаас үзэхэд, гэмт хэргийн индекс (index crime) болон индекс бус гэмт хэрэг (non-index crime) гэж 2 ангилан бүртгэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, төсвөө тодорхойлдог байна.¹⁴

Гэмт хэргийн статистикийг 2 хэсэгт бүлэглэн бүртгэх ажил 1979 онд АНУ-ын Холбооны мөрдөх товчооны санаачлагаар хэрэгжиж, дэлхийн олон улсуудад нэвтэрсэн байна.

Индекс гэмт хэрэг гэдэг нь тухайн улсад түгээмэл үйлдэгддэг болон дэлхийн аль ч улсад гэмт хэрэгт тооцогддог хүнийг алах, хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хулгайлах, залилах, дээрэмдэх, хүчиндэх, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зэрэг гэмт хэргүүд хамаардаг. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төсөв, хүний нөөцийн асуудлыг тусгайлан тодорхойлдог бөгөөд төсвийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглодог байна.

Индекс бус гэмт хэрэгт түгээмэл биш боловч нийгмийн хор аюулаар ихтэй бусад төрлийн гэмт хэрэг хэргүүд тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, хүн амын эрүүл мэнд, байгаль орчны эсрэг гэмт хэргүүд хамаардаг байна. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсад туршлагыг нэвтрүүлэх арга зам

- Монгол Улсын хувьд индекс гэмт хэргийн эхний байруудад хулгайлах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг орох нь судалгаагаар тогтоогдож байна.
- Цагдаагийн байгууллага гэмт хэргийн индекс (index crime) болон индекс бус гэмт хэрэг (non-index crime) гэж 2 ангилан бүртгэх, индекс гэмт хэргийн төрөлд багтах гэмт хэрэгтэй (хүнийг алах, хүний эрүүл мэндийн хохирол учруулах, хүчиндэх, хулгайлах, залилах, дээрэмдэх, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг зэрэг гэмт хэрэг) тэмцэх төсөв, стратегийг боловсруулан хэрэгжилтийг нь ханган ажиллах;
- Түгээмэл үйлдэгддэг буюу индекс гэмт хэргийн нотлох баримтыг судлан шинжлэх техник, технологи шаардлагын түвшинд хүрэхгүй, мэдүүлэгт суурилсан мөрдөн шалгах

¹³ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.4.4 дэх заалт

¹⁴ Ronald L.Akers and Christine S.Sellers, “Criminological theories: introduction, evaluation, application” sixth edition, New York Oxford University. Press 2013.

ажиллагаа зонхилж байгаа нь гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын чанар, үр дүнд шууд нөлөөлж байна. Иймд Цагдаагийн албаны тухай хуулийн 6.6 дахь хэсэгт заасны дагуу эд мөрийн баримт, шинжилгээний лаборатори байгуулах ажлыг зохион байгуулах;

- Индекс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад цагдаагийн байгууллагаас гаргаж байгаа зардлын тооцоог төсвийн тодотголоор болон жил тутам танилцуулж, шийдвэрлүүлж байх. Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн ажлыг дүгнэхдээ индекс гэмт хэргийн гаралтыг бууруулж, чадсан эсэхийг харгалзаж байх зүйтэй.

Дээрх аргачлалыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод өөрчлөлт орж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахад эерэг нөлөө үзүүлэх;
- Цагдаад итгэх олон нийтийн хандлага нэмэгдэж, иргэд-цагдаагийн хамтын ажиллагаа шинэ түвшинд гарах;
- Цагдаагийн байгууллагын гэмт хэргийг бүртгэх аргачлал олон улсын жишигт нийцэх;
- Монгол Улсын гэмт хэргийн нөхцөл байдлыг бусад улс оронтой харьцуулахад нэг стандарт мөрдөгдөх нөхцөл бүрдэнэ. Тухайлбал, дэлхийн улс орнуудын гэмт хэргийн нөхцөл байдлыг индекс гэмт хэргийн үзүүлэлтээр харьцуулан тодорхойлдог.

Ном зүй

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2016-2020/
- Цагдаагийн ерөнхий газар. “Монгол Улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2009-2018”. УБ., 2019
- Баянгол дүүрэг дэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2019
- Ronald L.Akers and Christine S.Sellers, “Criminological theories: introduction, evaluation, application” sixth edition, New York Oxford University. Press 2013.

ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

М.Даваадулам
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Д.Булган
Доктор (Ph.D), дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улс дахь эдийн засгийн аюулгүй байдлын талаарх сургалтын тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Боловсрол, боловсролын тогтолцоо, эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдал

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлд 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заасан нь аюулгүй байдлыг хангах чиг үүргийг төрийн үүрэгт хамааруулжээ. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, 16 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ...хамгаалуулах эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 3-т “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”¹⁵ гэж заасан. Эдгээр заалтаас харахад төрийн үүрэг, иргэний эрх, үүргийн тэнцвэрийг хадгалж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг зохицуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр заалтад үндэслэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт тодорхойлсноор эдийн засгийн аюулгүй байдал нь Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, ... эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана”¹⁶ гэж заасан. Эндээс харахад, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, олон тулгуурт бүтцийг бий болгох асуудал үндэсний аюулгүй байдлын цогц бодлогын бүрэлдэхүүн хэсэг болж чадсан.

Мөн үзэл баримтлалын 1.2.4 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь “мэдлэгт суурилах” зарчим дээр тулгуурлах буюу аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна” гэж заасан.

Монгол Улс ардчилсан, зах зээлийн тогтолцоонд шилжсэн 30 жилийн хугацаанд эдийн засаг өсч, хөгжлийн тодорхой хэд хэдэн үзүүлэлтүүдээрээ дэлхийн дундаж түвшний хөгжилтэй орнуудын тоонд багтаж, уул уурхай, газар тариалан, барилга, худалдаа үйлчилгээний салбарт тодорхой ахиц дэвшилд хүрсэн боловч олон салбарт эрсдэлүүд байсаар байна. Тухайлбал, Монгол Улсын дунд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ (тайлан IV) нөхцөл байдлын шинжилгээнд манай орон гадаад өрийн хүнд дарамтад орсон, экспортын гол нэрийн бүтээгдэхүүн нь БНХАУ-ын ганц зах зээлээс шууд хараат, шатахууны хувьд ОХУ-аас бүрэн хараат (98 хувийг авдаг), орлогын гол эх үүсвэр болох уул уурхайн бүтээгдэхүүнээс олох орлого нь эрдэс түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнээс шууд хамааралтай зэрэг шалтгааны улмаас эдийн засаг маань бүхэлдээ эмзэг, эрсдэл өндөртэй¹⁷ гэж дүгнэжээ. Мөн хөдөө аж ахуйн салбарт байгаль, цаг уурын нөхцөлөөс шууд хамааралтай ган, зуд тохиолдож мал аж ахуй болон газар тариаланд ихээхэн гарз хохирол учрах асуудал хэвээр байна. Үүнээс гадна чулуун нүүрсний 97,9 хувь, зэсийн баяжмалын 100 хувь, молибдены баяжмалын экспортын 92,7 хувь, хайлуур жоншны 42 хувь, төмрийн хүдрийн 100 хувийг тус тус БНХАУ руу экспортолдог. БНХАУ COP-215 гэрээнд нэгдсэнээр дэлхийн дулаарлын үйл явцад үзүүлэх

¹⁵ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. Төрийн мэдээлэл №1

¹⁶ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол

¹⁷ Монгол Улсын дунд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ (тайлан IV) УБ., 2018 он. <http://nda.gov.mn/>

нөлөөллийг бууруулах зорилгоор нүүрснийхээ хэрэгцээг хязгаарлах бодлого явуулж эхэлсэн тул цаашдаа Монгол Улс нүүрс экспортолж, орлогынхоо үлэмж хэсгийг олдог арга зам хязгаарлагдаж болзошгүй гэдгийг мэргэжилтнүүд хамгийн түрүүнд нэрлэж байна.

Монгол Улсад цэргийн уламжлалт аюул занал үүсгэх хүчин зүйлүүд харьцангуй суларч газрын тос, байгалийн хий, эрчим хүчний хомстол, санхүү, хөрөнгийн зах зээлийн хямрал, шашин, соёлын нөлөөлөл зэрэг уламжлалт бус аюул, занал зонхилох болсон. Эрдэс, баяжмалын нөөц, агуулгыг бүрэн тооцохгүй, татвар, шимтгэлийг бүрэн авахгүй, тусгай зөвшөөрөл, химийн хортой бодисын хэрэглээнд тавих төрийн хяналт сул, зах зээл дэх монополь, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, хууль бус ашигт малтмал олборлогчдыг хязгаарлаж бусад салбарт ажлын байраар хангаж чадахгүй, байгаль орчныг ихээхэн сүйтгэж, мөнгө угаах, нийгмийн даатгал хууль бусаар авах гэх зэрэг нь эдийн засгийн салбарын олон жил үргэлжилсэн хүндрэлүүд болоод байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх, “эдийн засгийн аюулгүй байдал-эрх зүй”-н чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч, мөрдөгч, аудитууудыг бэлтгэх хэрэгцээ шаардлага байна. Тиймээс энэхүү сэдвээр Монгол Улсад эдийн засгийн аюулгүй байдлын мэргэжилтэн, алба хаагчдыг бэлдэж буй сургалтын өнөөгийн байдлыг судалж, дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох талаар судаллаа.

Нэг.Боловсролын тогтолцооны мөн чанар: Монгол Улс ардчилсан зах зээлийн харилцаанд шилжсэн сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санаа, хууль, эрх зүйн хувьд нэлээд өөрчлөлтүүд явагдаж, сургалтын үйл ажиллагаанд ч шинэ тогтолцоо, шинэ зарчим, шинэ аргыг хэрэгжүүлсэн билээ. Боловсролын бодлогын баримт бичгүүдийг энэхүү цаг хугацаатай уялдан боловсруулсан. Тухайлбал, 1991 онд “БНМАУ-ын боловсролын тухай хууль”¹⁸-иар дээд боловсролыг зах зээлийн зарчимд шилжих суурийг тавьснаар энэ салбарт бүх түвшний засаглалын төвлөрлийг бууруулах, түүнчлэн хувийн хэвшлийг бий болгох, сургалтын төлбөрт шилжих суурийг тавьсан байдаг. Мөн 1995 онд “Боловсролын тухай Монгол Улсын хууль”, 2002 онд “Дээд боловсролын тухай хууль”, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2008 онд “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль” тус тус батлагдан гарч, боловсролын тогтолцоонд шинэчлэл хийгдсээр ирсэн.

Боловсрол нь хүний сурч боловсрох хэрэгцээг хангахад чиглэсэн, урьдчилан нарийвчилж төлөвлөсөн, системтэй үйл ажиллагаанаас бүрдэнэ. Боловсролын үйл ажиллагаа нь эрдэм мэдлэг (learning) олгоход чиглэсэн зохион байгуулалттай, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоо (communication) юм.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заасан. Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ”¹⁹ гэж заасан.

Дараах хүснэгтээр боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд, түүний зорилгыг харьцуулан авч үзье.

	Боловсролын тогтолцоо	Зорилго, зорилго	Онцлог
	Доктор	Дээд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1. Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино. ²⁰	Магистр, докторын сургалтын онцлог нь төрөөс баримтлах бодлого болон боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг хандлагатай нийцэхүйц шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр суралцагсдад сургалт, эрдэм шинжилгээ, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг,
	Магистр		

¹⁸ Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл –II УБ., 2014, 8-19 дэх тал

¹⁹ Боловсролын тухай хууль. 2002 он, Төрийн мэдээлэл №19.

²⁰ Дээд боловсролын тухай хууль. УБ., Төрийн мэдээлэл 2002 он, №19

			чадвар, дадал болон судалгаа, туршилтын арга зүй эзэмшүүлж, иргэний өндөр боловсрол, соёлыг төлөвшүүлэхэд чиглэнэ
	Бакалавр		Бакалаврын оюутнууд сонгосон мэргэжлээрээ онол, практик мэдлэг олж авахад чиглэсэн дээд боловсролын анхан шатны түвшин юм. Бакалаврын сургуулыг дүүргээд дээд боловсролын диплом авдаг бөгөөд энэ нь түүнд мэргэжлээрээ ажиллах боломжийг олгодог.
	Коллеж диплом	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино. ²¹	Энэхүү сургалтаар суралцагчдад мэргэжил, мэргэшлийн ур чадварыг чадамжид суурилсан сургалтаар олгож, бизнес сэтгэлгээг нь хөгжүүлэх, ажил, амьдралд өөрийгөө аваад явах чадвартай болгоход чиглэсэн сургалтыг тусгаж хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, “Сургууль + Жижиг үйлдвэр” гэж хэлж болно.
	Дунд сургууль	Бага дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1. Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино. ²²	Энэхүү сургалтаар “бүх нийтийн ерөнхий боловсрол”-ыг 12 жилийн хугацаатайгаар сургалтын агуулгын батлагдсан хөтөлбөрийн дагуу олгодог.
	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн	Энэхүү сургалтын онцлог нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлдэг

²¹ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай. УБ., 2009 он, Төрийн мэдээлэл №10.

²² Бага дунд боловсролын тухай хууль. УБ., 2002 он, Төрийн мэдээлэл №19

	онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино. ²³	сургалтын байгууллага юм.
--	--	---------------------------

Дээрх хүснэгтэд боловсролын тогтолцоон дахь шаталсан сургалтуудын зорилго, онцлогийг тодорхойлон харуулсан. Тэгвэл эдгээр сургалтын хоорондын ялгааны талаар дараагийн хэсэгт товчхон дурдъя. Учир нь “Эдийн засгийн аюулгүй байдлын талаарх сургалт” аль хэсэгт түлхүү хамаарах, суралцагчдын сургалтын үр дүнг тодорхойлох боломж хаана бүрдэхийг авч үзнэ.

Хоёр. Бүрэн дунд боловсролын сургалтад “Эдийн засаг, санхүү, түүний аюулгүй байдал”-ын талаар мэдлэг олгож буй өнөөгийн байдал:

Бүрэн дунд боловсролын түүх, нийгмийн ухааны (түүх, нийгэм судлал, бизнес судлал) сургалтын цөм хөтөлбөрийг 2016 онд БСШУЯ-аас баталж, дараах үе шаттайгаар үндэсний түвшинд хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

- 2016-2017 оны хичээлийн жилд 10 дугаар ангид
- 2017-2018 оны хичээлийн жилээс 11 дүгээр ангид
- 2018-2019 оны хичээлийн жилээс 12 дугаар ангид тус тус хэрэгжүүлнэ.

Ахлах ангийн нийгмийн ухааны (нийгэм судлал, түүх, бизнес судлал) сургалтын цөм хөтөлбөр нь заавал болон сонгон судлах агуулгатай бөгөөд сонгон судлах агуулга нь манай улсын ерөнхий боловсролын сургалтын практикт анх удаа 2016-2017 оны хичээлийн жилээс хэрэгжиж буйгаараа онцлог юм.²⁴

	Заавар судлах	Сонгон гүнзгийрүүлэн судлах
X анги	Түүх Нийгмийн ухаан	Түүх: Монголын түүх Нийгмийн ухаан Бизнес судлал
XI анги	Түүх Нийгмийн ухаан	Түүх (Монголын ба дэлхийн түүх) Нийгмийн ухаан Бизнес судлал
XII анги		Түүх (Монголын ба дэлхийн түүх) Нийгмийн ухаан Бизнес судлал

Түүх, нийгмийн ухааны багш нарын хувьд сургалтын цөм хөтөлбөр (нийгэм судлал, түүх, бизнес судлал)-ийн зорилт, агуулгын уялдаа, ялгааг 10, 11 дүгээр ангийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тодорхойлсон.²⁵ Харин 2018-2019 оны хичээлийн жилийн хувьд 12 дугаар ангид түүх, нийгмийн ухааны хичээлийг заавал судлах хөтөлбөрөөр бус, зөвхөн сонгон судлах хөтөлбөрийн дагуу судлахаар сургалтын төлөвлөгөө батлагдсан. Тиймээс тухайн сургалтын хөтөлбөрийн агуулга нь сурагч бүр өмнө үзсэн агуулга, мэдлэг, чадвараа гүнзгийрүүлэн ахиулах, ирээдүйд эзэмших мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлоход чиглэгдэнэ. Бүрэн дунд боловсролын 12 дугаар ангийн нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрт “бүлэг 1-социологи; бүлэг 2-логик; бүлэг 3-эрх зүй; бүлэг 4-эдийн засгийн онол; бүлэг 5-улс төрийн шинжлэх ухаан; бүлэг 6-олон улсын харилцааны үндэс” гэсэн хичээлийг хамааруулжээ.

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан 6 бүлгийн хичээлийн хүрээнд бүлэг 4 буюу “эдийн засгийн онол” хичээлийг тухайлан авч үзье. Энэхүү бүлгийн зорилго нь:

- Микро болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн мөн чанарыг ойлгож тооцоолол хийж сурах;

²³ Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль. УБ., 2008., Төрийн мэдээлэл №21

²⁴ Бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй – III, Сургалтын гарын авлага. УБ., 2018., 3 дахь тал

²⁵ БСШУС сайдын 2018 оны А/453 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг тооцох, зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнийн хамаарлыг тогтоох, график дээр ажиллах чадвар эзэмших;
- Төрийн макро эдийн засгийн бодлого, эдийн засгийн гадаад бодлогын мөн чанар, зорилгыг тайлбарлах;
- Монгол Улсын гадаад худалдааны алдагдлыг бууруулах, эх орны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд гарах боломжийг илрүүлж хөгжлийн гарцыг өөрийн зүгээс тайлбарлаж үндэслэл гаргах гэж цөм хөтөлбөрт тусгажээ.

Суралцахуйн зорилт	Тулгуур ойлголт
1. Эдийн засгийн ухааны үүсэл хөгжил, эдийн засгийн тогтолцоо	- Хомстол ба сонголт
2. Эдийн засгийн ухааны судлах зүйл, судалгааны аргууд	- Үйлдвэрлэлийн хүчин зүйлс
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл	- Хөдөлмөрийн бүтээмж
4. Хүчин зүйлийн зах зээл	- Борлуулалтын орлого
5. Макро эдийн засгийн үзүүлэлт, тооцох арга	- Үйлдвэрлэлийн зардал, ашиг
6. Нийт эрэлт, нийлүүлэлт	- Зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнэ
7. Төрийн эдийн засгийн бодлого	- Хөдөлмөрийн зах зээл
8. Хөгжлийн эдийн засаг	- Макро эдийн засгийн үзүүлэлтүүд
	- Нийт эрэлт
	- Нийт нийлүүлэлт
	- Төрийн сангийн бодлого
	- Төрийн мөнгөний бодлого
	- Татвар
	- Мөнгө
	- Банк
	- Эдийн засгийн өсөлт
	- Гадаад худалдаа
	- Гадаадын хөрөнгө оруулалт
	- Эдийн засгийн хөгжил

Дээрх хүснэгтээс харахад, эдийн засгийн онол хичээлийн хүрээнд “Эдийн засгийн аюулгүй байдал” гэсэн сэдэв, агуулга байхгүй боловч эдийн засгийн анхан шатны мэдлэг олгож байгаа нь ач холбогдолтой хөтөлбөр болжээ.

Мөн ерөнхий боловсролын сургуульд 2016-2017 оны хичээлийн жилээс “Бизнес судлал” сургалтын цөм хөтөлбөр нь X ангид, 2017-2018 оны хичээлийн жилд XI ангид сонгон судлах хөтөлбөрөөр орж эхэлсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилээс XII ангид сонгон судлах хөтөлбөрөөр хэрэгжиж байна.²⁶

Сурагчид X, XI ангид Хувь хүний болон Өрхийн санхүү, бизнесийн үйл явцыг судалж, амьдралд хэрэгжүүлэх эхний алхмыг хийсэн бол XII ангид Бизнесийн үйл явцыг судалж, амьдралд хэрэгжүүлэх, турших алхмыг хийж байна. Хөтөлбөрийн агуулга нь нийгмийн ухааны хичээлээр олж авсан эдийн засгийн шинжлэх ухааны мэдлэг, ойлголттой холбоотойн зэрэгцээ хувийн, өрхийн болон бизнесийн түвшний мэдлэг ойлголтыг ашиглан бодит жишээ, тохиолдол дээр үндэслэн суралцдаг юм. Өөрөөр хэлбэл, бизнес судлалын хичээлийг сурагч бүр хувь хүний болон өрхийн санхүү, бизнесийн харилцааг судлах явцдаа үүсэж буй асуудлыг илрүүлэх, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, дэвшүүлэх зэрэг идэвхтэй, зорилтот үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.

Бизнес судлалын сургалтын хөтөлбөрийн агуулгыг Мөнгө ба орлого, Зардал ба хуримтлал, Төлөвлөгөө ба төсөв, Эрсдэл ба даатгал, Бизнес, санхүүгийн үйл ажиллагаа, түүний ёс зүй гэсэн үндсэн таван агуулгын хүрээнд боловсруулсан. X ангид хувь хүн өөрийн мөнгөн хөрөнгөө хэрхэн захиран зарцуулах, удирдах, хэмнэх, арвижуулах, хуримтлалаа хэрхэн бий болгох талаар; XI ангид өрхийнхөө мөнгөн хөрөнгийг хэрхэн хамтран захиран зарцуулах, удирдах, хэмнэх, арвижуулах, хуримтлуулахад санаачилгатай идэвхтэй оролцох, өрхийн бизнес эрхлэн хөрөнгө бий болгох, төлөвлөх, төсөвлөх, ашиг алдагдлаа тооцох талаар судалсан. XII ангид бизнесийг (аж ахуйн нэгж буюу компанийн хэмжээнд) танин мэдэх,

²⁶ Бизнес судлал сургалтын хөтөлбөрийг зөвхөн бизнес, эдийн засгийн чиглэлээр цаашид мэргэжил эзэмших сурагчид сонгон судална гэсэн ташаа ойлголт байгаа нь сурагчдын сонголт хийсэн байдлаас ажиглагдаж байгаа нь судалгаанаас харагддаг. Энэхүү хөтөлбөр нь иргэн бүр өдөр тутмын санхүү, бизнесийн үйл явцад бие даан санаачилгатай, хариуцлагатай оролцох анхан шатны мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх зорилготой тул цаашид эзэмших мэргэжил сонголтоос хамааралгүй бүх сурагчид сонгон судлах боломжтой


бизнесийн зорилгоо тодорхойлох, зах зээлийг судлах, дотоод гадаад шинжилгээ хийх, бизнес төлөвлөгөө, төсөв зохиох, бизнесийн үйл явцыг үнэлэх, ашиг алдагдлаа тооцох зэрэг жижиг дунд бизнес эрхлэх, удирдахад шаардагдах анхан шатны мэдлэг, чадварыг эзэмших ба эдгээр мэдлэг, чадвар нь сурагчдын мэргэжил сонголтод бодитой туршлага болох юм.

Гурав. Дээд боловсролын сургалтад “Эдийн засаг, санхүү, түүний аюулгүй байдал”-ын талаар мэдлэг олгож буй байдал:

Энэхүү хэсэгт Монгол Улсын их, дээд сургууль, коллежийн тоо, түүнд суралцагчдын тоог судалж, түүнээс “эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдал, эрх зүй”-н бакалавр, магистрын сургалтыг харьцуулан, сургалтын хөтөлбөрийг судална.


Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2000/2001 оны хичээлийн жилд 172 байсан бол 2005/2006 оны хичээлийн жилээс тогтмол буурсаар 2018/2019 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн тоо 94 болж, 2000/2001 оны хичээлийн жилтэй харьцуулахад 78 (45.3 %) -аар буурсан байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчид 2000/2001 оны хичээлийн жилд 85.0 мянга байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 157.6 мянга болж, 2000/2001 оны хичээлийн жилээс 1.9 дахин өсөж, харин 2008/2009 оны хичээлийн жилээс 2.2 хувиар буурсан байна.

График №1. Нийт их, дээд сургуульд суралцагчид



Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 130.9 мянга (83.0 %) нь бакалавр 22.5 мянга (14.3 %) нь магистр, 4.2 мянга (2.7 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна. Нийт суралцагчдын тоог 2014/2015 оны хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврынх 24.9 мянга (16.0 %) -аар буурсан бол магистрынх 3.4 мянга (18.0 %) -аар, докторынх 828 (24.4 %) -аар тус тус өссөн байна.


График №2. Суралцагчдын мэргэжлийн чиглэл



Нийт суралцагчдыг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд 31.0 мянга (19.7 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлд, 23.3 мянга (14.8 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлд, 22.4 мянга (14.2 %) нь анагаах ухааны чиглэлд, 16.7 мянга (10.6 %) нь

инженерийн чиглэлд, 12.3 мянга (7.8 %) нь хууль, эрх зүйн чиглэлд, 51.9 мянга (32.9 %) нь бусад чиглэлд тус тус суралцаж байна²⁷.

График №3.



Дээрх 3 графикаас харахад, 2018-2019 оны хичээлийн жилд 94 их, дээд сургуульд нийт 157626 суралцагч сурч байгаа нь 1 сургуульд дунджаар 1676 суралцагч суралцаж байгаа бөгөөд 130,0 буюу 83 хувь бакалаврын боловсрол эзэмшиж байна. Мөн эдгээр суралцагчийн дийлэнх буюу 6,7 мянга буюу 16,5 хувь нь бизнес, худалдааны чиглэлээр суралцаж, төгсөж байна.

Монгол Улсад эдийн засаг, санхүүгийн чиглэлийн боловсрол олгож буй СЭЗИС болон МУИС-ийн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгыг товчхон харьцуулан авч үзье.

Сургууль	Хөтөлбөрийн нэр, индекс	Хөтөлбөрийн зорилго	Эдийн засгийн аюулгүй байдлын хичээл байгаа эсэх
МУИС	Эдийн засаг, D031101 Бакалавр	“Эдийн засаг” нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл хөдлөлийг судалж, үнэлэлт, дүгнэлт өгөх, нийгэм-эдийн засгийн хөгжлийн харилцан уялдааг бодлого, хөтөлбөрт тусган боловсруулах, тэдгээрийг үнэлэх, хэрэгжилтийн байдлыг хянах, бодлого, хөтөлбөр боловсруулахад үндэслэл болохуйц судалгаа, шинжилгээний ажлыг бие даан хийж гүйцэтгэх чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна.	Байхгүй
	Санхүү, D041201 Бакалавр	Төрийн санхүүгийн орчин үеийн онол, үзэл баримтлал, хандлага, зарчим, арга зүйг эзэмшин, түүнийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэх	Байхгүй
СЭЗИС	Эдийн засаг Бакалавр	Орчин үеийн технологи, програм хангамж ашиглан нийгэм, эдийн засгийн аливаа асуудлын шалтгаан үр дагаврыг онолын гүнзгий мэдлэгт тулгуурлан, системийн хүрээнд судалж, оновчтой шийдвэр гаргах техник, ур чадвар эзэмшсэн, макро болон микро	Байхгүй

²⁷ Дээд боловсролын үндсэн үзүүлэлтийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ. Үндэсний статистикийн хороо. УБ., 2019 он.

		түвшингийн бүхий л байгууллагад ажиллах чадвартай мэргэжилтэнг бэлтгэнэ.	
	Санхүүгийн менежмент Бакалавр	Санхүүгийн мэргэшүүлэх бакалаврын сургалтын агуулга нь бизнесийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь таниулах, түүний хүрээнд шинжилгээ хийж, хөрөнгө оруулалт, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах, бизнесийн байгууллагын үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт, нөөцийн хуваарилалт, хяналт болон эрсдэлийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбоотой онолын мэдлэг эзэмшүүлэх, тэдгээрийг байгууллагын орчинд хэрэглэх арга, аргачлалыг ашиглах чадвар эзэмшүүлэхэд оршино.	Байхгүй
	Эдийн засаг Магистр	Эдийн засгийн ухааны магистрын хөтөлбөрийн агуулга нь суралцагчдад бизнесийн болон макро эдийн засгийн асуудлыг шинжилж, үнэлэлт, дүгнэлт өгөх, шийдвэр гаргалтын боломжит загваруудыг боловсруулж, бодлогын хувилбар гаргах судалгаа, шинжилгээний ахисан түвшингийн мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.	Байхгүй
	Санхүүгийн менежмент Магистр	Санхүүгийн Менежментийн MBA хөтөлбөрийн үндсэн зорилго нь санхүүгийн менежментийн мэргэжлийн чиглэлийн сургалт, судалгааны ажлыг хөгжүүлж, суралцагсдад цаг хугацааны болон эрсдэлийн хүчин зүйлсийг зөв үнэлэн үр өгөөжийг боломжит хамгийн их хэмжээгээр өсгөх санхүүгийн оновчтой шийдвэрийг гаргах онолын мэдлэг, практик үр чадварыг эзэмшүүлэх явдал юм.	Байхгүй

Дээрх хүснэгтээс харахад, эдийн засаг, санхүүгийн боловсрол олгож буй бакалавр, магистрын сургалтад эдийн засаг, санхүүгийн онолын гүнзгий мэдлэг олгож, аливаа асуудалд үнэлэлт, дүгнэлт хийх, ирээдүйг таамаглах үр чадварыг эзэмшүүлдэг боловч эдийн засгийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой хичээл, сургалт дээрх сургуулиудад агуулгын хувьд байхгүй байна.

Харин 2016 оноос Дотоод хэргийн их сургууль, ХААИС “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын магистрын сургалтын хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү магистрын сургалтын хөтөлбөрөөр эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэж буй хуулийн салбарын албан хаагчид, эдийн засаг, санхүүгийн мэргэжилтэй иргэдийг эдийн засгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэшүүлэх, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажил хийж, түүндээ тулгуурласан шийдвэр гаргах үр чадвартай мэргэжилтэн, шинжээчийг бэлтгэх юм.

Дүгнэлт

Монгол Улсын боловсролын тогтолцоонд эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдлын талаарх талаарх сургалтын өнөөгийн байдлыг харьцуулан судалж, эзлэх байрыг суурийн талаар дараах дүгнэлт хийлээ.

- Бүрэн дунд боловсролын түүх, нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөрийг 2016 онд БСШУЯ-аас баталж, хэрэгжүүлсэн. Энэхүү цөм сургалтын бүлэг хичээлд “Эдийн

засгийн онол” хичээлийг тусгаж оруулсан нь “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын суурь ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой болсон байна.

- Монгол Улсад 2018-2019 оны хичээлийн жилд 94 их, дээд сургуульд нийт 157.626 суралцагч, 1 сургуульд дунджаар 1676 суралцагч суралцаж байгаа бөгөөд 130.000 буюу 83 хувь бакалаврын боловсрол эзэмшиж байна. Эдгээр суралцагчийн 6,7 мянга буюу 16,5 хувь нь бизнес, худалдааны чиглэлээр суралцаж, төгсөж байна. Монгол Улсад эдийн засаг, санхүүгийн чиглэлийн боловсрол олгож буй СЭЗИС, МУИС-ийн бакалавр, магистрын сургалтын төлөвлөгөөг харьцуулан үзэхэд, эдийн засгийн аюулгүй байдлын талаарх хичээл тусгагдаагүй байна.
- Дотоод хэргийн их сургууль, ХААИС-тай хамтран “Эдийн засгийн аюулгүй байдал судлал”-ын магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрөөр эдийн засгийн аюулгүй байдлын талаар шинэ мэдлэг эзэмших, энэ чиглэлээр дүн шинжилгээ хийж, түүнд тулгуурлан шийдвэр гаргах, санал дэвшүүлэх, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх, аюулгүй байдлыг хангах арга зүйг бүтээлчээр ашиглах ур чадвар эзэмшүүлэхэд чиглэж байгаа бөгөөд Монгол Улсад энэ чиглэлийн анхдагч хөтөлбөр юм.

Монгол Улсад эдийн засгийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн албан хаагч, мэргэжилтэн бэлтгэж буй боловсрол олгох сургалтын үйл ажиллагааг цогц байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй. Одоогийн хэрэгжүүлж буй магистрын хөтөлбөрийн бакалаврын түвшинд сургалтыг нэвтрүүлэх, сургалт, дадлагын төв, багшлах бүрэлдэхүүн, материаллаг орчны хангалтыг сайжруулах, сургагч багш нарыг бэлтгэх, чадавхжуулах ажлыг бодлогын түвшинд зохион байгуулж, гадаад, дотоодод туршлага судлах зэрэг ажлыг тасралтгүй явуулах нь зүйн хэрэг юм.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. Төрийн мэдээлэл №1
- Боловсролын тухай хууль. 2002 он, Төрийн мэдээлэл №19
- Дээд боловсролын тухай хууль. УБ., Төрийн мэдээлэл 2002 он, №19
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай. УБ., 2009 он, Төрийн мэдээлэл №10
- Бага дунд боловсролын тухай хууль. УБ., 2002 он, Төрийн мэдээлэл №19
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль. УБ., 2008 он, Төрийн мэдээлэл №21
- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол

Хоёр. Ном, гарын авлага, эмхэтгэл

- Монгол Улсын дунд хугацааны (2018-2025) хөгжлийн хүрээ (тайлан IV) УБ., 2018 он. <http://nda.gov.mn/>
- Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл –II УБ., 2014
- Бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй – III, Сургалтын гарын авлага. УБ., 2018
- Дээд боловсролын үндсэн үзүүлэлтийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ. Үндэсний статистикийн хороо. УБ., 2019

ШИНЭ ТИТЭМ ВИРУС БА БИОТЕРРОРИЗМ

*Г.Мөнгөншагай
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн
тэнхимийн эрхлэгч, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Шинэ титэм вирусын гарал үүслийн талаарх судлаачдын байр суурь, биотерроризм, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлын талаар товч авч үзсэн.

Түлхүүр үг: Шинэ титэм вирус (nCoV-2019) biosecurity, bioweapon, bioterrorism

Корона буюу Титэм вирусийн тархалт анх 2020 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр БНХАУ-ын Хубэй мужийн Ухан хотод голомтолсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргаж буй шинэ корона вирусийн талаарх өдөр тутмын мэдээнээс харахад, 2020 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар дэлхийн нийтийн 216 улсын 4.525.497 хүн халдварлаж, нийт 307.395 хүн амь насаа алдсан²⁸ бол БНХАУ-д 84.484 хүн халдварлаж, нийт 4645 хүн амь насаа алдсан²⁹ байна. Манай улсын тухайд 135 тохиолдол бүртгэгдсэн нь бүгд гадаад улсаас зөөвөрлөгдөн ирсэн.³⁰

Олон Улсын аюулгүй байдлын судлаачид “Ковид-19” нь биологийн зэвсэг мөн эсэхэд хариулт нэхсэн мэтгэлцээн өрнүүлсээр байгаа бол их гүрнүүд тухайлбал, АНУ, БНХАУ-ын тухайд хэдийнээ нэг нэгийгээ энэхүү вирусийн тархалтад буруутгасаар байна. АНУ-ын зүгээс БНХАУ-ыг биологийн лабораторид “Ковид-19” вирусийг бүтээж, тараасан гэж буруутгаж байгаа бол манай өмнөд хөршийн зүгээс АНУ-ын Цэргийн лабораторыг буруутгаж байгаа хэдий ч одоог хүртэл nCoV-2019 нь биологийн зэвсэг болохыг баталсан нотлох баримт байхгүй байна.

Нэр томьёоны хувьд Коронавирус гэдэг нэр нь латин хэлний Corona буюу титэм, цагираг гэсэн утгатай үгнээс үүссэн. Электрон микроскопоор харахад вирусын халдвар цагирган, титэм хэлбэртэй харагддаг тул титэм гэж нэрлэсэн.

Титэм вирус нь 1960 онд анх энгийн ханиадтай хүний хамрын самсаанаас олдож, хэд хэдэн хэв шинжид хуваагддаг байна. Сүүлийн 20 жилд олныг хамарсан 3 удаагийн дэгдэлтүүд тус вирусийн өөр өөр хэв шинжээр үүсгэгджээ. Ихэнхдээ ханиад, томуу хэлбэрээр эхэлж уушгины хатгалгаа болж хүндэрдэг байна. Мал, амьтны гаралтай тухайн вирус элбэг байдаг бөгөөд саяхныг хүртэл зөвхөн мал амьтнаас хүнд халдварладаг гэж үзэж байсан нь үгүйсгэгдэж хүнээс хүнд, амьсгал, агаар дусал, ахуйн замаар халддаг болох нь тогтоогдоод байна.

Анх 2002 онд SARS Co-V (Severe acute respiratory syndrom), 2012 онд Дундад Азид MERS Co-V (Middle east respiratory syndrom) гэж нэрлэгдсэн түргэн тархац бүхий амьсгалын замын хурц халдварт өвчний вирусээр олон хүн амь насаа алдсан тохиолдлуудыг олон судалгаанаас дэлгэрүүлж харж болно. Одоогоор хүний коронавирусын 7 төрлийг³¹ тогтоосон байна. Үүнд: Human coronavirus 229E, Human coronavirus OC43, SARS-CoV, Human coronavirus NL63 (HCoV-NL63, New Haven coronavirus), Human coronavirus HKU1, Middle East respiratory syndrome coronavirus (MERS-CoV), previously known as Novel coronavirus 2012 and - HCoV-EMC, Wuhan coronavirus (2019-nCoV)³².

Шинэ төрлийн корона вирус нь бүтэц, шинж тэмдэг, онцлогийн хувьд шинэ хэлбэртэй боловч, 2002 оны SARS, 2012 оны MERS зэрэг амьсгалын замын хурц халдварт өвчний шинж тэмдэгтэй төсөөтэй.

Энэхүү 3 дахь дэгдэлт нь 2020 оны 1 дүгээр сард БНХАУ-ын Хубэй мужийн Ухан хотод тархаж, албан ёсоор “2019-nCoV” гэж нэрлэгдсэн хэдий ч олон улсын судлаач нарын зүгээс уг вирус 2019 оны сүүлээр тархаж эхэлснийг нийтэд мэдээлэлгүй нуун дарагдуулсан, олон улсад цаг хугацаа алдаж мэдээлсэн гэж БНХАУ-ын Засгийн газрыг буруутгаж байна.

БНХАУ-д голомтолсон шинэ төрлийн Корона вирус нь илүү хүнд хэлбэрийнх бөгөөд илрэн гарч буй үндсэн шинж тэмдэг нь 14 хоног хүртэл нууц үедээ байж ханиалгах, хоолой эрвэгнэх, бага зэрэг халуурах зэрэг шинжүүдээр илэрч улмаар богино хугацаанд амьсгалын

²⁸ World Health Organization (2020) Press Release, May 17, 2020.

²⁹ <https://covid19.who.int/region/wpro/country/cn>

³⁰ ЭМЯ-ны “Covid-19” 2020.05.17-ны өдрийн мэдээ,

³¹ <https://www.vdh.virginia.gov/epidemiology/epidemiology-fact-sheets/coronaviruses/>

³² <https://www.vdh.virginia.gov/epidemiology/epidemiology-fact-sheets/coronaviruses/>

дутагдлаар хүндрэх аюултай байсан бол сүүлийн үеийн мэдээллээс харахад, тухайн улс орны байгаль цаг агаарын нөхцөл байдал, газар зүйн байрлалаас шалтгаалж харилцан адилгүй шинж тэмдэг илэрч байна.

2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар шинэ корона вирус нь дэлхийн 5 бүсийн 25 улсад тархаж нийт 6065 хүн халдварлаж 138 хүн ам насаа алдсан тул ДЭМБ-ын зүгээс уг вирусын халдварыг “Олон улсын нийгмийн эрүүл мэндийн онц ноцтой байдал” хэмээн зарласан бөгөөд манай улсыг эрсдэлийн “Маш өндөр” зэрэгт шилжүүлсэн³³ бол 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар шинэ коронавирусын тархалт нь дэлхийн 114 улсыг хамарч, 123,000 орчим хүнийг өвчлүүлж, 4578 хүн нас барж, энэ тоо хурдацтай нэмэгдэх хандлагатай байсан тул албан ёсоор “Цар тахал” ангилалд оруулснаа зарласан³⁴ нь Covid-19 вирусээр халдварладаг өвчин нь дэлхий нийтийн аюул болсныг хүлээн зөвшөөрсөн.

БНХАУ-ын “nCoV- 2019” голомтолсон Хубэй мужийн Ухань хотын тухайд цухас дурдахад манай урд хөршийн бизнес, олон улсын худалдаа, тээвэр зууч, аялал жуулчлал хөгжсөн эдийн засгийн тулгуур болсон мужийн нийслэл метрополис хот юм.

Ухань хот нь Төв Хятадын хүн амын хамгийн нягт суурьшсан, зүүн хэсгээр Жиан Хань, Янг Зи мөрөн болон Хан мөрний уулзвар дээр оршдог. Ву Чанг, Хан Коу, Хань Янг гэсэн гурван хотуудаас бүрддэг, Төв Хятадын 9 мужийг холбосон олон арван төмөр зам, авто зам болон хурдны замууд энэ хотоор дайран өнгөрдөг онцгой байршилтай.

Ухань нь Төв Хятадын засаг захиргаа, эдийн засаг, санхүү, соёл, боловсрол, зам тээврийн төв хэмээн хүлээн зөвшөөрөгдөж чадсанаас гадна Бээжин, Шанхай хотын араас орох Хятадын шинжлэх ухаан, боловсролын гурван төв хотуудын нэг. 2011 онд дэлхийн хамгийн их элсэгч оюутантай хотоор нэрлэгдэж байсан дэлхийн өнцөг булан бүрээс нэг хүсэл мөрөөдөл тээсэн оюутан залуусын төв болохыг бататгана. Тус хот нь Уханий Их Сургууль, Төв Хятадын Технологийн Их Сургууль зэрэг 85 орчим дээд боловсролын байгууллагуудтай. Шинжлэх ухаан болон боловсролын салбарын үзүүлэлтээрээ бүх Хятад даяараа 3 дугаар байранд жагсдаг байна. Үүнд: Үндэсний хөгжлийн 3 бүс, шинжлэх ухаан болон боловсролын хөгжлийн 4 хүрээлэн, түүнчлэн, нэлээдгүй олон хэвлэлийн инкубатор, 350 гаруй судалгаа, шинжилгээний төвүүдтэй, 1470 өндөр технологи хэвлэлийн үйлдвэр, мөн 400.000 давсан мэргэжилтэн шинжээч, техникчидтэй. Үндэсний 36 их, дээд сургуулийн 8 нь тус хотод байдаг байна.³⁵

Титэм вирусийн дэгдэлтээс улбаалан тухайн хотод тавьсан хөл хорио БНХАУ-ын эдийн засагт сөргөөр нөлөөлж, ялангуяа аялал жуулчлал, тээвэр зууч, худалдааны салбарууд ихээхэн хохирол амссан. Дэлхийн өнцөг булан бүрээс цагаан сарын баяраа тэмдэглэхээр ирсэн хэдэн арван сая иргэд гацаанд орж, улс орнууд ч Ухань хот болон БНХАУ-ын бусад хотоос ирэх зорчигчдыг хүлээн авахаас татгалзаж агаарын болон хуурай замын хилийн боомтоо хааж эхэлсэн.

Титэм вирусийг үүсгэгч нянгын эх сурвалж одоог хүртэл тодорхойгүй, зарим нэг судлаачдын зүгээс Ухань хотод байрлах далайн болон амьтны гаралтай түүхий эдийн худалдааны төвөөс үүсэлтэй гэдэг битүүхэн мессэжийг олон нийтэд тарааж байгаа бол эсрэгээрээ их гүрнүүдийн хоорондын геополитикийн санаархал, бусад улс орныг эдийн засгийн хямралд оруулж, хараат байдалд оруулахаар хийж буй санаатай био-террорист ажиллагаа ч байж болзошгүй гэсэн байр суурийг олон улсын судлаач, шинжээч нар илэрхийлсээр байна. Олон төрлийн сэжиг таамаг дэвшүүлж буй боловч өнөөдрийг хүртэл хугацаанд титэм вирусны үүсэл гарал нь тодорхой бус, үндэслэл бүхий баримт, нотолгоо тогтоогдохгүй байгаа нь биологийн зэвсэг биш байгаадаа гэх хардлагыг нэмэгдүүлж байгаа хэдий ч эрх зүйн хувьд боломжгүй.

Дэлхийн улс орнууд биологийн зэвсгийг хэрэглэх зорилго нь олон нийтийг айдаст автуулах, цаашилбал, зэвсэгт мөргөлдөөн, дайн тулаанд ялалт байгуулахад хими, биологийн зэвсгийг хүн төрөлхтний эсрэг ашиглаж хамгийн ноцтой хор хохирлыг учруулж байсан. Иймд олон улсын хамтын нийгэмлэгээс энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор “Биологийн зэвсгийн эсрэг” Женевийн конвенцийг санаачилсан нь томоохон дэвшил хэмээн үзэж болох хэдий ч хүчирхэг гүрнүүдийн зүгээс энэ төрлийн зэвсгийг хязгаарлагдмал хүрээнд янз бүрийн зорилгоор нууцаар ашиглах, хэрэглэх тохиолдлууд гарсаар байна. Иймд уг конвенцийн үйлчлэх хүрээ, зохицуулж буй харилцааг тодотгож, 1972 онд “Биологийн зэвсгийг хориглох тухай” (Biological Weapon Convention-BWC) Женевийн конвенцийг санаачилсан

³³ World Health Organization (2020) Press Release, Jan 30, 2020.

³⁴ World Health Organization (2020) Press Release, March 11, 2020.

³⁵ Ухань хот дахь Монгол Оюутны Холбоо, Цахим сайт, 2018 он

бөгөөд өнөөдрийн байдлаар дэлхийн 183 улс нэгдээд байна. Монгол Улсын хувьд тус конвенц 1972 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр нэгдэн орсон.³⁶

Уг конвенц нь улс орнуудын нууц далд, хялбар арга, бага зардлаар олон нийтэд халдах чадвартай үй олноор устгах хими, биологийн зэвсэг бүтээх зорилгоор төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга байгууламж бий болгох, мэргэшсэн чадварлаг эрдэмтдийг ажиллуулах, биологийн лабораториос ховор төрлийн нян, эс, вирус хулгайлах, түүнийг үржүүлэх, хөгжүүлэх, бүтээх, үйлдвэрлэх үйлдлүүдэд хязгаарлалт тогтоож өгсөн олон улсын шинжтэй томоохон эрх зүйн баримт бичиг мөн.

Олон улсын хэмжээнд Биологийн зэвсгийн эсрэг конвенцийг 1975 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс мөрдөж эхэлж,³⁷ БНХАУ 1985 онд нэгдэн орсон³⁸ боловч үргэлж биологи, химийн зэвсгийн эсрэг программыг эсэргүүцсэн байр суурь илэрхийлсээр ирсэн тухай зарим судлаачид үздэг. Шинэ төрлийн “nCoV- 2019” вирус голомтолсон Ухань хотод Уханы вирус судлалын хүрээлэн, Биологийн бүтээгдэхүүний хүрээлэн байршдаг нь олон улсын судлаачдын зүгээс тухайн хүрээлэнгээс алдагдсан байх магадлалтай гэдэг байр суурийг хүчтэй илэрхийлсээр байна. Тухайлбал, “Биологийн зэвсгийг хориглох тухай” (Biological Weapon Convention-BWC) Женевийн конвенцийн дагуу олон улсын статус бүхий хяналтад байдаг 8 том хими, биологийн хүрээлэнгийн нэг Ухань хотод байрлах Биологийн бараа бүтээгдэхүүний хүрээлэн (Wuhan Institute of Biological Products) юм³⁹. Израиль улсын эрх баригчид nCoV-2019 нь БНХАУ-ын Ухань хотод байрлах вируслогийн лабораториос эх сурвалжтай, тус хүрээлэн нь үхлийн аюултай хорт вирусийн хөтөлбөр дээр ажиллаж буй тухай мэдээлсэн радиогийн нэвтрүүлгийг үндэслэл болгосон байна.

Мөн Израиль улсын Цэргийн тагнуулын Биологи, химийн бодисын тэмцлийн ахлах шинжээч, биологич, Данни Шохам: Ухань хотын Вируслогийн хүрээлэн нь Бээжингийн биологийн зэвсгийг хамаардаг хөтөлбөртэй холбоотой гэдгийг илэрхийлсэн бол АНУ-ын Массачусетсийн технологийн их сургуулийн аюулгүй байдлын мэргэжилтэн Випин Наранг хэлэхдээ миний харж байгаагаар, nCoV-2019 нь биологийн зэвсэг гэх ямар ч үндэслэл бүхий баримт байхгүй, биологийн зэвсэг гэж тарааж байгаа нь худлаа ташаа мэдээлэл, маш хариуцлагагүй үйлдэл гэдгийг онцолсон байна.⁴⁰

Эсрэгээрээ ОХУ-ын судлаачид америкчууд ашиг олох, мөн БНХАУ-ын эдийн засгийг унагах зорилгоор nCoV-2019-ийг Ухань хотод үйлдвэрлэж тараасан гэх байр суурийг хүчтэй илэрхийлсээр байна.⁴¹ ОХУ-ын мэдээллийн Новости агентлагийн нийтэлсэн, НҮБ-ын Хими, биологын зэвсгийн комиссын гишүүнээр ажиллаж байсан Никулины нийтлэлд: nCoV-2019 нь АНУ-ын корпорациудын санхүүжилтээр хийгдсэн халдварт өвчин. Шинэ төрлийн өвчин тарааж мөнгө олох үндсэн зорилготой гэж тайлбарласан байна. Учир нь nCoV-2019-ыг бүтээх хүчин чадал бүхий лаборатори Америкаас өөр байхгүй. АНУ-нь 400 гаруй Цэргийн биологийн лабораторитой ба дэлхийн олон оронд байрладгийн нэг нь БНХАУ-д байгаа нь⁴² хардах үндэслэл болоод байна.

Манай улсын тухайд nCoV-2019 нь биологийн зэвсэг мөн эсэхэд үнэлэлт дүгнэлт, ач холбогдол өгөхөөс илүүтэйгээр биологийн зэвсгээр үйлдэгдэх бодит аюул занал учирсан үед бид бэлэн үү гэдэгт хариулт хайх цаг болсныг гадаад, дотоод нөхцөл байдлаас харж болно.

Био-терроризм нь улс үндэстний аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт, эв нэгдэл, энх-тайванд ноцтой хор уршиг учруулдаг бодит халдлага байдаг. Биологийн зэвсэг, түүний хэрэглээ, түүгээр үйлдэгдсэн био-терроризмын аюул занал нь бусад терроризмын хэлбэрээс илүү ноцтой хор хохирол, сөрөг үр дагавар, эрсдэл учруулдаг онцлогтой. Мөн биологи, химийн бодис, бактери зэрэг нь хоруу чанар, төлөв байдлаа богино хугацаанд өөрчилж байдаг нь түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд ихээхэн хүндрэл, бэрхшээл учруулдаг онцлогтой. Ихэнхдээ түүний аюул занал, хор уршгийг урьдчилан тооцох боломжгүй байдаг боловч нөхцөл байдлыг бодитоор тооцож, тодорхойлж, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг цаг

³⁶ The biological weapons convention an introduction, 2017, United Nations Office at Geneva

³⁷ <https://www.un.org/disarmament/wmd/bio/>

³⁸

[https://www.unog.ch/80256EE600585943/\(httpPages\)/04FBBDD6315AC720C1257180004B1B2F?OpenDocument](https://www.unog.ch/80256EE600585943/(httpPages)/04FBBDD6315AC720C1257180004B1B2F?OpenDocument)

³⁹ Journal of Bioterrorism and Biodefense, Coronavirus (nCov-2019), March 10, 2020

⁴⁰ Hua J, Stanway D (2020) World News, Feb 9, 2020.

⁴¹ Ebb W (2020) Many Russians think American created Coronavirus & the reasons may shock you., Dim sum Daily Hong Kong, Jan 30, 2020

⁴² Nikulin I (2020) Russian media spew US Coronavirus conspiracies. RIA Novosti, Jan 27, 2020.

алдалгүй, өндөр төвшинд зохион байгуулах нь үүсч болох эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Аливаа улс орны хувьд био аюулгүй байдлын хангах үүднээс дараах алхмуудыг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1.Олон улсын террорист байгууллага, этгээдийн зүгээс хими, биологийн зэвсгийг орчин үеийн техник, технологийн хөгжлийг ашиглан хүн амын эсрэг хүчирхийлэл үйлдэх санаа зорилго эрчимтэй ихсэж байна. Хүн ам олноор төвлөрдөг олон нийтийн худалдаа, үзвэр, үйлчилгээний газар, барилга байгууламж, объектод химийн хорт хий цацах, хүн, мал, ан амьтан, ургамалд гоц халдварт өвчин тараах, шуудан илгээмжид хорт бодис шингээх зэргээр халдлагын арга, хэлбэрүүд хувьсан өөрчлөгдсөөр байна. Иймд цаг үеийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн арга, хэлбэрт нэн даруй шилжих, энэ төрлийн аюул заналтай тэмцэхийн тулд эрх зүйн орчинг боловсронгуй болгох, улсын хэмжээний энэ төрлийн тэмцлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын болон төлөвлөлт-зохион байгуулалтын арга такикийг боловсруулах;

2.Биологийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй террорист халдлагын үед түүнийг илрүүлэх, саармагжуулах, таслан зогсоох, аюулгүй болгох, устгах чиг үүрэг бүхий тусгайлсан чиг үүрэг бүхий нэгж байгуулж, мэргэшсэн баг бүрдүүлэх, цаашид, биологийн аюулгүй байдал, био-терроризмын чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг тогтмол бэлтгэж, мэргэшүүлэх;

3.Олон улсын хими, биологийн аюулгүй байдлын зэрэглэл бүхий эм, бэлдмэл, өвчин судлалын тусгай лаборатори байгуулах;

4.Биологийн аюулгүй байдлын хангах, учирч болох хор аюулыг саармагжуулахад чиглэгдсэн Үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

5.Биологийн аюулгүй байдлыг хангах, террорист халдлага болон хүн, малын халдварт өвчний үед төрийн байгууллагуудын чиг үүрэг, хийж гүйцэтгэх ажил, эрх хэмжээ, оролцоог тодорхой болгох;

6.Халдварт өвчний тархалтын үед иргэдийн ухамсар, үүрэг хариуцлага, эрх бүхий байгууллагаас тогтоосон заавар, зөвлөмж, журмыг баримтлах нь вирусийн тархалтыг саармагжуулах, учирч болох хор уршгийг бууруулахад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Үр дүн нь хэн нэгний хүчин чармайлтаас дан ганц шалтгаалахгүй гагцхүү нийтийн хамтын хүчин чармайлтаар хэмжигддэг байна. Мөн халдварт өвчний тархалтын үед тухайн орны улс төрийн болон эрүүл мэнд, эдийн засаг, худалдаа үйлчилгээний салбарын хэвийн тогтвортой байдал алдагдаж, ноцтой хор уршиг учрах нөхцөлүүд бий болдогос гадна иргэдийн ухамсар, ёс зүй сөргөөр өөрчлөгдөж, сэтгэл санааны хямралд орж, буруу ташаа, ор үндэсгүй, худал мэдээлэлд амархан автаж, улмаар нийтийг хамарсан эмх замбараагүй байдал руу хөтөлдөг тул цар тахлын үеийн нөхцөл байдлын талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг түгээх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалт, дадлагыг шат дараалан зохион байгуулах.

---oOo---

ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

А.Номундарь
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
322 дугаар дамжааны сонсогч

Товч агуулга: Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах нь нийгмийн болон хүний хөгжлийг дэмжих нэг хэлбэр юм. Иймд нийгмийн тулгамдсан асуудал болоод байгаа гэр бүлийн хүчирхийллээс дэлхийн зарим улсууд боловсролын тогтолцоонд тулгуурлан урьдчилан сэргийлж буй туршлагын талаар дурдсан.

Түлхүүр үг: Гэр бүл, хүүхэд, хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, боловсрол, боловсролын тогтолцоо, нөлөө.

Оршил

Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах нь нийгмийн болон хүний хөгжлийг дэмжих нэг хэлбэр юм. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн бүтцэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эзлэх хувийн жин өссөн үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч болон үйлдэгчид нь зөвхөн эцэг, эх бус харгалзан дэмжигч, асран хамгаалагч, хамтран амьдрагч байхаар заасан нь халамж, асрамжийн төвүүдэд амьдардаг хүүхдүүд ч гэр бүлийн хүчирхийлэлд өртөх боломжтой болохыг харуулж байна. Одоогийн байдлаар Монгол Улсад 36 асрамжийн газарт 1234 хүүхэд амьдарч байгаа бөгөөд далд хэлбэрээр гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг байж болзошгүй юм.⁴³

Мөн үүний зэрэгцээ үр хүүхдээ огт хайхардаггүй, олон хоногоор хараа хяналтгүй, хоолтой хоолгүй хаяад явчихдаг хатуу сэтгэлтэй эцэг эхчүүд их байдаг. Үүнээс улбаалж хүүхдүүд үл хайхрагдах, тэнүүчлэл, гуйланчлалд орох, гэмт хэрэгт холбогдох, гэмт хэргийн золиос болох тохиолдлууд байдаг. 2016 онд 838 гэмт хэрэгт 1194 хүүхэд холбогдсоноос 470 хүүхдэд холбогдох хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн байна.⁴⁴

Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт, хамрах хүрээ

Гэр бүлийн тухай хуульд “Гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ” гэж заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд (гэр бүлийн хамрах хүрээ) энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг тодорхойлсон.

Гэр бүлийн хүчирхийллийн онцлог шинж:

- Хэн нэгэн хүний ганц удаагийн, санамсаргүй, тохиолдлын зан үйл биш
- Тодорхой зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл төдийгүй бусдыг зовоон тарчилгах нэг хэлбэр
- Гэр бүлийн хүчирхийлэл нь санаатай үйлдэгддэг, байнгын тогтвортой үргэлжилдэг тэгш бус харилцаа
- Гэр бүлийн хүчирхийлэл хүний хувийн амьдрал, хувийн нууцтай холбоотой эмзэг асуудал
- Гэр бүлийн хүчирхийлэл нь дахин давтагдаж, даамжирч, далд үйлдэгддэг хэрэг юм.⁴⁵

⁴³ “Хүүхдийн эрх ба хамгаалал” үндэсний судалгаа 2016 он

⁴⁴ Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016 он

⁴⁵ Хүний эрхийн цуврал нийтлэл 2012 он. 27 дахь тал

Судлаачдын үзсэнээр, гэр бүлийн хүчирхийлэл нь нуугдмал хэлбэрээр үйлдэгдэх хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

- Гэр бүл дэх хүчирхийлэл нь хувь хүний болон гэр бүлийн нэр төртэй холбоотой эмзэг асуудал учир нуугдмал үйлдэгддэг учраас илрүүлэх үйл явц нь төвөгтэй байдаг.
- Ойр дотны хүнийхээ эсрэг хүчирхийлэл үйлддэг хүмүүс хохирогчдыг хянаж чаддаг бөгөөд хуулийн байгууллагын ажилтан тухайлбал, цагдаагийн албан хаагч хөндлөнгөөс оролцоход энэ хяналтаа ашиглан хүчирхийллийг илчлэх гэсэн хүсэл, зоригийг нь мохоож, хүчирхийлэл нь давтагдан үргэлжилж, улам даамжирсаар байдаг.
- Асуудлыг хүчирхийллийн аргаар үйлдэж сурсан зан үйлээ өөрчлөхийг хүчирхийлэгч хүсээгүй цагт гэр бүлийн хүчирхийлэл байнга давтагдаж байдаг ба хохирогчийн аюулгүй байдлыг хангах зохистой арга хэмжээ аваагүй, хуулийн зохистой зохицуулалт хэрэглэж чадаагүй тохиолдолд хэрэг хэзээ ч илэрч, шийдвэрлэгддэггүй.

Гэр бүл дэх хүүхдийн хүчирхийллийн ойлголт, хэлбэр

Хүүхэд хамгааллын тухай хуульд “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ гэж заасан.

Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийг хохирогчийг эрхшээлдээ оруулахын тулд хүүхдийг ашиглах гэдэг бөгөөд сүүлийн үед судлаачид насанд хүрсэн хохирогчийг хяналтандаа байлгахын тулд хүүхдийг ашиглах гэсэн шинэ төрлийн хүчирхийллийн хэлбэрийг онцлох болсон. Энэ нь хүүхдийг зодох, бусад хэлбэрээр хүчирхийлэх, хүчирхийлэхээр заналхийлэх, гэр бүлийн харилцаан дахь зөрчилдөө хүүхдээ хохирогчийн эсрэг турхирах, хүүхдээ хохирогчийн эсрэг хүч хэрэглэхийг хатгах зэргээр илэрнэ.

Хүүхдийн хүчирхийллийн хэлбэр:

1. **Бие махбодийн хүчирхийлэл:** Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед халдах, эсвэл нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүй.
2. **Бэлгийн хүчирхийлэл:** Хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан, бэлгийн болон садар самуун үйлдэлд уруу татсан, шаардсан, эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүй.
3. **Сэтгэл санааны хүчирхийлэл:** Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд өөрийн давуу байдлаа ашиглан үг хэл, үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтад оруулсныг, эсвэл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхүй.
4. **Үл хайхрах:** Хэн нэгэн этгээд хүүхдийн бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж, аюулгүй байдлыг хангах зэрэг суурь хэрэгцээг гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдэхүй.

Сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар, гэр бүлд хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдэхэд хүмүүсийн буруу ташаа ойлголт сөргөөр нөлөөлдөг бөгөөд жишээ нь, насанд хүрсэн 7 хүн тутмын 4 нь хүүхдийн бүхий л үйл хөдөлгөөнийг хянаж хүүхдээ загнаж, зодох хэрэгтэй, хүүхэд эцэг, эхийнхээ үгнээс зөрвөл зодож, загнах нь тэдний л сайн сайхны төлөө зэрэг өөрсдийн хүмүүжлийн арга гэж ташаа ойлгох нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг хүлээн зөвшөөрсөн байдлыг улам баталгаажуулж байна.⁴⁶

Монгол Улсад гэр бүл дэх хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдэж буй нөхцөл байдал

Монгол Улсад хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн дийлэнх буюу 90 орчим хувь нь гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байна. Өөрөөр хэлбэл, эцэг, эхчүүд болон гэр бүлийн гишүүдийн таарамжгүй харьцаа, гэр бүлийн маргаанаас улбаалж хүүхэд хүчирхийлэлд өртөн, сэтгэл санаа, эрүүл мэндээрээ хохирох тохиолдол нэмэгдсээр байна.⁴⁷

⁴⁶ Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл. 2016 он

⁴⁷ Хүүхдийн төлөө үндэсний газрын хүүхэд хамгаалал үйлчилгээний газрын дарга Б.Жавзанхүүтэй хийсэн ярилцлага 2013 он

Хүний эрхийн үндэсний комисс, “Гүүд нейборс” олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран 2016 онд “Хүүхдийн эрх ба хамгаалал” үндэсний хэмжээний судалгаа хийжээ. Асуулгад оролцсон нийт хүүхдийн 17.2 хувь нь хүчирхийлэлд өртөж байгаагүй гэсэн бол 82.8 хувь нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртөж байсан гэж хариулсан байна. Тэдний 62 хувь нь үг хэлээр доромжлох, 22.9 хувь нь айлган сүрдүүлэх, 17.1 хувь нь ялгаварлан гадуурхах, 14.7 хувь нь бэлгийн шинжтэй дарамт, халдлага үйлдэх, 5.9 хувь нь хүнд нөхцөлд ажил хийлгэх, 4.8 хувь нь гэрээсээ хөөх зэрэг хүчирхийлэлд өртөж байснаа дурьджээ.⁴⁸ Эндээс үзвэл, асуулгад хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртсөн, түүнээс 2 хүүхэд тутмын 1 нь бие махбодын хүчирхийлэлд, 4 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд, 3 хүүхэд тутмын 1 нь үл хайхрах хүчирхийлэлд, 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн шинжтэй дарамт, халдлагад өртөж байжээ. Давтамжийн хувьд хүүхдүүд бие махбодын хүчирхийлэлд их өртдөг бөгөөд энэ нь ихэвчлэн гэр бүлийн орчинд үйлдэгдсэн байна.

Асуулгад хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь амьдарч буй орчноо аюулгүй, хамгаалагдсан орчин гэж үздэггүй бөгөөд тэдний 38.3 хувь нь сургуулийн орчноос, 45.3 хувь нь гэр бүлийн орчноос 16.4 хувь нь бусдаас хамгийн их айдаг гэж хариулсан байна. Харин хүүхдийн эрхийг зөрчиж, хүчирхийлэл үйлдэгч гол этгээдээр хойд ээж, аав 38.6 хувь, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч 12.4 хувь нь тус тус нэрлэсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн иргэдийн 50 орчим хувь нь бүрэн дунд боловсролтой, 30 гаруй хувь нь дээд боловсролтой, боловсролгүй иргэн үлдсэн хувийг нь эзэлдэг. Эндэс үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг нь хувь хүний боловсрол, ухамсартай шууд холбоотой бөгөөд хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох явдал чухал юм.

Боловсролоор дамжуулан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж буй гадаадын зарим улсын туршлага

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад гэр бүлийн боловсролыг дараах байдлаар олгож байна. Үүнд:

1. Албан ёсны суурь боловсролын тогтолцоогоор дамжуулж:

- Бага ангиас нь эхлэн дунд сургууль төгсөх хүртэл нь шаталсан сургалтаар;
- Дунд сургуульд эрүүл мэндийн боловсрол дээр нь тулгуурлан олгох;
- Өсвөр наснаас нь үерхэл, нөхөрлөл, бэлгийн боловсрол дээр нь тулгуурлан олгох.

2. Албан бус сургалтаар дамжуулж:

- Уламжлалт соёл, ёс заншил дээр тулгуурлан олгох;
- Хүн амын бүлгүүдэд чиглэсэн сургалтуудаар дамжуулж гэр бүлийн боловсрол олгох.

Албан ёсны суурь боловсролын тогтолцоогоор дамжуулж гэр бүлийн боловсрол олгодог гадаад улс орнуудаас дурдвал:

Англи улс: Тус улсад 7-16 насны дунд сургуулийн сурагчдад 4 үе шаттайгаар “Гэр бүлийн боловсрол” олгох хичээлийг Гэр бүл төлөвлөлтийн холбоо нь заадаг.

Нэгдүгээр үе шат: 7-11 насны хүүхдүүдэд хүмүүсийн хоорондын ялгаатай болон төсөөтэй зүйлийг ялгаж салгах, гэр бүл, найз нөхдөө хамгаалах аргуудыг тайлбарлаж сургана. Сэтгэлд нь таалагддаг найздаа сэтгэлээ илчлэн хэлэх болон хүнд бэрхшээл туулж буй гэр бүлдээ санаа тавих ёстой болохыг мэдүүлж дадлага хийлгэдэг.

Хоёрдугаар үе шат: 11-13 насны хүүхдүүдэд шилжилтийн насанд очих үед нь бие махбод болон сэтгэл зүйд ямар өөрчлөлт гардаг талаар мэдүүлнэ. Сурагчдад эрүүл амьдрах аргыг сонгох, сэтгэл зүйн аюулгүй байдалд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн талаар мэдлэг олгодог.

Гуравдугаар үе шат: 14-16 насны хүүхдүүдэд хүнд дурлах, үерхэх үед сэтгэлээ найздаа эсхүл багшдаа хэлж сурах аргыг зааж өгөх, мөн ийм үед сэтгэл зүйн хувьд ямар эерэг арга хэмжээ авч болох талаар ярилцана. Мөн гэрлэлт, эцэг эх болох, гэр бүлийн амьдрал зэрэг олон төрлийн хүмүүсийн харилцаа ба үүрэг хариуцлагын чухал чанарын талаар таньж мэдүүлнэ.

Европын улсууд: Тухайн улсуудад хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт “Хүчирхийллийн хор уршиг”, “Аюултай

⁴⁸ “Хүүхдийн эрх ба хамгаалал” үндэсний судалгаа 2016 он.

нөхцөл байдалд хэрхэн орохгүй байх”, “ҮГҮЙ гэж хэлж сур” зэрэг сургалт тусгагдсан байдаг. Түүнчлэн, албан бус сургалтаар залуу хосууд болон эцэг, эхчүүдийг хэрхэн уураа барьж сурах мөн нялх хүүхэдтэйгээ хэрхэн харьцаж ямар аргаар тайвшруулах, хэрхэн болгоомжтой тэврэх зэрэг ойлголт эзэмшүүлдэг.⁴⁹

Солонгос улс: БНСУцын албан бус сургалтаар гэр бүлийн боловсролыг олгох дараах хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Үүнд:

- Үр нөлөөтэй эцэг, эх боловсролын хөтөлбөр /Хөтөлбөрийн зорилго нь эцэг, эх, хүүхдийн харилцааг сайжруулах, харилцан ойлголцлын арга зүй, зарчмуудыг эцэг, эхэд эзэмшүүлэх/
- Дуранну аавын сургууль /“Аав амьдарвал гэр бүл амьдарна” гэсэн уриатай ба аав хүн бусдад ямар нөлөөтэй болох, ажил үүргийн хуваарь, эр хүний мөн чанар, түүний алддаг шалтгаан, эр хүний чанарын загвар зэргийг заадаг./
- Дүрэнна ээжийн сургууль /Ээж гэж хэн бэ? Эмэгтэй хүний хүсэл, мөрөөдөл, сонирхол, хүүхэд гэр бүлд үзүүлэх нөлөөлөл, үүрэг хариуцлага зэргийг заадаг./

Дэлхийн өндөр хөгжилтэй улсууд боловсролын тогтолцоондоо тулгуурлан гэр бүлийн гишүүдэд албан бус, албаны ёсны сургалтаар гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, эцэг, эх, хүүхдийн үүрэг хариуцлага, хүүхдийг хүмүүжүүлэх орчин үеийн аргын талаар гэр бүлийн гишүүдэд ойлголт мэдлэг олгох замаар гэр бүл дэх гэр бүлийн хүчирхийллээс амжилттай урьдчилан сэргийлж байна.

Монгол Улсад гэр бүлийн боловсрол олгож буй өнөөгийн байдал

Манай улсын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт гэр бүлийн боловсрол гэсэн тусгай хичээл байхгүй бөгөөд “Эрүүл мэндийн боловсрол”, “Иргэний боловсрол”, “Технологи” зэрэг хичээлийг төстэй агуулгатай гэж авч үзье.

Эдгээр хичээлийг заах мэргэжлийн багшийн орон тоо байхгүй бөгөөд 1-5 дугаар ангийн хичээлийг анги удирдсан багш нар, “Эрүүл мэндийн боловсрол” хичээлийг хими биологийн багш нар, “Иргэний боловсрол” хичээлийг түүх-нийгмийн ухааны багш нар голчлон заадаг байна.

Хүснэгт 2.

Хичээлийн нэр	Анги	Агуулга	Багшийн мэргэжил
Эрүүл мэндийн боловсрол (7 хоногт нэг удаа 45 минутаар нэг жилд нийт 36 удаа)	1-5	Хүний хөгжил, хүний биеийн бүтэц, биеийн эрүүл мэнд, эрүүл орчин, архи тамхины муу нөлөө, гэрлэлт, зөв хооллолт, гэр бүлийн боловсрол, гоо сайхан, жирэмслэлт, бэлгийн боловсрол	Хими-биологийн багш нар
	6-8		
	9-12		
Иргэний боловсрол (7 хоногт нэг удаа 45 минутаар нэг жилд нийт 36 удаа)	9-12	Эцэг, эх- эхнэр нөхрийн үүрэг, Гэр бүл улсын баялгийг зөв зохистой ашиглах нь Яаралтай түргэн тусламж	Түүх-нийгмийн ухааны багш нар
Технологи (7 хоногт хоёр удаа 45 минутаар нэг жилд нийт 72 удаа)	1-5	Цаасан урлаг, хайчилбар	Технологи, гар урлалын багш
	6-8	Гар урлал, хоолны орцны бүтэц калори, нэхмэл	
	9-12	Хувцас зүүлт гоёл хийх, хувцасны материал, хоолны орцны бүтэц, хийх арга, хатгамал	

2017 онд байгуулагдсан Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдүүдийг гэр бүлийн боловсролтой холбоотой албадан сургалтад хамруулдаг болсон нь сайшаалтай.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс үзэхэд, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын дунд сургууль, их, дээд сургуульд гэр бүлийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, гэрлэгсдийн үүрэг,

⁴⁹ https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/rights-child/child-protection-systems_en

хариуцлага, гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаар мэдлэг олгох хичээл, сургалт зохион байгуулдаггүйгээс үүдэн хүчирхийлэлд дасан зохицох байдлыг төрүүлэх хандлагатай байна.

Иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсар дутмаг байгаа нь гэр бүл дэх гэр бүлийн хүчирхийллийг нуугдмал байхад нөлөөлж байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бодлогын судалгаа, гадаадын улсын туршлагад үндэслэн тодорхой үе шаттай зохион байгуулах, ялангуяа боловсролын тогтолцоонд тулгуурлан иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн гишүүдийг хайрлах, энэрэх хандлага төлөвшүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтыг чанартай зохион байгуулж, хяналт тавих тогтолцоог сайжруулах шаардлагатай болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Хүүхдэд сургуулийн өмнөх наснаас нь эхлэн хүчирхийлэл болон түүнийг үл тэвчих хандлага эзэмшүүлэх сургалтыг боловсролын тогтолцоогоор дамжуулан заах /Солонгос улсад хүүхдэд сургуулийн өмнөх наснаас эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаа, эсрэг хүйсийн хүнтэйгээ хэрхэн харьцах талаарх хичээлийг зааснаар тус улс дахь гэр бүлийн хүчирхийлэл сүүлийн жилүүдэд 10.5 хувь буурсан үзүүлэлттэй байна.⁵⁰
- Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт гэр бүлийн боловсрол, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршиг, түүнээс сэргийлэх талаарх хичээлийг тусгах
- Албан бус сургалтаар иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалах мэдлэг, чадвар олгох сургалтыг зохион байгуулах-зэрэг болно.

Ном зүй

- Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судалгааны тайлан. ХЗДХЯ, ФСЭХ, 2005
- Хүүхдийн эрх ба хамгаалал үндэсний судалгаа 2016
- Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016
- Хүний эрхийн цуврал нийтлэл 2012
- Жөндөрт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл 2016
- Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төвөөс шүүх эмнэлгийн бүртгэлд хийсэн судалгаа. УБ 2007
- Хүүхдийн төлөө үндэсний газрын хүүхэд хамгаалал үйлчилгээний газрын дарга Б.Жавзанхүүтэй хийсэн ярилцлага 2013
- https://ec.europa.eu/info/policies/justice-and-fundamental-rights/rights-child/child-protection-systems_en
- <https://asiasociety.org/education/south-korean-education>
- United Nations Study on Violence against Children
- <https://www.ohchr.org/Documents/HRBodies/CRC/StudyViolenceChildren/Responses/Republic%20of%20Korea.pdf>

---oOo---

⁵⁰United Nations Study on Violence against Children. <https://www.ohchr.org/Documents/HRBodies/CRC/StudyViolenceChildren/Responses/Republic%20of%20Korea.pdf>

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

БУЛАНГ ЭРХЛЭН ГАРГАГЧИЙН ҮГ

1990 оноос эхлэн Монгол Улсад хууль зүйн салбарын шинэчлэл тасралтгүй явагдаж, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, сэтгэлгээ хөгжихийн хирээр үндэсний эрүүгийн хууль тогтоомж улам боловсронгуй болсоор байна. Үүнд эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлалын үүрэг, ач холбогдол нэмэгдсээр байгаа ба гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, төрийн эрүүгийн бодлогыг зөв тодорхойлон хэрэгжүүлэх, Эрүүгийн хуулийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжийг судлах, ололттой талыг нээн илрүүлэх, сайн туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн нутагшуулах, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж байна.

Үүний тулд эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлалыг хөгжүүлэх, нийгмийн захиалга, эрх зүйн шинжлэх ухааны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн судалгааны ажлыг бодлогоор явуулах, судалгааны ажлын чиглэл, цар хүрээг өргөжүүлэх, мэргэшсэн судлаачдыг бэлтгэх, хууль зүйн их, дээд сургуулиудад заагдаж буй “Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал” хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, сургалтад ашиглах сургалтын материал, сурах бичиг, сургалтын гарын авлагыг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх гадаад орнуудын Эрүүгийн хуулийг эх хэлнээ орчуулах, харьцуулсан эрүүгийн эрх зүйн чиглэлээр тусгайлан эрдэм шинжилгээний сэтгүүл гаргах шаардлага байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Энэ ажилд дэм болох зорилгоор 1999 оноос Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Отгонтэнгэр их сургууль, МҮИС-ийн Хууль зүйн удирдлагын сургууль, ХУИС-ийн харьяа Билиг хууль зүйн сургуулийн магистрын сургалтад “Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал” хичээл заасан туршлагандаа дулдуйдан, эрдэмтэн-судлаачийн хувьд нэмэр болох үүднээс “Гэмт явдалтай тэмцэх асуудал” онол, арга зүйн сэтгүүлд “Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал” гэсэн буланг нээж хариуцан ажиллахаар болсноо сэтгүүлийн эрхэм уншигч та бүхэнд дуулгаж байна. Өнөөдөр уг булангаа нээж БНАСАУ-ын Эрүүгийн хуулийн талаарх мэдээллээр эхэлж байна.

БНАСАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Г.Гантөмөр

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор,
доктор, профессор*

Оршил: БНАСАУ улс төрийн дэглэм, үзэл сурталын шалтгаанаар гадныханд хаалттай учраас тус улсын эрх зүйн тогтолцоо, Эрүүгийн хуулийн талаар мэдээлэл хомс, ихэнх мэдээлэл гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл, албан ажлын шугамаар зорчсон хүмүүсийн тэмдэглэлд тулгуурладаг учраас зарим талаар бодит бус, өнгөц, хувийн үзэл бодол, таамаглал хэлбэртэй байдаг.

БНАСАУ-ын эрх зүйн тогтолцоо, Эрүүгийн хуулийн талаарх судалгаа туйлын бага, бичиж хэвлэгдсэн нь харьцангуй цөөн. Иймээс Хойд Солонгосын Эрүүгийн хуулийн талаарх мэдээллийг орос хэлээр хэвлэгдсэн материал, эх сурвалжууд, тухайлбал, Орос хэлээр хэвлэгдсэн тус улсын Эрүүгийн хуулийн орчуулгад⁵¹ үндэслэн бэлтгэлээ. Ингэхдээ тус орны Эрүүгийн хууль, түүний холбогдох хэм хэмжээтэй уншигч та бүхнийг зөвхөн танин мэдэхүйн үүднээс танилцуулах зорилготой ба харьцуулан дутагдалтай талыг илрүүлж шүүмжлэх зорилгыг тавиагүй болно.

БНАСАУ нь Солонгосын хойгт оршдог, социалист эрх зүйн бүлийн төлөөлөл болж үлдсэн цөөхөн орны нэг юм.

1945 онд Алс Дорнодод явагдсан дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд Японы империалистуудтай хийсэн Зөвлөлтийн улаан армийн чөлөөлөх дайны үр дүнд 1948 оны 9 дүгээр сарын 9-нд ардчилсан Солонгос улс байгуулагдсан түүхтэй.

⁵¹ Уголовный кодекс Корейской Народной Демократической Республики. Перевод А.Ю.Ковша, Ю.Д.Скрипника. СПб. изд. Гиперион.2017 год. 158 с .

1950 оны 3 дугаар сарын 3-нд Ардын Төлөөлөгчдийн Дээд Хурлын 1 дэх удаагийн сонгуулийн 5 дугаар чуулганаар БНАСАУ-ын анхны Эрүүгийн хуулийг баталсан ба уг хууль нь 13 бүлэг, 161 зүйлээс бүрдэж байв.⁵²

1974 онд БНАСАУ-ын хоёрдахь Эрүүгийн хуулийг 17 бүлэг, 215 зүйлтэйгээр баталж 1975 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрджээ.⁵³

БНАСАУ-д одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Эрүүгийн хууль нь тус улсын Ардын Төлөөлөгчдийн Дээд Хурлын Байнгын хорооны 1987 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн тогтоолоор батлагдсан⁵⁴ ба түүнээс хойш 10 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.⁵⁵

БНАСАУ-ын Эрүүгийн хуулийн тогтолцоо: Эрүүгийн хууль нь бүтцийн хувьд онцлогтой, бидний мэддэг уламжлалт ерөнхий, тусгай анги гэсэн бүтэц байхгүй, 9 хэсэг, 290 зүйлээс бүрдэнэ.

1 дүгээр хэсэг. Эрүүгийн хуулийн үндсэн зарчим /1-9 дүгээр зүйл/

2 дугаар хэсэг. Нийтлэг үндэслэлүүд гэсэн нэртэй 10-58 дугаар зүйлээс бүрдэнэ. Энэ 2 хэсэг нийлж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн үүрэг гүйцэтгэдэг.

Ардчилсан Солонгос Улсын Эрүүгийн хуулийн 3-9 дүгээр хэсэг нь тусгай ангийн үүрэг гүйцэтгэх ба

3 дугаар хэсэг. Эх орон, улс үндэстний эсрэг гэмт хэрэг /59-73 дугаар зүйл/

4 дүгээр хэсэг. Улс орны батлан хамгаалах журам зарчсөн гэмт хэрэг / 74-90 дүгээр зүйл/

5 дугаар хэсэг. Социалист аж ахуйн эсрэг гэмт хэрэг /91-182 дугаар зүйл/

6 дугаар хэсэг. Социалист аж төрөх ёсны эсрэг гэмт хэрэг /183-208 дугаар зүйл/

7 дугаар хэсэг. Төрөөс тогтоосон захиргааны журмын эсрэг гэмт хэрэг /209-245 дугаар зүйл/

8 дугаар хэсэг. Социалист нийгмийн хэв журмын эсрэг гэмт хэрэг / 246-265 дугаар зүйл/

9 дүгээр хэсэг. Иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмчийн эсрэг гэмт хэрэг /265-290 дүгээр зүйл/ гэсэн бүтэцтэй.

Ерөнхий анги: “Эрүүгийн хуулийн үндсэн зарчим” гэсэн 1 дүгээр бүлгийн 1-9 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн зорилго, гэмт хэрэгтэнтэй харьцах, зөвхөн Эрүүгийн хуульд заасан үйлдлийн төлөө ял оноох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эх орон, ард түмний эсрэг урьд гэмт хэрэг үйлдсэн хүнд хандах, гэмт хэргээ илчлэн ирсэн болон гэмт хэрэгтнийг барьж өгсөн этгээдэд ял оногдуулах, ялыг ялгамжтай оногдуулах, эрүүгийн хуулийн үйлчлэх иргэний харьяалалын ба нутаг дэвсгэрийн зарчим, эрүүгийн хуулийг хэрэглэх, буцаан хэрэглэхгүй байх журам гэсэн зарчим гэхээс илүүтэйгээр Эрүүгийн хуулийн үйлчлэх, хэрэглэх журмын заасан хэм хэмжээнээс бүрдэж байна.⁵⁶

Энэ бүлгээс анхаарал татах хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх тухай заалт бөгөөд уг хуулийн 9 дүгээр зүйлд “...гэмт хэрэг үйлдэх үед ямар Эрүүгийн хууль үйлчилж байсан тэр хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ, өөрөөр хэлбэл, өмнөх Эрүүгийн хуулиар гэмт хэрэг гэж тооцож байсан үйлдлийг шинэ хуулиар гэмт хэрэг гэж тооцохоо больсон эсвэл ялыг хөнгөрүүлсэн байсан ч ийм шинэ хуулийг буцаан хэрэглэх хүчингүй...” гэж заажээ.

“Нийтлэг үндэслэлүүд” гэсэн нэртэй 2 дугаар хэсгийн 10-58 дугаар зүйлд гэмт хэргийн ойлголт /10 дугаар зүйл/, эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаар /11 дүгээр зүйл/, хэрэг хариуцах чадваргүй байдал, ийм байдалд гэмт хэрэг үйлдсэн хүнд хэрэглэх эмнэлгийн чанартай арга хэмжээ хэрэглэх тухай /12-13 дугаар зүйл/, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх үндэслэл /14 дүгээр зүйл/, аргагүй хамгаалалт /15 дугаар зүйл/, гарцаагүй байдал /16 дугаар зүйл/, бусдын гуйлт, хүсэлтээр эсвэл уг этгээдтэй хамтран түүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /17 дугаар зүйл/, ах дүү, гэр бүлийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /18 дугаар зүйл/, гэмт хэргийг

⁵² А.М.Иванов, А.Г.Корчагин. Преступление и наказание в странах АТР. Учебное пособие. Владивосток. Изд ДВГУ. 1999 стр 22-23

⁵³ Мөн тэнд. стр 25

⁵⁴ А.В.Ковш. Сравнительный анализ отдельных положений УК КНДР и РК // КНДР И РК 70 лет. Коллективная монография. Издательство Института Дальнего Востока Российской академии наук. М. 2018. стр 84.

⁵⁵ А.П.Скиба, А.В.Ковш, А.Н.Миханова. Досрочное освобождение от отбывания наказания: сравнительно правовой анализ норм уголовного законодательства РФ и КНДР //Юридический Вестник Самарского университета. 2019. № 1 стр 61

⁵⁶ Уголовный кодекс Корейской Народной Демократической Республики. Перевод А.Ю.Ковша, Ю.Д.Скрипника. СПб. изд. Гиперион. стр 3-4 /Цаашид уг хуулиас ашиглах болно.Г.Г..

урьдчилан төлөвлөж үйлдэх, үйлдэхээр завдсан үед хүлээлгэх эрүүгийн хариуцлага /19 дүгээр зүйл/, гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзах /20 дугаар зүйл/, гэмт бүлэглэлийн гишүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /21 дүгээр зүйл/, гэмт хэргийг үйлдэхийг өдөөн хатгасан, турхирсан болон тусламж дэмжлэг үзүүлсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх /22-23 дугаар зүйл/, гэмт хэргийг нуун далдлах /24 дүгээр зүйл/, гэмт хэргийг төрийн байгууллагад үл мэдээлэх /25 дугаар зүйл/, гэмт хэргийн тухай мэдээлэлд хайхрамжгүй хандах /26 дугаар зүйл/ ялын ангилал, төрлүүд /27-37 дугаар зүйл/, ял онгдуулах /38 дугаар зүйл/, ял хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдлууд /39-40 дүгээр зүйл/, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах /42 дугаар зүйл/, ялыг нэгтгэж оногдуулах /43-44 дүгээр зүйл/⁵⁷, тодорхой төрлийн ялуудын хугацаа, хэмжээг тогтоох /45 дугаар зүйл/, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх, гүйцэтгэх хугацааг тоолох /48 дугаар зүйл/, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнийг хөдөлмөр хүмүүжлийн сургуульд явуулах /49 дүгээр зүйл/, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг зогсоох, хойшлуулах /51 дүгээр зүйл/, ял шийтгэлтэй байдал /52, 55 дугаар зүйл/, өршөөл үзүүлэх /53 дугаар зүйл/, ялаас хугацааны өмнө чөлөөлөх /54 дүгээр зүйл/, хэргийн хөөн хэлэлцэх хугацаа /56 дугаар зүйл/, хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх тохиолдлууд /57 дугаар зүйл/, хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам /58 дугаар зүйл/-ыг тогтоосон байна.

Гэмт хэргийн ойлголт, ангилал: Тус улсын Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлд "...БНАСАУ-ын тусгаар тогтнол, социалист нийгмийн байгуулал, социалист хуулийг санаатай ба болгоомжгүйгээр зөрчсөн, нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэг гэж үзнэ" гэж хэргийн ойлголтыг хуульчилсан нь социалист агуулгатай гэмт хэргийн материаллаг ангилалын тодорхойлолтод хамаарна.

БНАСАУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийн ангилалыг хуульчлаагүй боловч цөөнгүй зүйлд эх орон, иргэдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, эх орон, иргэдийн эсрэг онц аюултай үйлдэл хийсэн бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, ялаас чөлөөлөхгүй байх талаар тусгайлан заасан нь анхаарал татаж байна.

Эрүүгийн хариуцлага хүлээх насны доод хязгаарыг 14 насаар тогтоож өгсөн /11 дүгээр зүйл/, нийгэмд аюултай үйлдлийн улмаас ялимгүй хохирол учруулсан бол гэмт хэрэг тооцохгүй байх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх /14 дүгээр зүйл/, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал гэсэн гэмт хэргийг үгүйсгэх 2 нөхцөл байдлыг заасан /15-16 дугаар зүйл/, бусдын зөвшөөрснөөр /гуйлт, хүсэлтээр/ эсвэл уг этгээдтэй хамтран түүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь эх орон, иргэдэд онц аюултай үйлдэл хийж хохирол учруулсанаас бусад тохиолдолд гэм хэрэгт тоцохгүй байх /17 дугаар зүйл/ ах дүүс, гэр бүлийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хохирогчдын зүгээс гомдолгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй эвлэрсэн тухай хүсэлт гаргасан бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй байх /18 дугаар зүйл/, гэмт хэргийг төлөвлөх, гэмт хэрэг үйлдэхээр завдах гэсэн гэмт хэргийн хоёр үе шатыг хуульчилж, ял оногдуулах нөхцөл, журмыг заасан /19 дүгээр зүйл/, хатгагч, хамжигч, гэсэн гэмт хэрэгт хамтран оролцогчдын төрөл /22 дугаар зүйл/, зохион байгуулалттай бүлэг гэсэн гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг зааж, түүний удирдагч, гишүүдэд хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан /23 дугаар зүйл/ зэрэг онцлог хэм хэмжээ бий.

Ялын ойлголт, тогтолцоо, төрөл, ангилал: БНАСАУ-ын Эрүүгийн хуульд ялын ойлголт, түүний зорилгыг тодорхойлоогүй, харин 27-28 дугаар зүйлд ялын төрөл, ангилалыг хуульчилсан байна. 27 дугаар зүйлд ялын тогтолцоог тогтоохдоо гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах 8 төрлийн ялыг хүндээс нь хөнгөн ялын төрөл рүү доорх дараааалаар хуульчилжээ. Энэ нь:

1. Цаазаар авах
2. Бүх насаар нь засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
3. Хугацаатайгаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх
4. Албадан ажил хийлгэх
5. Сонгуулийн эрхийг хасах
6. Эд хөрөнгийг хураах
7. Албан тушаал хаших эрхийг хугацаагүй хасах
8. Тодорхой хугацаагаар албан тушаал хаших эрхийг хасах ял болно.

Дээрх ялын төрлийн 1-4-д заасан ялыг үндсэн ял, 4-8-д заасан ялыг нэмэгдэл ялын шинж чанартайгаар шүүхээс оногдуулна. /28 дугаар зүйл/

⁵⁷ Хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах Г.Г.

Цаазаар авах ялыг Эрүүгийн хуульд оногдуулахаар заасан хэрэгт хэрэглэх ба буудан алах замаар гүйцэтгэнэ. 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн болон жирэмсэн эмэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулдаггүй. /29 дүгээр зүйл/

Төр, засгийг түлхэн унагах зорилгоор хуйвалдаан зохион байгуулах, төрийн эргэлт хийх, Улс төрийн зорилгоор аллага хийх, Хорлон сүйтгэх, Үндэсний эрх чөлөөний болон Солонгосын ард түмнийг нэгтгэх үйл ажиллагаанд саад учруулах, Хүнийг санаатай алах зэрэг хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдвэл цаазаар авах ял шийтгэдэг.

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг Эрүүгийн хуульд заасан тохиолдолд ялтныг энэ ялыг эдлүүлэхээр тусгайлан байгуулагдсан хөдөлмөрийн лагерьт хугацаагүй болон хугацаатайгаар засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэж эдлүүлдэг. Хугацаатай засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын доод хэмжээ нь 1 жил, дээд хэмжээ нь 15 жил байх ба улс төрийн болон иргэний зарим эрхүүд нь хязгаарлагддаг онцлогтой. /30 дугаар зүйл/

Албадан ажил хийлгэх ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн заасан газарт /үйлдвэрт/ албадан хөдөлмөр эрхлүүлэх замаар хэрэгжих ба иргэний улс төрийн болон иргэний бусад эрхийг хязгаарладаггүй, 6 сараас- 2 жил хүртэл хугацаагаар оногдуулна. /31 дүгээр зүйл/

Сонгуулийн эрхийг хасах ялыг үндсэн ялуудад нэмэгдэл ял болгон эх орон, ард түмний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулна. Уг ялын хугацаа 1-5 жил хүртэл байх ба үндсэн ялаа эдэлж дуусан өдрөөс хугацааг нь эхлэн тоолно. /32 дугаар зүйл/

Эд хөрөнгө хураах ялыг мөн нэмэгдэл ялын шинжтэйгээр шүүхээс оногдуулна. Уг ялын цээрлэл нь ялтны хувийн эд хөрөнгийг хурааж төрийн эзэмшилд шилжүүлэх явдлаар илрэх ба ялтан, түүний гэр бүлийн амьдралын наад захын хэрэгцээний зүйл, хоол хүнс, хувцасыг хурааж болохгүй гэж заасан нь манай улсын 1961 оны Эрүүгийн хуулийн эд хөрөнгө хураах ялын тухай хэм хэмжээг санагдуулдаг. /33 дугаар зүйл/

Албан тушаал хаших эрхийг хасах ялыг албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн байдал, дахин гэмт хэрэг үйлдэх боломж, нөхцөл зэргийг харгалзан шүүхээс хугацаагүй болон тодорхой хугацаатайгаар оногдуулдаг. Хугацаатайгаар албан тушаал хаших эрхийг хасах ялыг шүүх оногдуулахаар бол хугацаа нь 3 жил хүртэл байна. /37-38 дугаар зүйл/

Тус улсын Эрүүгийн хуулийн 39 дүгээр зүйлд ялыг хүндрүүлэх 5 нөхцөл байдлыг, хөнгөрүүлэх 8 нөхцөл байдлыг заасан ба шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхээс өмнө улс орны хөгжил, социалист бүтээн байгуулалтанд үлэмж хувь нэмэр оруулсан, эх орны өмнө гавьяа байгуулсан бол ялыг хөнгөрүүлэхээр заасан нь анхаарал татна, ийм зохицуулалт 1997 оны БНХАУ-ын Эрүүгийн хуульд байдаг.

Тусгай ангийн тогтолцоо: Дээр дурдсанчилан Ардчилсан Солонгос Улсын Эрүүгийн хуульд тусгай анги гэсэн тусгайлан нэрлэсэн бүтэц байхгүй ч тодорхой төрлийг гэмт хэргүүд, тэдгээрт оногдуулах ялын төрлийг заасан хэм хэмжээ буюу 3 дугаар хэсгээр эхэлж байна.

“Эх орон, улс үндэстний эсрэг гэмт хэрэг” гэсэн 3 дугаар хэсгийн 59-73 дугаар зүйлд заасан Төр, засгийг түлхэн унагах зорилгоор хуйвалдаан зохион байгуулах, төрийн эргэлт хийх, Улс төрийн зорилгоор аллага хийх, Төрийн эсрэг ухуулга, суртчилгаа хийх, Эх орноосоо урвах, Тагнуул хийх, Хорлон сүйтгэх, БНАСАУ-д гадаадаас халдан довтлох, дипломат харилцааг хүндрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, Үндэсний эрх чөлөөний болон Солонгосын ард түмнийг нэгтгэх үйл ажиллагаанд саад учруулах, БНАСАУ-ын эрх ашигт хор хүргэх зорилгоор гадаадын иргэдийн эсрэг хүч хэрэглэх, Хилийн гадна байгаа БНАСАУ-ын иргэдийн эсрэг хүч хэрэглэх, Эх орон, улс үндэстний эсрэг гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдлах зэрэг гэмт хэргийг хуульчилжээ.

“Улс орны батлан хамгаалах журам зарчсон гэмт хэрэг”-ийг багтаасан 4 дүгээр хэсэг нь БНАСАУ-ын Үндэсний батлан хамгаалах зөвлөлийн дарга, Завсэгт хүчний Ерөнхий командлагчийн болон БНАСАУ-ын Үндэсний батлан хамгаалах зөвлөл, БНАСАУ-ын Хөдөлмөрийн намын Цэргийн төв Хорооны тушаал, шийдвэрийг үл биелүүлэх, биелүүлэхэд хайнга хандах, Цэрэг, дайны хэрэгцээ шаадлагатай болон улсын захиалгат бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхгүй байх, зохих ёсоор биелүүлэхгүйгүй байх, Цэргийн объект, байлдааны галт зэвсэг, хэрэгслийг санаатай устгах, Цэргийн объект, байлдааны галт зэвсэг, хэрэгслийг болгоомжгүй устгах, гэмтээх, Цэргийн алба хаах дүрэм, журмыг зөрчих, Байлдааны галт зэвсэг, хэрэгслийг хууль бусаар олж авах, Байлдааны галт зэвсэг, хэрэгслийг үрэгдүүлэх, Байлдааны галт зэвсэг, хэрэгслийг худалдах, Байлдааны галт зэвсэг, хэрэгслийг үйлдвэрлэхэд саад учруулах, Чанаргүй, гэмтэлтэй байлдааны галт зэвсэг, хэрэгслийг үйлдвэрлэх, Байлдааны галт

зэвсэг, хэрэгсэл болон түүний эд анги болон үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийг хууль бусаар завших, Цэргийн албанаас зайлсхийх, Цэргийн албанаас зайлсхийгчид болон цэргийн албанаас оргосон этгээдийг нуун далдлах, тэдэнд туслах, Цэргийн албан хаагчдад албан үүргээ биелүүлэхэд нь саад учруулах, Цэргийн албан хаагчийн нэрийг зээлдэх, цэргийн албан хаагчийн хувцасыг хууль бусаар хэрэглэх, Батлан хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг зөвшөөрөлгүйгээр тараах, хэвлэх зэрэг үйлдүүдийг заасан 74-88 дугаар зүйлээс тогтоно.

Дараагийн бүлэг гэмт хэргүүд нь 5 дугаар хэсэгт заасан **“Социалист эдийн засаг, ахуйн эсрэг гэмт хэрэг”** бөгөөд улсын ба хоршооллын өмчийн эсрэг болон социалист аж ахуйн үйл ажиллагааны журам зөрчсөн дараах хэргийг хуульчилжээ. **Улсын ба хоршооллын өмчийн эсрэг хэргүүдийг** 89-99 дүгээр зүйлд заасан ба Улсын ба хоршооллын эд хөрөнгийг хулгайлах, Улсын ба хоршооллын эд хөрөнгийг дээрэмдэх, Улсын ба хоршооллын эд хөрөнгийг онц их хэмжээгээр дээрэмдэх /энэ тохиолдолд бүх насаар нь засан хүмүүжүүлэх ял шийтгэнэ. 94 дүгээр зүйл/⁵⁸, Улсын ба хоршооллын эд хөрөнгийг хууль бусаар авахаар дайлайлган сүрдүүлэх, заналхийлэх, Улсын ба хоршооллын эд хөрөнгийг залилан эхэлж авах, Улсын ба хоршооллын эд хөрөнгийг завших, Улсын ба хоршооллын эд хөрөнгийг санаатай устгах гэмтээх хэргүүд хамаардаг бол **“Социалист аж ахуйн үйл ажиллагааны журам зөрчсөн хэргүүд”**-д Мөнгөн тэмдэгийг хуурамчаар үйлдэх, Хуурамч мөнгөн тэмдэгт ашиглах, Гадаад валютыг дамлан худалдах, Гадаад валютын гүйлгээний журам зөрчих, Эм болон аюултай бодисыг үйлдвэрлэх, хангах нийлүүлэх хадгалах журам зөрчих, Албан татвар, төлбөр, хураамжийг төлөхөөс зайлсхийх, Хувийн хөдөлмөрийн хориглосон үйл ажиллагаа явуулах, Патент, барааны тэмдэг, бараа үйлдвэрлэсэн газрын нэрийг хууль бусаар ашиглах, Хоршооллын байгууллагын нэрийг ашиглах, Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, Үнэт чулуу, үнэт металыг хууль бусаар хил нэвтрүүлэх, Бараа бүтээгдэхүүн импортлох, экспортлох журам зөрчих зэрэг хэргүүд хамаардаг. Мөн энэ хэсэгт байгаль хамгаалах журмын эсрэг зарим гэмт хэргүүдийг хуульчилжээ.

6 дугаар хэсгийн 183-208 дугаар зүйлүүдэд **“Социалист аж төрөх ёсны эсрэг гэмт хэргүүд”**-ийг заасан. Уг хэсэгт социалист үзэл суртал, ёс суртахуун, хүмүүжил, социалист соёл, социалист хамтын аж байдал, аж төрөх ёсны эсрэг гэмт хэргүүдийг хуульчилжээ. Тухайлбал: Социалист ёс суртахуунд харшлах эд зүйлийг хил нэвтрүүлэх, тараах, Мөрийтэй тоглох, Дамын наймаа хийх, Ажил, хөдөлмөр хийхээс татгалзах, зайлсхийх, Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай ба болгоомжгүй устгах гэмтээх, хууль бусаар хил нэвтрүүлэх, Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг устгах гэмтэх, хайр гамгүй хандах зэрэг болно.

“Төрөөс тогтоосон захиргааны журмын эсрэг гэмт хэрэг” гэсэн 7 дугаар хэсэгт /209-245 дугаар зүйл/ Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг, төрийн албан тушаалтан, албан хаагчийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг болон шүүн таслах ажиллагааны журам зөрчсөн гэмт хэргүүдийг, 8 дугаар хэсэгт заасан **“Социалист нийгмийн хэв журмын эсрэг гэмт хэрэг”** /246-265 дугаар зүйл/-т нийгмийн хэв журам, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийг хуульчилсан онцлогтой.

Тусгай ангийн хамгийн сүүлд буюу 9 дүгээр хэсэгт **“Иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмчийн эсрэг гэмт хэрэг”** /265-290 дугаар зүйл/-үүдийг нэг хэсэгт хуульчилсан анхаарал татна.

Иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт уламжлал ёсоор хүнийг санаатай алах, хүний амь насыг болгоомжгүй хохироох, бие махбодь, эд эрхтэнийг хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, хүний амь бие, эрүүл мэндийг аюултай байдалд оруулах, хүчиндэх болон түүнтэй төсөөтэй гэмт хэргүүдийг хуульчилсан бол Иргэдийн өмчийн эсрэг гэмт хэрэгт хулгайлах, булаах, дээрэмдэх, эд хөрөнгийг устгах, гэмтээх гэсэн харьцангуй цөөн тооны хэргийг хамааруулжээ.

Дүгнэлт

Эцэст нь тэмдэглэхэд БНАСАУ-ын Эрүүгийн хууль нь тус улсын нийгмийн байгуулал, улс төрийн дэглэм, нэг намын тогтолцоо, социалист үзэл суртал, эдийн засгийн харилцааны мөн чанар, онцлогийг илэрхийлсэн, тэдгээрт нийцсэн, социалист эрх зүйн бүлийн орнуудын Эрүүгийн хуулийн нийтлэг шинжийг агуулсан ба эрүүгийн эрх зүйн хөгжлийн онолын ба сэтгэлгээний түвшин, боловсруулалт, хуулийн бүтэц, түүнд хууьчлагдсан гэмт хэрэг, ялын

⁵⁸ Үүнтэй ажил төстэй хэм хэмжээ 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангид байсан. Уг хуулийн 128 дугаар зүйлд социалист өмчийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулсан бол эд хөрөнгийн хурааж 8-15 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл эд хөрөнгийг хурааж цаазаар авах ял шийтгэдэг байв. Г.Г

төрөл зэргээрээ БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуультай зарим талаар ижил төстэй байгаа нь ажиглагдаж байна.

---o0o---

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН АГУУЛГА, МӨН ЧАНАР, ХУУЛЬ ЗҮЙН УЧИР ХОЛБОГДОЛ

Б.Эрдэнэбилээ
Хуульч

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж нь тухайн үеийн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг дагаж, 1926, 1929, 1936, 1942, 1961, 2002, 2015 онд шинээр батлагдан үйлчлэхэд түүнийг хэрэгжүүлэх эрүүгийн процессын хууль тогтоомж нь 1927 оны Монгол ард улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх хуулиас эхлэн 1935, 1949, 1963, 2002, 2017 онд шинэчлэгдэн хөгжлийн түүхэн замналыг туулж ирсэн байна.

Үндсэн хууль	Эрүүгийн хууль	Эрүүгийн процессын хууль
1924 оны Үндсэн хууль	Шүүх цаазын бичиг 1926.11.11	Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх хууль 1927.8.21
	Шүүх цаазын бичиг 1929.9.23	БНМАУ-ын Аливаа хэргийг байцаан Шийтгэх тухай хууль 1935.9.27
	Шүүх цаазын бичиг 1934.5.24	
1940 оны Үндсэн хууль	Эрүүгийн хууль 1942.01.17	ЭБШХууль 1949.7.30
1960 оны Үндсэн хууль	Эрүүгийн хууль 1961.01.31	ЭБШХууль 1963.12.24
1992 оны Үндсэн хууль	Эрүүгийн хууль 2002.01.03	ЭБШХууль 2002.01.03
	2015.12.03	ЭБШХууль 2017.05.18

Эрүүгийн процессын хууль тогтоомжууд нь олон улсын жишиг хандлагын дагуу даяаршиж, улмаар амьдралын бодит хөрсөнд суурилан, түүнд нийцэн зохицож хууль, түүнийг хэрэглэх практик ажиллагаа харилцан шүтэлцэж, уг хуулийн хэрэгжих нөхцлийн талаар судлан мөн чанар, зорилт агуулгыг нээн харуулахын тулд түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн агуулга, мөн чанар, хууль зүйн учир холбогдлыг харьцуулан судлах зайлшгүй шаардлагатай. Үүнд:

Нэмэлт, өөрчлөлт оруулсан	Тайлбар	Хүчин төгөлдөр үйлчилсэн
2019.04.25	Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр "... хүндрүүлж ..." гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн.	2019.05.20
2019.10.10 ⁵⁹	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	2019.11.07
2019.10.18	Өмгөөллийн тухай хууль батлагдсан	2020.01.09
2019.12.20	Сонгуулийн хууль тогтоомжийг шинэчилсэн.	2019.12.23
2020.01.10	Эрүү, Зөрчлийн болон ЗШШТ хуулиудад нэмэлт орсон.	2020.02.24
2020.05.01		

Өнгөрсөн хугацаанд энэхүү хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллагууд болон иргэдээс гаргасан санал, хүсэлтээс үзэхэд тус хуульд заасан зарим асуудлыг тодруулах, нарийвчлах хэрэгцээ байна. Нөгөө талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг Улсын Их Хурлаар батлах явцад эхний хэлэлцүүлгээр дэмжигдэж, хуулийн төсөлд тусгагдсан санал, эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдэхгүй батлагдсаны улмаас хуульд үүссэн хийдэл, давхардлыг арилгах, мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өөрчлөгдөн тусгагдсан заалтад нийцүүлэх шаардлага үүссэн.

⁵⁹ Энэхүү харьцуулалтад 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт, хүчингүй болгосон огноог тавиагүй бөгөөд бусад нэмэлт, өөрчлөлтийн огноог тавьсан болно. Судлаач

Хуульд дээр дурдсан практик хэрэгцээ, шаардлагад үндэслэн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан. Үүнд:

1.Шүүх хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүгч нэмж оруулах болон бүрэлдэхүүнгүй болсон тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг ялгаж тусгайлан зохицуулах;

2.Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах үүднээс прокурорын даалгаварт мөрдөгч санал бичих эрхтэй байхаар заах;

3.Мэдүүлэг авах тухай бүлэгт үндсэн шаардлага болон тусгагдсан боловч зарим нэг оролцогчийн эрхэд тусгагдаагүй асуудлыг тухайлан тусгах;

4.Практикт хэрэгжүүлэх явцад анхан шатны шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулах зэрэг асуудал гарч байгааг шийдвэрлэх зорилгоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуулиар харьяалуулсан асуудлыг шийдвэрлэсэн шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар өөрчлөх;

5.Гэмт хэрэгт холбогдож байгаа хүмүүсийн ихэнх нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй байгааг харгалзан таслан сэргийлэх зарим арга хэмжээнд өөрчлөлт оруулах;

6.Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох зүйлд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу өөрчлөлт оруулах;

7.Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах зорилгоор хуульд тогтоосон зарим хугацаа нь практикт тухайн ажиллагааг явуулж багтахгүй байгаа саналыг харгалзан хугацааг сунгах зохицуулалт оруулах;

8.Хуульд ерөнхий заасан зарим асуудлыг нарийвчлан тусгах. Тухайлбал, яллагдагч яллах дүгнэлтийг хүлээн авахгүй тохиолдолд хийх ажиллагаа, яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт орсон тохиолдолд хийх ажиллагаа зэрэг;

9.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд орсон гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаархи өөрчлөлтөд нийцүүлэн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зохицуулалтад өөрчлөлт оруулах;

10.Анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэртэй холбоотой зарим зохицуулалтад өөрчлөлт оруулах;

11.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль бус ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлд өөрчлөлт оруулах зэрэг онцлог нэмэлт, өөрчлөлт орсон байна.

ЭХХШТ хууль нь 46 бүлэг, 386 зүйлтэй бөгөөд орсон нэмэлт, өөрчлөлтийг харьцуулан дараах дүн шинжилгээг хийж болохоор байна. Үүнд:

2.2 дугаар зүйл.Шүүхийн харьяалал

5.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон, эсхүл шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хэргийг харьяалан шийдвэрлэх шүүх ашиг сонирхолын зөрчилтэй талаар гаргасан хүсэлт нь үндэслэлтэй бол адил шатны өөр шүүхийн дэд шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр зохих шатны өөр шүүхийн шүүгчийг томилж, шүүх бүрэлдэхүүнд шүүгчдийн олонхи нь оролцож байгаа шүүхээр хэргийг хянан шийдвэрлүүлнэ.

5.Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол тухайн хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл сум буюу сум дундын шүүхээс дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын Тэргүүний шийдвэрээр, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, эсхүл өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр шүүхийн харьяалал тогтоон шилжүүлнэ.

Тайлбар: Гагцхүү дээд шатны шүүхийн шүүгчийн шийдвэрээр шүүхийн харьяалал тогтоох асуудлыг шийдвэрлэсэн байна.

3.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн

7.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон бол сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг харьяалах аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, аймаг, нийслэлийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын Тэргүүний шийдвэрээр шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг баримтлан томилно. Тайлбар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай **2.2 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан холбоотойгоор тухайн нэмэлт орсон байна.**

5.1 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг

2. Өмгөөлөгч дараахь эрхтэй:

2.1. **Гэрч**, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан **даруй** уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих;

Тайлбар: 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт **оруулсан** Гэрчээр мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгчтэй мэдүүлэг авах эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч түүнтэй ганцаарчлан уулзах, нийт эрх ашиг сонирхол нь хөндөөгдөж байгаа оролцогчтой даруй буюу боломжит богино хугацаанд уулзах нэмэлтийг Өмгөөллийн тухай хууль батлагдсантай холбогдуулан оруулжээ.

2.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлттэй танилцах, **өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах**, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах;

Тайлбар: Түүнчлэн, шинжээчийн дүгнэлттэй танилцахдаа хуулбарлан авч оролцогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг нь хамгаалах боломжийг бүрдүүлсэн байх бөгөөд мөрдөгч, прокурор нь хуулбарлан өгөх үүрэг хүлээгээгүй гэдгээр өмгөөлөгчдийг чирэгдүүлдэг байсан байна. Учир нь 2002 оны ЭБШ хуульд энэхүү зохицуулалт байсан билээ.

2.7. **өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах;**

Тайлбар: Өмгөөлөгч нь ЭХХШ ажиллагааны явцад оролцогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл нь нотлох баримт цуглуулах хүсэлт, гомдол гаргах билээ. Гэхдээ өмгөөлөгч нотлох баримт цуглуулахгүй.

5.1 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн эрх, үүрэг

4. Өмгөөлөгч тухайн хүн, хуулийн этгээдийн өмгөөлөгчөөр оролцох болсон тухай шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр мэдэгдэнэ.

4. Өмгөөлөгч тухайн хүн, хуулийн этгээдийн өмгөөлөгчөөр оролцох болсноо **үйлчлүүлэгчийн бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулж, шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр мэдэгдэнэ.**

/Энэ хэсэгт 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

Тайлбар: Харин энэхүү зохицуулалт нь хууль зүйн туслалцаа үзүүлэх болсныг үйлчлүүлэгчийн хүсэлтийг баталгаажуулж тухайн мөрдөн шалгах ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлж өгчээ. Гэвч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авагдсан яллагдагч, шүүгдэгч хэрхэн баталгаажуулах нь эрсдэлтэй байна.

Урьд нь гагцхүү өмгөөлөгч тухайн хүн, хуулийн этгээдийн өмгөөлөгчөөр оролцох болсон тухай шүүх, прокурор, мөрдөгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ болон бичгээр мэдэгддэг байсныг өргөжүүлэн үйлчлүүлэгчийн бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулахыг шаардсан байна.

5.4 дүгээр зүйл. Өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулах баталгаа

2. Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгч, прокурор, мөрдөгч нь өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчтэйгээ байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг шаардахыг хориглоно. */Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./*

Тайлбар: Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгч, прокурор, мөрдөгч нь өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчтэйгээ байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг шаардахыг хориглох нь өмгөөллийн үйл ажиллагааны болон хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой байна.

6.1 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага

1. Тагнуулын байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:

1.1. **29.11/Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт;**

/Энэ заалтад 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

Тайлбар: 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд** нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн байна.

6.1 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага

1. Тагнуулын байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:

1.1. **Эрүүгийн хуулийн 14.5 /Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх/, 14.6 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх/, 14.7 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах/, 14.8 /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/, 14.9 /Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах/...**

/Энэ зүйлд 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

Тайлбар: Сонгуулийн хууль тогтоомжийг шинэчилэн баталсантай холбоотойгоор 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар сонгуулийн хууль тогтоомж зөрчих гэмт хэргүүд Тагнуулын Ерөнхий газрын харъяаллын шалгах хэрэг болж энэ хуулийн өөрчлөлт 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр үйлчилж байна.

6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага
1.2.тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 13.1/Хүн худалдаалах/, 18.2/Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/, 18.5/Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/, 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйл, 20.7 дугаар зүйл/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-ийн 3.3-т заасан гэмт хэрэгт.
Тайлбар: Тагнуулын байгууллага нь Эрүүгийн хуулийн 18.2 /Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/, 20.7 / Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах /дугаар зүйлийн 3.3-т заасан гэмт хэрэг буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгоор улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.
6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага
1. Тагнуулын байгууллага...хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.
1.1... 29.1/ Түрэмгий дайныг Түрэмгийлэл, эсхүл дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/./Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
Тайлбар: Эрүүгийн хуульд орсон гэмт хэргийн нэр өөрчлөгдсөнтэй холбоотой.

6.2 дугаар зүйл.Мөрдөгч
2.Мөрдөгч дараахь эрхтэй: 2.11.Прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт саналаа бичгээр нэг удаа гаргах;
Тайлбар: Мөрдөгч эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих байдлуудыг тогтооход ач холбогдолгүй эсхүл тогтоосон гэж хууль л эрх зүйн ухамсарыг удирдлага болгон прокурорын даалгаварт хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор л дээд шатны прокурорт санал гаргах эрхтэй байх бөгөөд энэхүү ажлын 3 хоног өнгөрсөн тохиолдолд прокурорын даалгаварт санал бичих эрхгүй болж заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.
2.14. Шаардлагатай тохиолдолд Өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;
8.Энэ зүйлийн 2.14 дэх заалт нь энэ хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага хооронд өгөх даалгаварт хамаарахгүй.
Тайлбар: Өөр нутаг дэвсгэр, эрх бүхий байгууллагад мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах саналаа прокурорт гаргах нь цаг хугацаа алдах прокурорын ачааллыг зохиомлоор үүсгэж байсныг залруулж прокурорын шийдвэргүй мөрдөгч даалгавар бичих, хариуг авахаар зохицуулжээ. ЭХХШТ хуулийн 2.14 дэх заалт нь цагдаа, тагнуул, Авлигатай тэмцэх байгууллагууд хооронд өгөх даалгаварт хамаарахгүй байгаа нь энэхүү хуулийн 29.4 дүгээр зүйл заасан “мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтантай дараахь хэлбэрээр хамтран ажиллаж болно: 1.1.мэдээлэл солилцох, гаргуулан авах; 1.2.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахад дэмжлэг авах; 1.3.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулах” гэсэн зохицуулалттай холбоотой билээ.

8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх
1.13.шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах; Тайлбар: 2002 оны ЭБШ хуульд энэхүү зохицуулалт байсан нь 2017 оны ЭХХШТ хуулийн 27.2 дугаар зүйлээр шинжилгээ хийлгэх үед оролцогч шинжээчийн дүгнэлттэй танилцахаар хуульчлагдсан боловч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хохирогчид хэргийн танилцуулна гэсэн хэвшмэл ойлголтоос хохирогчийн хуульч ёсны эрх ашиг сонирхол нь зөрчигдөх болсон байна.
Иймд ЭХХШТ хуулийн ерөнхий ангид хохирогчийн эрх зүйлд тусгайлан нэмэлтээр шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн зөвхөн өөрт хамааралтай хэсэгтэй танилцахаар хуульчлагджээ.
1.14.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх; Тайлбар: Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулагдсан иргэн гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг ЭХХШТ хуулийн 25.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна” гэж тусгасан боловч хохирогчийн эрхэд тусгасан байна.
1.15.энэ хуульд заасан бусад эрх.
4.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Тайлбар: Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд гагцхүү Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ томъёолсныг Зөрчлийн тухай хуулийн 15.7 дугаар зүйлд заасан Хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зөрчлийг тусгаж өгсөн байна.

Энэ нь Зөрчлийн тухай хуулийн **15.7 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах**

1.Шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл гэрч, хохирогч, шинжээч мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч шүүхэд хүрэлцэн ирэх, эсхүл шүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, эсхүл шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн захиргааны ажилтны үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.6 дугаар зүйл.Гэрч

4.Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд **Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд** заасан хариуцлага хүлээлгэнэ.

Тайлбар: Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулагдсан иргэн гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг ЭХХШТ хуулийн **25.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт** “Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна” гэж тусгасан байсан бөгөөд гэрчийн эрхэд тусгайлан тусгасан байна.

Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд гагцхүү Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ томъёолсныг Зөрчлийн тухай хуулийн **15.7 дугаар зүйлд заасан Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах** зөрчлийг тусгаж өгсөн байна.

10.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

2.Энэ хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан асуудлыг хянан шийдвэрлэсэн шүүгч анхан шатны, давж заалдах, хяналтын шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

2.Энэ хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах этгээдээр тогтоосон шийдвэр гаргасан шүүгч уг хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

Тайлбар: ЭХХШТ хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад энэ хуулиар харьяалуулсан асуудлыг шүүх хянан шийдвэрлэнэ” гэж заасан нь шүүхийн зөвшөөрөлтэй авагдах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн шүүгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэлд хуульчилсныг өөрчилж гагцхүү хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах этгээдээр тогтоосон шийдвэр гаргасан шүүгч уг хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүйгээр хуульчилсан байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль

29 дүгээр зүйл.Шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт

29.1.Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол оролцохоос татгалзах, эсхүл уг болзошгүй нөхцөл байдал үүсч болохыг шүүх ажиллагаанд оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийн татгалзан гаргах санал тавих боломжийг хангах үүрэгтэй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“нийтийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг;

3.1.2.“хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

3.1.3.“ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

10.1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцож болохгүй үндэслэл

1.Шүүгч дараах үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй:

1.4.өөрөө шууд, эсхүл шууд бусаар энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

ДӨЧИН ТАВДУГААР БҮЛЭГ ЭХХША-НЫ ЯВЦАД ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧИЙН ХУУЛЬ ЗӨРЧСӨН АЖИЛЛАГААНЫ УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ АРИЛГАХ

45.2 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл

1.Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл

харгалзан төр хариуцан арилгана.

10.7 дугаар зүйл. Прокурорыг татгалзан гаргах

3. Шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцож байгаа прокурорыг татгалзан гаргах хүсэлтийг тухайн асуудлыг хянан шийдвэрлэж байгаа шүүх шийдвэрлэнэ.

/Энэ заалтад 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

Тайлбар: Мөрдөн байцаалтын явцад таслан сэргийлэх арга хэмжээ авах санал гаргасан прокурорыг оролцогчдоос ЭХХШТ хуульд заасан прокурор ЭХХШ ажиллагаанд оролцож болохгүй тохиолдолд татгалзах санал гаргасныг дээд шатны прокурор шийдвэрлэх нь цаг хугацаа алдсан чирэгдэлтэй байсныг залруулж шүүх шийдвэрлэхээр нэмэлтээр тусгасан байна.

12.1 дүгээр зүйл. Дуудан ирүүлэх

6.....дуудан ирүүлж болно.

6.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудан ирүүлнэ.

Тайлбар: Өсвөр насны яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудан ирүүлж болно гэсэн сонгох эрх зүйн зохицуулалт буюу хууль ёсны төлөөлөгчөөр дуудахгүй байж болох зохицуулалтыг императив шинжтэй болгон зассан Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенци, олон улсын гэрээнд нийцүүлсэн өөрчлөлт байна.

12.4 дугаар зүйл. Эрэн сурвалжлах ажиллагаа

1. Мөрдөгч дараахь хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулна:

1.6. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, **мал, амьтан**, баримт бичиг, тээврийн хэрэгсэл.

2. Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага **шүүх**, прокурорын шийдвэрийн дагуу яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг **шүүх**, прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна.

Тайлбар: Мөрдөгч, прокурор эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад мал амьтан нь эд зүйл, хөрөнгө гэсэн ойлголтод хамаарахгүй байсан учраас мал амьтан гэж нэмсэн байна.

Эрэн сурвалжлах эрх бүхий байгууллага, прокурорын шийдвэрийн дагуу яллагдагчийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг гагцхүү прокуророос тогтоосон хугацаанд танилцуулахаар байсныг шүүхийн тогтоосон хугацаанд мөн танилцуулахаар эрх зүйн зохицуулалтыг өргөтгөжээ.

Шүүхээс эрэн сурвалжилж байгаа хүнийг эрэн сурвалжлах ажиллагаа хийгдэж байгаа эсэхийг тогтоох, нягтлах шаардлагын үүднээс энэхүү нэмэлтийг хийх болжээ.

13.1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл

6. Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэрийг цуцлах тухай албан тушаалтны санал, гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх, **прокурор** гэрч, хохирогчийг хамгаалах тухай шийдвэрээ хүчингүй болгож, өөрчилж болно.

Тайлбар: Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэрийг шүүх хүчингүй болгох, өөрчлөхөөр гаргасан нь прокурор шүүхийн өмнөх шатанд авсан гэрч хохирогчийг хамгаалах шийдвэр, түүнийг өөрчлөх хүчингүй болгохыг мөн л хуульд тусгахгүй бол хууль зүйн техникийн хувьд алдаатай байсныг залруулсан байна.

8. Гэрч, хохирогчийг хамгаалах **тухай прокурор**, болон хамгаалалтыг цуцлах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

Тайлбар: Энэхүү нэмэлтийн агуулга нь дээрхитэй адил гэрч хохирогчийг хамгаалах, цуцлах гагцхүү шүүхийн шийдвэрт бус прокурорын шийдвэрт ч гомдол гаргахаар тусгах ёстой байсан.

Гэвч хууль зүйн хувьд буруу байрлуулснаас өөр агуулга илэрхийлэгдэж байна. Зөв байрлуулвал агуулга нь зөв болж байна. Залруулбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон хамгаалалтыг цуцлах тухай **прокурор**, шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

11. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын бусад арга хэмжээг энэ хуульд заасан журмын дагуу хэрэглэнэ.

Тайлбар: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын бусад арга хэмжээг энэ хуульд заасан журмын дагуу хэрэглэнэ гэж хоёр хуулийн уялдаа холбоог хангаж өгсөн байна.

14.3 дугаар зүйл. Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ

1. Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан хувийн баталгаа гаргах яллагдагч нь байнга оршин суух газрын хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг байна. /хүчингүй болсонд тооцсон./

Тайлбар: Энэхүү байнга оршин суух газрын хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг байх шалгуур нь энэхүү таслан сэргийлэх арга хэмжээг зарим нөхцөлд хэрэглэх боломжийг үгүйсгэсэн. Ийм учраас прокурор, мөрдөн шалгах байгууллагаас гаргасан саналын дагуу энэхүү хэсгийг хүчингүй болгосон байна.

14.4 дүгээр зүйл. Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан

сэргийлэх арга хэмжээ

5.Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ. **Тайлбар:** Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлэх нь шүүхийн өмнөх шатанд яллагдагчийн болон хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах шаардлагаас улбаатай байна.

14.6 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ

8.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Тайлбар: Барьцааны мөнгийг тусгай дансанд байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар буюу Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг энэхүү нэмэлтээр баталгаажуулсан байна.

14.9 дүгээр зүйл. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ

1.Шүүх дараахь үндэслэлийн аль нэг нь байвал яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргана:

1.3.гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;	1.3.гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;
--	--

Тайлбар: Гэмт хэрэг дахин үйлдэх талаархи үндэслэл бүхий баримт, мэдээлэл гэснийг гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт гэж өөрчилсөн нь 2002 оны ЭБШ хуульд “болзошгүй” гэсэн таамаглалаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэдэг гэсэн Хүний эрхийн комиссын тайлантай хэрхэн нийцэх эсэхийг тунгаана биз.

15.4 дүгээр зүйл.Хүсэлтийг хангах**15.4 дүгээр зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх**

Тайлбар: Хүсэлтийг шийдвэрлэх нь хангах, хэсэгчилэн хангах, татгалзах хэлбэрүүдэй учраас зүйлийн нэр явцуугаар өгөгдснийг залруулжээ.

15.7 дугаар зүйл.Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах

1.Оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаархи гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.

Тайлбар: Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ялангуяа төрийн байгууллага албан тушаалтанд гомдол гаргах, түүнийг шийдвэрлүүлэх эрхийг ноцтой зөрчих нэмэлт болсон байна. Шийдвэрийг хүлээн авснаас эсхүл мэдсэнээс хойш бус харин шийдвэр гарснаас хойш ажлын гурван хоногт иргэн гомдол гаргаж амжих эсэх нь туйлын эргэлзээтэй. Учир нь тухайн шийдвэрийг оролцогч мэдээд өмгөөлөгчдөө мэдэгдэх, өмгөөлөгч танилцах, гомдол гаргах гээд цаг хугацаа орох нь.

4.....3 хоногийн дотор Улсын ерөнхий прокурорын газарт гомдол гаргаж болохыг тайлбарлана.	4.Гомдол гаргагчид гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн, түүний үндэслэл, уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорын газарт гомдол гаргаж болохыг тайлбарлана.
---	--

Тайлбар: Мөн гомдлыг шийдвэрлэсэн талаар шууд УЕП-т гомдол гаргах зохицуулалттай байсныг өөрчилж дээд шатны буюу аймаг, нийслэлийн прокурорын газарт гомдол гаргахар өөрчилсөн байна.

15.8 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрт гомдол гаргах

3.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч дангаар гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч даруй хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр эцсийн байна.

Тайлбар: Шүүхийн өмнөх шат дахь шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг шийдвэрлэсэн Ерөнхий шүүгч эсхүл томилсон шүүгчийн шийдвэр эцсийн байна гэсэн нэмэлт орсон байна. Өөрөөр хэлбэл таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гомдол гаргасныг Ерөнхий шүүгч гомдлыг хангаагүй нөхцөлд дахин гомдол гаргахгүй болно.

17.1 дүгээр зүйл. Яллагдагч хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргах

3.Яллагдагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтэд хохирлоо нөхөн төлсөн баримт, **нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн тухай баталгааг** -ыг хавсаргана. **Тайлбар:** Яллагдагч хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн тухай баталгааг хавсаргаж байснаас яллагдагч шүүгдэгч хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлж баталгаа гаргаж байснаас хохирогч эвлэрдэггүй эсхүл хохирогч хохирлоос илүүтэй мөнгө эд зүйл нэхэх зэргээр хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлж байсан.

Иймд хүсэлтэд хохирлоо төлсөн баримт хавсаргах нь чухал боловч энэхүү хохирлын хэмжээг мөрдөгч, прокурор тогтоох эсэх хохирогч хохирол бүрэн төлсөн эсэх талаар гомдолтой бол хэрхэн шийдвэрлэх нь зэрэг асуудлууд үлдэж байна.

17.2 дугаар зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх

1.Прокурор, мөрдөгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан яллагдагчид **Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх** тухай болон энэ бүлэгт заасан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг танилцуулна.

Тайлбар: Эрүүгийн хуулиас

5.5 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял

4.**Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний** гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

6.7 дугаар зүйл.**Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх**

17.3 дугаар зүйл.Прокурорын хяналт

1.Прокурор хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай даруй танилцаж, дараахь нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянана:

1.2.Гэмт хэрэг үйлдсэн нь нөтлөх баримтаар тогтоогдсон өсөж;

1.2.Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасан нөхцөл хангагдсан эсэх;

3.Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзвэл хэргийн зүйлчлэл, түүнд оногдуулах ялын төрөл, хэмжээ, эсхүл ялаас чөлөөлөх, эсхүл ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналыг яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулж, яллагдагч зөвшөөрвөл гарын үсэг зуруулж, яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд даруй шилжүүлнэ.

Тайлбар: Эрүүгийн хуулиас:

5.3 дугаар зүйл.Торгох ял

4.Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.

5.4 дүгээр зүйл.Нийтэд тустай ажил хийлгэх ял

2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.

5.5 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах ял

4.Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх энэ хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

6.7 дугаар зүйл.**Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх**

Прокурор хэргийн зүйлчлэл, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаархи саналыг яллагдагчид танилцуулж байсныг өөрчилж яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулахаар болсон нь эрүүгийн хэрэгт заавал өмгөөлөгч оролцох тохиолдол биш байсан ч хялбаршуусан журмаар хэргээ шийдвэрүүлэх ялагдагч заавал өмгөөлөгчтэй байх шинжийг агуулжээ.

17.4 дүгээр зүйл.Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам

2.Шүүх тухайн хэргийг шууд хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл хүлээн авсан даруй, эсхүл 7 хоногийн дотор ял оногдуулах шүүх хуралдаан зарлан явуулж болно.

4.3.прокурорын сонгосон ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн эсэх;

4.4.хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг зөвшөөрсөн эсэх;

Хучингүй болсонд тооцсон.

4.5.гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, **нөхөн төлөхөө илэрхийлсэн, хохирогчтой эвлэрсэн эсэх;**

5. Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн **5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд** заасныг баримтлан прокурорын саналын хүрээнд **шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр** эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргана.

Тайлбар: Шүүх тухайн хэргийг шууд хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл хүлээн авсан даруй шүүх хуралдаан зарлан явуулж болно гэж заасныг **“эсхүл 7 хоногийн дотор ял оногдуулах”** гэж эцсийн хугацааг хуанлийн хоногоор хуульчлан тогтоожээ.

Урьд нь гагцхүү прокурорын сонгосон ялыг хүлээн зөвшөөрсөн эсэхийг шүүх хянаж байсан бол цаашид ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн эсэхийг хянаж улмаар хохирогчтой эвлэрсэн эсэхийг хянах шаардлагагүй болсон байна.

Прокурор хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай даруй танилцаж Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасан нөхцөл хангагдсан эсэх хянаж гаргасан прокурорын саналын хүрээнд шүүгдэгчийн **эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр** эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргахаар нэмэлт оруулсан байна.

Энэ нь прокурорын саналын хүрээнд буюу яллагдагч, түүний өмгөөлөгчийн тохиролцсон зөвшөөрсөн нөхцлөөс хүндрүүлж ял оногдуулахгүй бөгөөд харин хөнгөрүүлж болно гэсэн агуулгыг илэрхийлж байна.

17.5 дугаар зүйл.Зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журам

Тайлбар: Энэ зүйлийг 2020.01.10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан ЭХХШТ хуулийн агуулгаар хялбаршуулсан мөрдөн байцаалт нь дараах 2 агуулгыг илэрхийлж байсан. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан агуулга
- хуулиар харъяалуулсан зарим төрлийн тодорхой хэргийг Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан шаардлага хангагдаагүй ч гэсэн шуурхай шийдвэрлэх

Хуулиар харъяалуулсан зарим төрлийн тодорхой хэргийг Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан шаардлага хангагдаагүй ч гэсэн шуурхай шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн байцаалт 14 хоног, прокурорын хяналт хэргийн байдлыг тал бүрээс бүрэн бодитойгоор тогтоох зарчмыг зөрчсөн гэх яллагдагч, түүний өмгөөлөгчдийн шүүмжлэлийг дагуулж ирсэн.

Иймд хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журмыг хүчингүй болгосон байна.

19.3 дугаар зүйл.Хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

4.Шүүх дараахь шийдвэр гаргана:

4.4.Шүүгдэгч сэтгэцийн эрүүл мэндийн улмаас хэрэг хариуцах чадваргүй ч эдгэрэх боломжтой гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулж, энэ зүйлийн 4.2, **4.3-т** заасан шийдвэрийг гаргах.

Тайлбар: ЭХХШХ-ийн 19.3 дугаар зүйл.Хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

4. Шүүх дараахь шийдвэр гаргана:

4.2.гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн эрүүл мэндийн улмаас хэрэг хариуцах чадваргүй нь тогтоогдсон шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахаар байвал эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлэх;

4.3.гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахааргүй бол эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох;

ЭХХШТ хуулийн 19.3 дугаар зүйлийн 4.3 дахь заалтыг хассан нь давхардсантай холбоотой байна.

21.5 дугаар зүйл.Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэх

6.Хавтаст хэргийн материал, хураан авсан, **битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг** хүлээн авах, хадгалах, шилжүүлэх, **хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгох, улсын орлого болгох** болон энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4-т заасан ажиллагааны журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

Прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд мөрийн баримт, гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь олгох, эсхүл улсын орлого болгуулахаар шүүхэд санал гаргаж шийдвэрлүүлнэ.

Тайлбар: Прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд мөрийн баримт, гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь олгох, эсхүл улсын орлого болгуулахаар шүүхэд санал гаргаж шийдвэрлүүлнэ гэсэн өгүүлбэрийг энэ зүйлд нэмэлтээр оруулжээ.

24.5 дугаар зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах

1.Мөрдөгч байгууллага, хувь хүний нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.	1.Мөрдөгч төрийн нууц, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.
2.Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авч болно.	2.Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авч болно.
<p>Тайлбар: Байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл, баримтыг прокурорын зөвшөөрөл шаардахгүй. Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авч болно.</p> <p>Хувь хүний нууцын тухай хуулиас: 2-р зүйл.Хувь хүний нууцын тухай ойлголт "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.</p> <p>4 дүгээр зүйл.Хувь хүний нууцын төрөл</p> <p>1.Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/захидал харилцааны нууц; 2/эрүүл мэндийн нууц; 3/хөрөнгийн нууц; 4/гэр бүлийн нууц; 5/хуулиар тогтоосон бусад нууц. <p>2.Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно:</p> <ol style="list-style-type: none"> 1/захидал харилцааны нууцад захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг; 2/эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг; 3/хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг; 4/гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг. <p>Мөрдөгч прокурорын зөвшөөрөл авахаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авч болно.</p>	

<p>26.1 дүгээр зүйл Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах</p> <p>1.Мөрдөгч гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нууц, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараахь ажиллагаа явуулна:</p>
<p>1.1. үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах;</p>
<p>1.2. үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.</p>
<p>Тайлбар: Санхүүгийн зах зээлд өрийн хэрэгсэл гэдэг нэр томъёо бий болсон төдийгүй хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах тохиолдод Улсын бүртгэл болон тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хянах, зохих байгууллагад даалгах шаардлагатай тул нэмэлтээр оруулсан байна.</p>

<p>26.7 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагааны журам</p> <p>2.Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 10.1 /Хүнийг алах/, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг /Хүчиндэх/,-т заасан гэмт хэргийг илрүүлэхээс бусад үндэслэлээр цагдан хорих байранд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.</p> <p>Тайлбар: Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн нөхцөлд энэхүү гэмт хэргийг илрүүлэхээр мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж болно гэж нэмэлтээр оруулжээ. Гэмт хэрэг илрүүлэхийн тулд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенциор эрүү шүүлт гэж үзсэн атлаа дээрхи хэргүүдийг илрүүлэхийн тулд хүнийг хорьж, улмаар хорих байранд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байна.</p>
--

29.2 дугаар зүйл.Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах

9.Нэг үйлдэлд хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна.
Тайлбар: Нэг үйлдэлд хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна гэсэн нь нэг үйлдэлд нэг л хариуцлага гэсэн ойлголттой холбоотой билээ.

30.3 дугаар зүйл.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл гаргах

2.Биечлэн, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан гаргасан гомдол, **мэдээллийг** тэмдэглэл үйлдэж хүлээн авах ба түүнд тэмдэглэл үйлдсэн хүн гарын үсэг зурна.

3.Бичгээр гаргасан гомдол, **мэдээлэлд** гомдол гаргагч, эсхүл мэдээлэл өгсөн хүн гарын үсэг зурсан байна.

4.Санаатайгаар худал мэдээлбэл хүлээлгэх хариуцлагын талаар гомдол гаргагчид тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусган гомдол, **мэдээлэл** гаргагчаар гарын үсэг зуруулна.

Тайлбар: Энэхүү гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг гаргах журам гэсэн нэртэй зүйлийн доторхи агуулга гагцхүү гомдол гэж бичигдсэнээр мэдээлэл гаргаж буй иргэн, албан тушаалтаны мэдээлэл гаргах процесс журамлагдаагүй хууль зүйн техникийн алдааг залруулжээ.

30.7 дугаар зүйл.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах

1.Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадна дараахь мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно:

1.3.**хохилогч**, гэрчээс мэдүүлэг авах;

1.6 Шинжээч томилох;

2. Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно;

Тайлбар: ЭХХШТ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт гэснийг хассан нь мөрдөгч прокурорын зөвшөөрөлтэй явуулах мөрдөн шалгах ажиллагаанаас бусад ажиллагааг бие даан хэрэгжүүлэх бөгөөд гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг энэхүү хуулийн заасан 30.7 дахь зүйлд заасан ажиллагааг хязгаарлажээ.

Гэмт хэргийн талаар гомдол гаргасан хүнийг хохирогчоор мэдүүлэг авалгүй эхэлж гэрчээр авсны дараа хэрэг бүртгэлтийн хэрэг нээж байж хохирогч байх шаардлагатай гэж прокурор, мөрдөгч энэхүү хэсгийг амьдралд хэрэгжүүлсэн.

ЭХХШТ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах мажиллагаанд хохирогчоор тогтоох түүнээс мэдүүлэг авах ажиллагаа багтаж л байсан.

- Хэрэг бүртгэлт бол ЭБШ хуулийн дагуу мөрдөгдөж байсан гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах ажиллагаа гэдгийг одоог хүртэл ойлгохгүй л байна.

- Ийм учраас гэмт хэргийн гаралтыг бүртгэлийн системээр хянасан сэтгэлгээний уршгаар заавал шинжээчийн дүгнэлт гарсны дараа хэрэг бүртгэлтийн хэрэг нээх нь.

- Одоо 5 хоногоо нэг удаа 14 хүртэл хоногоор Албаны даргаар сунгахаар зохицуулсан нь буцаад ЭБШ хууль үйлчилж байсан гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг хүлээн авах шалгах зохицуулалттай ижилсүүлэх нь. Тухайлбал, 150000 гомдол, мэдээллээс 30000 нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээнэ. 120000 гомдол, мэдээллийг 14 хоногийн хугацаанд хэрхэн шалгасан бол гэдэг л хүний эрхийн асуудал мөн.

30.8 дугаар зүйл.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гаргах шийдвэр

3.Мөрдөгч энэ зүйлийн 1.2-т заасан саналыг прокурорт 72 цагийн дотор хүргүүлнэ.

Тайлбар: Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээх эсхүл хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах болон харьяаллын дагуу шилжүүлэх саналыг саналыг прокурорт 72 цагийн дотор хүргүүлнэ гэсэн нэмэлтийн хууль зүйн учир холбогдол дүгнэгдэхгүй байна. Тухайлбал, Мөрдөгч яагаад саналаа гаргачихаад прокурорт хүргүүлэхгүй байдаг юм бэ гээд үзвэл хэрэг бүртгэлтийн хугацаандаа захирагддаггүй юм уу энэхүү гомдол, мэдээллийн хугацаанд энэ 72 цаг орох эсэх, хугацаа дуусвал үргэлжлүүлээд өгч байгаа хугацаа юм уу гэд олон асуулт гарч байна. Гагцхүү орон нутагт нутаг дэвсгэрийн онцлогтойгоор л тайлбарлаж болох бизээ.

30.10 дугаар зүйл.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах

1.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байхгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон бол прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзана.

1.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн **хэрэг нээх** үндэслэл байхгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон бол прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзана.

3.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тухай гомдол, мэдээлэл гаргагчид **мөдөгдөнө**–мөдөгдэх ба энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан прокурорын шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

4.Мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурор хянаж, 7 хоногийн дотор

<p>шийдвэрлэнэ.</p> <p>5.Прокурор энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг хянаад үндэслэлгүй гэж үзвэл дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.;</p> <p>5.1.гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дахин шалгуулахаар буцаах;</p> <p>5.2.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;</p> <p>5.3.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах.</p>
<p>Тайлбар: Хууль зүйн техникийн хувьд хийгдсэн засвар мэт харагдаж байгаа боловч агуулгын чухал ач холбогдолтой байна. Энэхүү эрүүгийн хэрэг үүсгэх гэдэг үгнээс болж хэрэг бүртгэлт гэдэг нь гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгаж, хянаж байгаа үе шат гэдэг ойлголт үгүйсгэгджээ.</p> <p>Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан прокурорын шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно гэсэн агуулга хуучин ЭБШ хуульд ч байсан.</p> <p>Мөрдөгчийн саналыг прокурор 7 хоногийн дотор шийдвэрлэхээр бөгөөд мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг хянаад үндэслэлгүй гэж үзвэл дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:</p> <ul style="list-style-type: none"> - гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дахин шалгуулахаар буцаах; - хэрэг бүртгэлтийн хэрэг нээх; - эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах. <p>Гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг дахин шалгуулахаар буцаах тохиолдолд шалгах хугацаа бий эсэхийг прокурор нягтлах нь зүйн байна.</p>

<p>30.13 дугаар зүйл.Хэрэг бүртгэлтийг дуусгах</p> <p>1.Мөрдөгч хэрэг бүртгэлтийг дуусгаж, дараах саналын аль нэгийг гаргаж хэргийн хамт ажлын 3 өдрийн дотор прокурорт хүргүүлнэ:</p> <p>1.1.хэрэг бүртгэлтийн хэргийг хаах;</p> <p>1.2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах.</p>
<p>Тайлбар: Хууль зүйн техникийн хувьд 2 биш нэг л санал гаргах юм байна гэдгийг тодотгож энэ санал албажсаны дараа ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.</p> <p>Тодруулга, Хэрэг бүртгэлтийн хугацаа дууссанаас хойш дахин 3 хоног өгөөд байна уу эсхүл мөрдөгч саналаа гаргачихаад хэрэг бүртгэлтийн хугацаагаа дуусгах гээд прокурот хэргээ шилжүүлэхгүй байна уу гээд дээрхитэй адил асуулт гарч байна.</p>

<p>30.15 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал хүргүүлэх</p> <p>2.Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор үндэслэл бүхий дараахь шийдвэр гаргана:</p> <p>Тайлбар: Гэтэл мөрдөгчийг орон гаран аль нэгийг гэж бичихгүй бол 2 санал зэрэг бичнэ гэж хуульд нь нэмэлт оруулж байгаа бол хууль зүйн техникийн хувьд прокурор үндэслэл бүхий 3 шийдвэрийг зэрэг гаргана гэж далийлгаж тайлбарлах хуульч байна. Гэхдээ прокурор мөрдөгчийн саналыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор үндэслэл бүхий шийдвэрээ гаргана.</p>
--

<p>31.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах</p> <p>4.Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 6 12 цагийн дотор явуулна.</p> <p>Тайлбар: Сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагаа 12 цаг болгож уртасгасан нь хэрэг болгоныц ээдрээ төвөгтэй, яллагдагчийн хувийн байдлыг тогтоох баримт цуглуулахтай холбоотой билээ.</p>
--

<p>31.8 дугаар зүйл. Баривчлагдсан Сэжигтний эрх</p> <p>1.Баривчлагдсан сэжигтэн дараахь эрхтэй:</p>	<p>1. Сэжигтэн дараахь эрхтэй:</p>
<p>Тайлбар: Хойшлуулшгүй тохиолдол блон шүүхийн зөвшөөрөлтэйгээр баривчлагдсан сэжигтэн гэж явцуурууан ойлгогдож байсан учраас дуудагдан ирсэн сэжигтний эрх гэж дахин томъёолохгүйн тулд “Баривчлагдсан” тодотголыг хасчээ.</p> <p>Гэхдээ дуудагдан ирсэн сэжигтэнд баривчлагдсан сэжигтний эрхтэй /Мирандагийн зарчим/ танилцах боломжгүй байна. Энэ нь хуулийн үзэл баримтлалаар дуудагдан ирсэн сэжигтэн ч эрх чөлөө нь хязгаарлагдсан буюу баривчлагдсан категорит хамаарч байсан боловч ЭБШ хуулийн нийгмээс тусгаарлах байранд саатуулагдсан хүнийг ойлгож байснаар тайлбарлах шаардагатай болжээ.</p>	

<p>31.13 дугаар зүйл.Мөрдөн байцаалтын хугацаа</p> <p>1 Мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа</p>	<p>1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй. Энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт</p>
---	---

<p>өнгөрвөл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоно.</p>	<p>заасны дагуу мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.</p>
<p>Хавсралт: Эрүүгийн хуулиас</p>	
<p>2.Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно.</p>	
<p>5.Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна.</p>	
<p>6.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.</p>	
<p>Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиас</p>	
<p>1 дүгээр зүйл. 2020.01.10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 07.01-ний өдрөөс 2020.01.10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгана.</p>	
<p>2 дугаар зүйл. 2020.01.10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017.07.01-ний өдрөөс 2020.01.10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгана.</p>	
<p>3 дугаар зүйл. 2020.01.10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй.</p>	
<p>4 дүгээр зүйл.Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	
<p>Тайлбар: Дээрхи шийдлийн улмаас дараах нөхцөл байдлууд үүсч байна. Үүнд:</p>	
<p>- ЭХХШТ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль 2020 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн учраас 2020 оны 01 дүгээр сарын 10-наас 02 дугаар сарын 24-ний хооронд буюу 44 хоногийн хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болсон хэргүүд Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн үйлчлэлд үл хамаарахгүй байна.</p>	
<p>- Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолохоор материаллаг хууль болох Эрүүгийн хуульд тусгасан боловч ЭХХШТ хуульд “тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлдсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй” гэж хуульчилсан нь зөрчилдөөнийг бий болгожээ. Тухайлбал, зайлшгүй шаардлагаар эрүүгийн хэрэгт нотлох баримтууд цуглуулах байтал мөрдөн байцаалтын хугацааг сунгахгүй бол энэ хэргийг хэрхэн шийдвэрлэх вэ нэгдүгээрт яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлнэ хоёрдугаарт хөөн хэлэлцэх хугацаанаас өөр үндэслэлээр хэрэгсэхгүй болгоно.</p>	
<p>- ЭХХШТ хуулийн 29.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “ Нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар прокуророос буцаасан, түдгэлзүүлсэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээсэн бол өмнөх хугацаанаас нь үргэлжлүүлэн тоолж, хугацааг ердийн журмаар сунгана.” гэсэн агуулга хэвээр байгаа бөгөөд “... мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.” гэж дахин хуульчлах шаардлагагүй байсан байна.</p>	
<p>ЭХХШТ хуулийн 1.5 дугаар зүйлд 2, 3 дугаар хэсгүүдийг найруулан хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгох нөхцөлд шүүхээр эцэслэн шийдвэрлэх агуулгыг тусгах боломжтой байжээ. Энэ нь:</p>	
<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас</p>	
<p>2.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад энэ зүйлийн 1.1-д заасан нөхцөл байдал илэрвэл шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргана.</p>	
<p>3.Энэ зүйлийн 1.1, 1.2-т заасан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосныг яллагдагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч энэ зүйлийн 1.3-т заасан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосныг яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн эс зөвшөөрвөл гомдлоо прокурор, шүүхэд гаргах ба шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулж, гэмт хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээд гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэнэ.</p>	

<p>32.2 дугаар зүйл.Хэргийг прокурорт шилжүүлэх</p>
<p>1.Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж дууссаны дараа холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.</p>

Тайлбар: Тодруулга, мөрдөн байцаалтын хугацаа дууссанаас хойш дахин 3 хоног өгөөд байна уу эсхүл мөрдөгч саналаа гаргачихаад мөрдөн байцаалтын хугацаагаа дуусгах гээд прокурорт хэргээ шилжүүлэхгүй байна уу гэдэг асуулт гарч байна.

32.9 дүгээр зүйл.Прокурор яллах дүгнэлт үйлдэх үед яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт оруулах

2.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилсөн бол яллагдагчаас дахин мэдүүлэг авна.

Тайлбар: ЭБШ хуульд байсан агуулга бөгөөд яллагдагчийн гомдол, хүсэлт гаргах эрхийг хангах улмаар түүний мэдэх эрхийг хангахтай холбоотой нэмэлт байна.

32.10 дугаар зүйл.Яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх

10.7.Яллагдагч яллах дүгнэлтийг гардаж авахаас татгалзвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, шаардлагатай бол дуу-дүрсний бичлэгээр баримтжуулж хэргийг шүүхэд шилжүүлнэ.

10.8.Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг шүүхэд шилжүүлнэ.

Тайлбар: Яллагдагч яллах дүгнэлтийг гардаж авахаас татгалздаг олон тохиолдолд амьдралд тулгарсан. Энэ тохиолдолд түүнийг эрхийг нь хангасан эсэхийг хэрэгт баталгаажуулах шаардлагатай хэм хэмжээ үгүйлэгдсэн. Урд нь хуульд байхгүй ч хөндлөнгийн гэрч, эсхүл энэ тухай тэмдэглэл үйлдэж, шаардлагатай бол дуу-дүрсний бичлэгээр баримтжуулж байсан билээ.

Түүнчлэн яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийг шүүхэд шилжүүлээгүй байхад яллагдагч, түүний өмгөөлөгчдөөс гомдол, хүсэлт гаргасныг прокурор шийдвэрлэхээр байсан нь цаг хугацаа алдан хэргийг шүүхэд шилжүүлэх эсхүл яллах дүгнэлтэд нэмэлт өөрчлөлт оруулах нөхцлийг бий болгож байсан учраас яллах дүгнэлттэй холбоотой гомдол, хүсэлтийг прокуророос шүүхэд шилжүүлэхээр болсон нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүгээр нэг мөр шийдвэрлэх агуулгатай байна.

33.3 дугаар зүйл.Хэргийг прокурорт буцаах

2.Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.

Тайлбар: Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор л эс зөвшөөрвөл эсэргүүцэл бичлэг байсныг өргөжүүлэн яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан гомдол гаргах эрхтэй байхаар өөрчлөн найруулжээ.

34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

6.Өсвөр насны шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.

Тайлбар: 34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

2.Шүүх хуралдааныг дараахь тохиолдолд бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулна:

2.1.төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;

2.2.өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;

2.3.арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх;

2.4.хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах.

34.16 дугаар зүйл.Шүүх хуралдааныг хойшлуулах

4.Шүүгдэгч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэг дахин үйлдсэн, эсхүл урьд нь үйлдсэн өөр гэмт хэрэг илэрсэн нь хэргийн бодит байдлыг тогтооход нөлөөлөхгүй бол шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

Тайлбар Гэмт хэрэг үйлдсэн нь шийдвэрлэх гэж буй хэргийн бодит байдлыг тогтооход нөлөөлөхгүй түүнчлэн ЭХХШТ хуулийн 29.2 дугаар зүйл 1 дэх хэсэгт “...нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол үйлдэл тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулна.” гэж заасан Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйл.Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах.

1.Ялтан оногдуулсан ялыг эдэлж дуусахаас өмнө шинээр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдсон бол тухайн гэмт хэрэгт нь ял оногдуулж, өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно.

34.17 дугаар зүйл.Шүүх хуралдааныг хойшлуулах

6.Энэ зүйлд заасан түдгэлзүүлэх нөхцөл арилсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

Тайлбар: Шүүх дараахь шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хэрэгт холбоотой бусад шүүгдэгчийн хувьд шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ:

1.1.шүүгдэгч оргон зайлсан бол түүнийг олж ирүүлэх хүртэл;

1.2.шүүгдэгч сэтгэцийн, эсхүл өөр хүнд өвчний улмаас шүүхэд ирэх бололцоогүй нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдож байгаа бол түүний өвчнийг эдгэрэх хүртэл.

Энэхүү зүйлд түдгэлзүүлсэн хэргийг сэргээж үндэслэл, журам нь тусгагдаагүй байсан хууль зүйн техникийн алдааг залруулсан байна.

34.19 дүгээр зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгох

1.Шүүх дараахь үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоно:

1.1.гэмт хэргийн шинжгүй;

2.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана.

Тайлбар: Гэмт хэргийн шинжгүй үйлдэл, эс үйлдлийг хэрэг бүртгэлтэд бус харин шүүгдэгч тухайн гэмт хэргийг үйлдсэн нь нотлогдоогүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд хэргийг хэрэг бүртгэлтэд буцаах нь зүй бөлгөө. Харин Зөрчлийн тухай хуулиар зөрчлийн шинжтэй болон зөрчлийн хариуцлага хүлээлгэхээр тухайн зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх нь зүйтэй байна.

36.9 дүгээр зүйл.Шүүхийн цагаатгах тогтоол

4.Шүүгдэгч тухайн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй гэх үндэслэлээр цагаатгах тогтоол гарсан бол холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаана.

Тайлбар: ЭХХШТ хуулийн 34.19 дүгээр зүйлд гарсан хууль зүйн техникийн алдааг залруулж зохих хэсэгт нь нэмэлтээр оруулсан байна. Жишээлбэл, хүнийг санаатай алах гэмт хэргийн шүүгдэгч Ж тухайн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй гэх үндэслэлээр цагаатгах тогтоол гарсан бол энэхүү гэмт хэргийг дахин хэн үйлдсэн гэдгийг тогтоолгохоор Цагдаагийн байгууллагад шилжүүлэх нь байна.

37.5 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

37.5.Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих

1.Прокурор хорих байгууллагын төдөрхөйлөлт, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн Эрүүгийн хуулийн 6.11 дүгээр зүйлд заасан ялтны хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих тухай дүгнэлтээ шүүхэд хүргүүлнэ.

2.Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дүгнэлтийг хянан хэлэлцэж шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэрт зорчих эрхийг хязгаарлах ялын эхлэх, дуусах хугацааг төдөрхөй-заана.

3.Шүүхээс хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих шийдвэр гаргасан бол шийдвэрийг хүчин төгөлдөр болсон даруй тухайн ялтныг суллаж, хувийн хэргийн хамт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

4. хорих байгууллагын захиргаа хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар сольсон шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн ялтныг суллаж, хувийн хэргийн хамт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

5.хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар сольсон хугацаанд хорих ялын үндсэн хугацаа дууссан бол ялтны энэ хуульд заасан журмын дагуу суллаж прокурорт мэдэгдэнэ.

37.5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

2.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

4.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

6.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

Тайлбар: Эрүүгийн хуулиас

6.11 дүгээр зүйл.Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих

/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

1.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэгт шийтгүүлсэн хүний хорих ялыг дараах үндэслэлээр зорчих эрхийг хязгаарлах ялаар сольж эдлүүлж болно:

1.1.жирэмсэн эмэгтэйд төрөхөөс өмнө гурван сар, төрснөөс хойш хоёр жил хүртэл;

1.2.ганц бие эцэг, эхийг хүүхэд нь хоёр нас хүртэл.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл арилмагц ялтны зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг хорих ял эдэлсэн хугацаанд тооцож эдлээгүй үлдсэн хорих ялыг эдлүүлнэ.

3.Энэ хуулийн тусгай ангид таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн ялтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлсөн, хөр уршгийг арилгасан бол шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хөр уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан эдлээгүй үлдсэн хорих ялаас чөлөөлж болно.

Иймд ЭХХШТ хуулийн 37.5 дугаар зүйл /Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих/ хүчингүй болох ёстой байсан бөгөөд Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн **7.6 дугаар зүйл /Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах/-** агуулга нь ЭХХШТ хуульд журам нь тусгагдаагүй байсныг журамлажээ.

37.11 дүгээр зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх үндэслэл

1.**Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих**, торгох, нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар солих, түүнчлэн тогтоол биелүүлэх үед гарсан ямар нэг тодорхой биш зүйлийг тодруулах асуудлыг уг тогтоол гаргасан шүүх тухайн асуудлыг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, **хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар** солих, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох, хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх асуудлыг уг тогтоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр тогтоол биелүүлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

Тайлбар: ЭХХШТ хуулийн 37.5 дугаар зүйлд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих тухай журамлажээ. Тухайлбал, прокурор хорих байгууллагын тодорхойлолт, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн Эрүүгийн хуулийн 6.11 дүгээр зүйлд заасан ялтны хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих тухай дүгнэлтээ шүүхэд хүргүүлнэ гэжээ заасан тул энэхүү зүйлээс хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих агуулгыг хасжээ.

37.12 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх журам

4.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, **хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар** солих, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

Тайлбар: Эрүүгийн хуулийн 6.11дүгээр зүйл хүчингүй болсон мөн ЭХХШТ хуулийн 37.5 өөрчөн найруулсан мөн 37.11 дүгээр зүйлийн агуулгаас хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солихыг хассантай холбоотой энэхүү хасалтыг хийжээ.

38.4 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхэд хэрэг хүргүүлэх

2.Давж заалдах шатны шүүхэд ирсэн хэргийг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгчид хуваарилна.

Тайлбар:Шүүхэд шүүгч хараат бус байх, халдашгүй байх явдлыг хангах зоригор Ерөнхий шүүгчийн хэрэг хуваарилдаг зарчмыг 2017 онд ЭХХШТ хуульд анхан, хяналтын шатанд халж Шүүхийн багц хуулийн үзэл баримтлалтай нийцүүлсэн билээ.

39.4 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэрэг хэлэлцэх

3.Илтгэгч шүүгч тухайн хэргийн болон шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулна.

3.Илтгэгч шүүгч тухайн хэргийг илтгэж, шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулна.

Тайлбар: Эхлээд тухайн хэргийг илтгэж, шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулах дараалалд оруулсан байна. Өмнөх заалт нь хэргийг илтгэхдээ ч өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулахаар байсан.

39.9 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхийн шийдвэр

1.Давж заалдах шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1.4.хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах; /Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

Тайлбар: /Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр "... эсхүл хүндрүүлж ..." гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./

1.5.Энэ хуулийн 36.8 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9-д заасан шийдвэрт өөрчлөлт оруулах.

Тайлбар: хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах гэдэгт ЭХХШТ хуулийн 1.5 дахь агуулга бүхэлдээ багтсан гэж үзэж хүчингүй болгожээ.

ЭХХШТ хуулиас

36.8 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэг

1.Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт дараах зүйлийг тусгана:

1.3.хорих ял оногдуулсан хүний ял эдлэх хорих байгууллагын дэглэм;

1.4.шүүгдэгч нь шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө баривчлагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хугацааг ял оногдуулахдаа хэрхэн тооцсон;

1.5.шүүхийншийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болтол шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх тухай;

1.6.гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ял оногдуулах, эсхүл хохирогчид хохирол, хор уршгийг нөхөн төлж барагдуулах бол мөнгөн төлбөр, хохирол барагдуулах ажиллагааг ямар хугацаанд, ямар хэмжээгээр хийх;

1.7.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэлэлцэхгүй орших үндэслэл;

1.8.хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх тухай;

1.9.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хуваарилсан тухай.

40.1 дүгээр зүйл.Хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргах

1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт **дараах үндэслэлээр** оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон.

1.2.Энэ хуулийн 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг гардуулсан, эсхүл хүргүүлснээс хойш **30 14 хоногийн** дотор хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болно.

3.Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол, эсэргүүцэл гаргана:

3.1.шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

3.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон.

9.Өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ урьдчилан танилцуулсан байна.

10.Өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлоосоо өмгөөлж байгаа хүнийхээ зөвшөөрөлгүйгээр татгалзаж болохгүй.

Тайлбар: ЭХХШТ хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1, 3 дугаар зүйлийг нэгтгэн системчилсэн учраас 1.3 дахь хэсгийг хүчингүй болгосон бөгөөд агуулгын хувьд ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд хяналтын журмаар 30 хоногийн дотор гомдол, эсэргүүцэл гаргадаг байсныг богиносгож 14 хоног болгосон нь өмгөөлөгч, прокурор шуурхай ажиллах шийдвэр гаргах ёстой болжээ.

Гэгцхүү өмгөөлөгч гомдол гаргахын тулд өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ урьдчилан танилцуулсан байх нь оролцогчийн /шүүгдэгч, хохирогч гэх мэт/ зөвшөөрлөөр байх ёстойг илэрхийлжээ. Энэ нь шүүгдэгч, хохирогчийн мэдээлэлтэй зөвшөөрөлгүй бол өмгөөлөгч хяналтын журмаар гомдол гаргах боломжгүй байна. Мөн өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзах эрхтэй боловч өмгөөлж байгаа хүнийхээ зөвшөөрөлгүйгээр татгалзаж болохгүйг хуульчлан баталгаажуулжээ.

40.2 дугаар зүйл.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авах

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан **шүүгчийн шийдвэрийг гомдол, эсэргүүцэл гаргагч эс зөвшөөрвөл 10 хоногийн дотор** Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг **3 шүүгчийн** бүрэлдэхүүнтэй **14 хоногийн дотор** хэлэлцэж шийдвэрлэнэ. **Энэхүү шийдвэр эцсийн байна.**

Тайлбар: Хяналтын журмаар оролцогч гомдол, прокурор эсэргүүцэл бичсэнийг шүүгчийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүй тухай шийдвэрт оролцогч, прокурор эс зөвшөөрсөн тохиолдолд түүнийг 10 хоногт УДШ гомдол гаргаснаар 14 хоногт хэлэлцэж энэ нь эцсийн шийдвэр байхаар өөрчлөн найруулсан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн жишигтэй адил байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

40.2 дугаар зүйл.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авах

5.Шүүгч дараах үндэслэл тогтоогдвол гомдол, эсэргүүцлээр хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргана:

- 5.1.гомдол, эсэргүүцэл нь энэ хуулийн 40.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;
- 5.2.гомдол, эсэргүүцэл гаргагч нь хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргах эрх бүхий хүн, хуулийн этгээд биш;
- 5.3.гомдол, эсэргүүцэл гаргах хугацаа хэтэрсэн;
- 5.4.хяналтын шатны шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудалд хамаарахгүй;
- 5.5.тухайн хэргийг урьд нь хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэр хүчинтэй байгаа;
- 5.6.гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан.

40.6 дугаар зүйл. Хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэх

3.Илтгэгч шүүгч тухайн хэргийг илтгэж, шүүхийн шийдвэр болон хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн агуулгыг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулна.

Тайлбар:Эхлээд тухайн хэргийг илтгэж, шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулах дараалалд оруулсан байна. Өмнөх заалт нь хэргийг илтгэхдээ ч өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулахаар байсан.

40.8 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэр

1.7.энэ хуулийн 36.8 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9-д заасан шийдвэрт өөрчлөлт оруулах.

Тайлбар: хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах гэдэгт ЭХХШТ хуулийн 1.5 дахь агуулга бүхэлдээ багтсан гэж үзэж хүчингүй болгожээ.

ЭХХШТ хуулиас

36.8 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэг

1.Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт дараахь зүйлийг тусгана:

- 1.3.хорих ял оногдуулсан хүний ял эдлэх хорих байгууллагын дэглэм;
- 1.4.шүүгдэгч нь шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө баривчлагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хугацааг ял оногдуулахдаа хэрхэн тооцсон;
- 1.5.шүүхийншийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болтол шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх тухай;
- 1.6.гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ял оногдуулах, эсхүл хохирогчид хохирол, хор уршгийг нөхөн төлж барагдуулах бол мөнгөн төлбөр, хохирол барагдуулах ажиллагааг ямар хугацаанд, ямар хэмжээгээр хийх;
- 1.7.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэлэлцэхгүй орхих үндэслэл;
- 1.8.хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх тухай;
- 1.9.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хуваарилсан тухай.

40.12 дугаар зүйл.Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр

1.Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, **өөрчлөх** эсэх асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Тайлбар: Улсын дээд шүүхийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хяналтын шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгох, хэвээр үлдээх шийдвэрийг гаргадаг байсныг нэмж шүүхийн тогтоолд өөрчлөлт оруулах эрхийг хуулиар оруулсан нь хүчингүй болгож дахин хяналтын шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй байх боломжийг бүрдүүлжээ.

ДЭЧИН ТАВДУГААР БҮЛЭГ. ЭХХША-НЫ ЯВЦАД ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧ /ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ/ ИЙН ХУУЛЬ ЗӨРЧСӨН АЖИЛЛАГААНЫ УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ АРИЛГАХ

45.1 дүгээр зүйл.Хохирол арилгуулах эрх

1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, **эрх бүхий албан тушаалтан**, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй.

Тайлбар: 2017 оны ЭХХШТ хуулиар эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэн нь учирсан эд хөрөнгийн хохирол болон сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах эрх нь нээгдсэн ч энэхүү өөрчлөлтөөр хасагдсан байна.

45.2 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл

1.Дараахь ажиллагааг хууль бусаар явуулсны улмаас тухайн хүнд учирсан хохиролыг мөрдөгч, **эрх бүхий албан тушаалтан**, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцаан арилгана:

1.1.баривчилсан;

1.Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, **цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм**

<p>1.2.таслан сэргийлэх арга хэмжээ авсан; 1.3.эмнэлгийн байгууллагад байлгасан; 1.4.албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн; 1.5.ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн.</p>	<p>бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.</p>
<p>2.Дараахь тохиолдолд хохирол нөхөн төлүүлэх эрх үүснэ: 2.1.яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан, 2.2.Хууль бусаар баривчилсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь тогтоогдсон, эсхүл баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийг хууль зөрчсөн үндэслэлээр хүчингүй болсон, 2.3.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр нь хууль бус гэдэг нь тогтоогдож хүчингүй болгосон, 2.4.яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон.</p>	<p>2.Хохирол нөхөн төлүүлэх эрх дараах тохиолдолд үүснэ: 2.1.хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсон; 2.2.тухайн хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан; 2.3.тухайн хэрэг нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон; 2.4.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон; 2.5.яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон.</p>
<p>Тайлбар: ЭХХШТ хуулийн 45.2 дугаар зүйлийн 1, 2 хэсгийг нэгтгэн өөрчлөн системчилсэн бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсны улмаас хүнд учирсан хохирлыг төр хариуцан арилгахаар байсныг хүчингүй болгосон. Харин ЭБШ хуульд байсан агуулгаар буцаан өөрчилсөн боловч эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцах агуулга тусгагдсан бөгөөд энэ хуулийн гэмт хэрэг үйлдсэн бол тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай хүнээр нөхөн төлүүлэхээс ангид авч үзсэн байна. Түүнчлэн гарчгийн үзэл баримтлалын дагуу эрх бүхий албан тушаалтан хасагдсан.</p>	

<p>45.6 дугаар зүйл. Хэргийг хэрэгсэхгүй болгосон Хууль зөрчсөн ажиллагааны тухай лавлагаа өгөх</p>	
<p>1.Цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон бол шүүх, прокурор нь хүн, хуулийн этгээдэд зөрчигдсөн эрхээ сэргээх болон бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж, хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу өөрийн гаргасан шийдвэрийн талаар тухайн хүн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авсан даруй түүний ажиллаж байгаа байгууллагад бичгээр лавлагаа өгнө.</p>	
<p>2.Хүнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, бусад таслан сэргийлэх арга хэмжээ авсан, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийсэн мэдээлэлдээ залруулга хийж, шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.</p>	
<p>Тайлбар: Лавлагаа өгөх тохиолдлоос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хасч хүчингүй болгосон нь ямар нэгэн мөрдөн шалгах ажиллагаа хийгдэх тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг прокурор, шүүх гаргах бөгөөд цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон гэдэгт хамаарах тулд давхардсан гэж үзсэн байна. Бусад таслан сэргийлэх арга хэмжээ авсан гэдгийг хасч гагцхүү цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан зэрэг нийгмээс тусгаарлах албадлага хэрэглэсэн тохиолдолд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийсэн мэдээлэлдээ залруулга хийхээр явцууруулжээ.</p>	

<p>45.7 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах</p>	
<p>1.Цагаатгах тогтоол гарсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон болон бусад хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчилсөн тухай тогтоолын хуулбарыг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хүнд гардуулан өгөх, эсхүл энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу шуудангаар илгээнэ. Тайлбар: Хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлахдаа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах шийдвэрийг хасч хүчингүй болгосон нь ямар нэгэн мөрдөн шалгах ажиллагаа хийгдэх тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг прокурор, шүүх гаргах бөгөөд цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон гэдэгт хамаарах тулд давхардсан гэж үзсэн байна.</p>	

45.9 дүгээр зүйл.Хохирол арилгуулах нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх

1.Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

Тайлбар: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхээр нэмсэн байна.

---o0o---

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХАД
АНХААРАХ АСУУДАЛ**

А.Амарсайхан

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа*

Товч агуулга: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгахдаа цагдаагийн албан хаагчдын үйл ажиллагаанд удирдлага болгон мөрдөх холбогдох хууль тогтоомжийг тухайлан авч үзсэн бөгөөд түүнчлэн, тодорхой ажиллагааг явуулахдаа анхаарах асуудлыг дурдсан болно.

Түлхүүр үг: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хойшлуулшгүй ажиллагаа

Цагдаагийн байгууллагын алба хаагчид ЦЕГ-ын даргын 2017 оны А/262 дугаар тушаалаар баталсан 220 код “Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах”, 2017 оны А/262 дугаар тушаалаар баталсан 311 код “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг шалгах” журмыг баримтлан ажиллана.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дуудлага мэдээлэл, сэжигтэй этгээдийг шалгахад “Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах”, “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг шалгах” тухай журмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгохоос гадна дараах зүйлийг анхаарна. Үүнд:

Цагдаагийн албан хаагч мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн талаар дуудлага мэдээлэл авсан, сэжигтэй этгээдийг эргүүл, шалгалтын үед илрүүлсэн тохиолдолд газар дээр нь нөхцөл байдлыг үнэлж жижүүрийн шуурхай бүрэлдэхүүнд мэдэгдэн, чиглэл авч хойшлуулшгүй тохиолдолд сэжигтэй этгээд, тээврийн хэрэгслийг шуурхай шалгах ажлыг зохион явуулна.

Мансууруулах бодис хэрэглэсэн этгээдийг шалгах, баривчлах, саатуулах үед тухайн этгээдийн амь нас, өөрийн болоод хамтрагчийн аюулгүй байдалд онцгой анхаарахаас гадна сэжигтэй этгээдийн үйлдлийг шуурхай хязгаарлаж, нэг бүрийн тусгай хэрэгсэл гав ашиглан хоёр гарыг хөдөлгөөнгүй байрлуулж, эд зүйл хаях, устгах болгоомж өгөхгүй байхад онцгой анхаарна. Учир нь энэ төрлийн гэмт хэрэгт эд мөрийн баримт буюу тухайн бодис, түүний хэрэглүүргүйгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг алддаг учир сэжигтэй этгээдүүд өөрийн бие, тээврийн хэрэгсэл, орон байрнаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон бусад эд зүйлээ ямар нэг аргаар хаях, устгахыг эрмэлздэг.

Сэжигтэй этгээд, тээврийн хэрэгслийг саатуулан шалгах үед сэжигтэй эд зүйлс, эм бодис илэрсэн тохиолдолд жижүүрийн шуурхай бүрэлдэхүүн дуудаж хэргийн газрын үзлэг хийж хэрэгт ач холбогдолтой эд мөрийн баримтуудыг илрүүлэн бэхжүүлж авах ажиллагааг явуулна. Ингэснээр эд мөрийн баримт устах, нотлох баримтын ач холбогдлоо алдах, гэмт этгээдэд ял завшуулахаас сэргийлж чадна.

Гэмт хэргийн газар үзлэг хийсний дараа сэжигтэй этгээдийн бие, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, орон байранд хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд үзлэг, нэгжлэг хийнэ.

Хойшлуулшгүй ажиллагааны гол зорилго нь эд мөрийн баримт болох мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийг хэрэглэхэд ашигладаг хэрэглүүр зэргийг олж илрүүлэх явдал юм.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн газрын үзлэгийг явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн⁶⁰ 23 дугаар бүлэгт дурдсан үзлэг явуулах ерөнхий нөхцөл, 23.2 дугаар зүйл. Хүний биед үзлэг хийх, 23.3 дугаар зүйл. Хэргийн газрын үзлэг, 23.4 дүгээр зүйл. Цогцост үзлэг хийх зэрэг чиглэл тус бүрээр үндэслэл, журамд нийцүүлсэн явуулна.

Хэргийн газрын үзлэгийг явуулахдаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.3 дахь хэсэгт заасан мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй гэх бодит үндэслэл байгаа бол хэргийн нотлох баримтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор орон байр, бусад газар, нийтийн эзэмшил газрын тодорхой хэсгийг хэргийн газраар тогтоон үзлэг хийх, түүнчлэн үзлэгийг хэргийн газраар тогтоосон орон

⁶⁰ Төрийн мэдээлэл 2017 он, УБ., №23

байр, бусад газраас гадна хэргийн газрын хамгаалалтын бүсэд байгаа хүн, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, цогцос зэргийг хамруулан хийх үндэслэлийг баримтлан дараах арга хэмжээг нийтлэг байдлаар хэрэгжүүлнэ.⁶¹ гэж хуульчилсан байгааг анхааран ажиллах хэрэгтэй.

Хэргийн газарт үзлэг хийж байгаа албан хаагч эд мөрийн баримтыг өөрийн дотоод итгэлээрээ үнэлэн хурааж авах ба тухайн эд зүйлийн бохирлогдсон байдал, шинж чанар зэргийг анхаарах нь зүйтэй. Шилэн бортого, зориулалтын шилэн гаанс, гар аргаар хийсэн “бонг” буюу хуванцар сав, соруул мэт болгосон мөнгөн дэвсгэрт гэх мэт зүйлд шинжилгээгээр мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис илэрдэг тул эд мөрийн баримтаар хураагдаж байгаа эд зүйлсийн битүүмжлэлийг сайтар хангах хэрэгтэй. Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтооход хамгийн чухал хийгдэх хойшлуулшгүй ажиллагаа бол хэргийн газарт байх эд мөрийн баримтууд дээрээс гарын мөр илрүүлж бэхжүүлж авах, хэргийн газарт байсан болон гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдүүдийн гарын дардасыг авах, бэхжүүлж авсан гарын мөрүүдтэй сэжигтэй этгээдүүдийн гарын дардастай харьцуулах шинжилгээ хийлгэх шаардлагатай байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4.1.26 дахь хэсэгт “Хойшлуулшгүй тохиолдол” гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг ойлгохоор хуулийн нэр томьёонд хуульчилсан бөгөөд хойшлуулшгүй тохиолдол гэж үзэн процессын ажиллагаа явуулах дараах тохиолдлыг хуульчилсан байна.

Хойшлуулшгүй ажиллагааны үед эрх бүхий албан тушаалтан доорх зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:

- Сэжигтэй этгээдийн бие, ачаа тээш, тээврийн хэрэгсэлд хийсэн үзлэгээр хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон түүнийг хэрэглэхэд ашигладаг /хэрэглэсэн зүү тариур, тугалган цаас, соруул, төрөл бүрийн гаанс, бортого гэх мэт/ хэрэглэлүүд илэрсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг явуулж, хураагдсан эд мөрийн баримтыг илтгэх хуудас, тэмдэглэлээр хүлээлгэн өгнө.
- Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг этгээдүүд нь ихэвчлэн нэг удаагийн хэрэглээний мансууруулах бодис буюу ойролцоогоор 0.5-1 граммаас илүүгүй хэмжээтэйгээр авч явдгийг анхаарч бие, ачаа тээш, тээврийн хэрэгсэл, үзлэг, нэгжлэг хийхдээ хэтэвч, халаас, цүнх, хувцасны оёдол, тамхи, чүдэнзний хайрцаг, гар утасны таг, зайны ар талын хэсэг, шашны эд зүйл, тээврийн хэрэгслийн суудлын дор, толиний ар гэх мэт нууж болох бүхий л газруудад нуудаг тул тухайн этгээд гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдахаа мэдсэн бол мансууруулах бодисыг биенээсээ зайлуулах, хаях, устгах арга хэмжээг авдаг.

Иймд баривчлах, саатуулах үед дээрх нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж хүн хүч, техник хэрэгслийг зөв байршуулах, баривчилгааны үед сэжигтэй этгээдийн хөдөлгөөнийг хязгаарлах, хоорондоо ярилцах, үгсэн тохиролцохоос сэргийлж нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглах /гав/, тусгаарлах арга хэмжээг хамгийн түрүүнд авах хэрэгтэй.

- Энэ төрлийн гэмт хэргийн онцлог нь эд мөрийн баримт болох мансууруулах бодис тухайн этгээдийн биенээс салснаар нотлох баримтын шинж чанараа алддаг нөхцөл байдал зарим хэрэгт ажиглагддаг тул үзлэг, нэгжлэгийг явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг чанд баримтлаж эд мөрийн баримт болох мансууруулах бодис, хэрэглүүр, зарж борлуулснаас олсон ашиг болох мөнгө зэргийг хураан авахдаа хөндлөнгийн гэрчийг заавал байлцуулах, эд мөрийн баримтыг хураан авах үйл ажиллагааны явцыг видео бичлэгээр давхар баримтжуулах нь зүйтэй.
- Монгол Улсын нэлээдгүй аймгийн нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах төрлийн зэрлэг олс буюу каннабисыг түүх, боловсруулах, хэрэглэх, зарж борлуулах гэмт хэрэг ихээр бүртгэгддэг тул үзлэг хийхдээ хар, бор, ногоон өнгийн гар аргаар хийсэн хатуу шахмал бодис, бор, ногоон өнгийн хурц үнэртэй ургамлын зүйлийг илрүүлэн шалгах, сэжигтэй этгээдүүд дээрх ургамалыг ганга, арц, шарилж гэх мэтээр тайлбарлан шашны зан үйл болон уламжлалт эмчилгээнд хэрэглэгддэг ургамлын гаралтай тан гэж эрүүгийн

⁶¹ МУ-ын ЭХХШтХуулийн 23.3.3 дахь хэсэг, Төрийн мэдээлэл УБ., 2017 он, №23

хариуцлагаас мултрах арга ашигладаг болохыг анхаарч ямар зүйл болохыг нь заавал лабораторын шинжилгээгээр тогтоолгох.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах⁶² аргачлал нь ЦЕГ-ын даргын 2017 оны А/262 дугаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 220-д тусгайлан тохиолдлыг тусгаж алба хаагчийн үйл ажиллагааны дэс дараалал, анхаарах асуудлыг системчлэн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, эсхүл үйлдсэн байж болзошгүй үндэслэл тогтоогдож байгаа хүн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах дэг горимыг тогтоож өгснөөрөө ач холболдол нь оршиж байна.

Мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа нэн тэргүүнд анхаарал хандуулах дараах ажиллагаа байна. Үүнд:

- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгахдаа хүний эрх, эрх чөлөөг дээдлэн эрүүл аюулгүй байдлыг хангасан, шинжлэх ухаан, техникийн ололтод түшиглэн олон улсын жишигт хэрэглэж байгаа багаж хэрэгслийг ашиглана.
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис эм, хэрэглэхийг энгийн аргаар тогтоож болох бөгөөд үүний тулд тухайн этгээдийг шулуун шугаман тэмдэгийн дагуу өөрийнх нь зөвшөөрснөөр алхуулж, тэнцвэрээ хэрхэн олж байгаа байдлаар нь магадлан, цаашид биологийн дээж авч, эсхүл бусад багаж хэрэгсэл ашиглан шинжилгээ хийлгэх асуудлыг шийдвэрлэж болно.
- Гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа хүний мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн эсэх талаар үндэслэл бүхий сэжиг байгаа тохиолдолд цаг хугацаа алдалгүй биологийн дээж авахуулан шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулна.
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсний улмаас тухайн этгээд хэвийн бус байгаа үед амьсгалын замын түгжрэл үүсэх, ухаан алдах зэргээс сэрэмжлүүлэхийн тулд идэвхтэй хяналт /мэдрэмжийг нь шалгах, сэргээх г.м/ тавина.
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг ердийн шалгагч багажаар тогтоох боломжгүй тохиолдолд эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагын туслалцаа авна.
- Шалгалтын явцад цугларсан баримт сэлт мэдээллийг үндэслэн согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн гэх газарт үзлэг хийнэ.
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн эсэхийг шалгагч багаж хэрэгслийг ашиглахдаа үйлдвэрлэгчээс ирүүлсэн зааврыг баримтална.

Хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгахдаа хордуулах бодис хэрэглэсэн шинж тэмдэг илэрсэн хүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээг авч, хордуулах бодис хэрэглэсэн байж болзошгүй тохиолдолд түүний орон байр холбогдох газруудад үзлэг хийж олдсон хордуулах бодис, түүний сав боодол, баглаа зэргийг шинжлүүлэхээр түр хураан авч, эмнэлгийн яаралтай тусламжийн ажилтанд мэдээллийг шуурхай өгч ажиллана.

Тухайн нутаг дэвсгэр, нэгжийг хариуцсан цагдаагийн байгууллагын дарга болон шуурхай удирдлагын албаны зохицуулагч нь хордуулах бодис хэрэглэсэн байж болзошгүй орон байр холбогдох газруудад жижүүрийн бүрэлдэхүүн үзлэг хийх үед хамгаалалтын хувцас, хэрэглэлээр хангаж, мэргэжлийн байгууллагыг оролцуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүргийг гүйцэтгэнэ.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис болон түүнийг хэрэглэсэн эсэхийг шалгахдаа мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн хүний нүдний хүүхэн хараа томорсон, гэрлийн тусгалд урвал өгөхгүй байх, сэтгэцийн байдлын онцлог, хэл яриа, хөдөлгөөний хэмнэл алдагдсан шинж илэрдэг. Тухайлбал, сэтгэцэд нөлөөт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үед хэт хөөрөл, сэтгэл санааны хямрал, уналтад орсон байдаг.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн байж болзошгүй этгээдийн биеийн хэсэгт тариурын ором байгаа эсэхийг шалгана.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хадгалсан байж болзошгүй хүн эд зүйл, ачаа тээшинд үзлэг, нэгжлэг хийхдээ албаны нохойг Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/210 дугаар тушаалаар батлагдсан “Албаны нохой бэлтгэх, ашиглах, хамгаалах журам-д заасны дагуу ашиглахыг анхаарах шаардлагатай байна.

⁶² ЦБҮАЖКод эмхэтгэл 2017, УБ.,

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журам болон үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хэрэглэнэ.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэсэн эсэхийг шалгахын өмнө тухайн этгээдээс эмчилгээний шугамаар мансууруулах эм, бэлдмэл хэрэглэсэн эсэхийг асууна.

Эмчилгээний зорилгоор хэрэглэсэн, хэрэглэдэг нь тогтоогдсон тохиолдолд энэ тухай тэмдэглэл үйлдэж баримтжуулалтыг эхэлнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон түүнийг хэрэглэсэн эсэхийг шалгах сэжиг бүхий үндэслэл байгаа тохиолдолд шалгагч хэрэгслийг ашиглан дараахь зүйлсээс дээж авч, зохих журмын дагуу шалган, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Үүнд:

- Хүний арьс, хөлс, шүлс, шээс, цус, үснээс;
- Эд зүйлс болон түүний гадаргуу, бодисоос.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис болон түүнийг хэрэглэсэн эсэхийг шалгах явцад шаардлагатай тохиолдолд хэд хэдэн багаж хэрэгслийг ашиглаж болно.

Шалгах ажиллагаа эхлэхийн өмнө тухайн этгээдэд ашиглах багаж хэрэгсэл, хэрхэн шалгах талаар тайлбарлан өгч, шалгагч, шинжлэгч багаж хэрэгслийн сав баглаа, боодлын бүрэн бүтэн байдал, баталгаажилтыг урьдчилан харуулах хэрэгтэй.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис болон түүнийг хэрэглэсэн эсэхийг шалгах ажиллагааны явцыг дүрс, дуу бүхий техник хэрэгслээр бэхжүүлж болно.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис болон түүнийг хэрэглэсэн эсэхийг шалгагч хэрэгслээр тогтоосны дараа, гарсан үр дүнг тухайн этгээдэд танилцуулна. Гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ тухай зохих журмын дагуу тэмдэглэл тусгах ёстой.

Ашигласан хэрэгслийг битүүмжлэн, сав баглаан дээр шалгуулагч этгээд болон хөндлөнгийн гэрч нарын овог, нэр, хаяг, утас, газар орон, цаг хугацааг дэлгэрэнгүй бичиж, ашигласан багаж хэрэгсэл болон алба хаагчийн талаарх мэдээллийг тусгана.

Цагдаагийн албаны тухай хуулийн 4.1. зүйлд “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.” гэж хуульчилжээ. Үүнээс улбаалан Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэргийг шалгах⁶³ алба хаагч тухайн хэргийг мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа үйл ажиллагаандаа баримтлах журмыг ЦЕГ-ын даргын 2017 оны А/262 дугаар тушаалаар баталсан байдаг.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэргийг шалгах тухай Эрүүгийн хуульд заасан хориглосон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүй болон худалдаалах зорилготойгоор хууль бусаар бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бусдад өгсөн гэмт хэргийг шалгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж 311 кодын хүрээг зөвхөн Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан гэмт хэргээр тодорхойлсон нь учир дутагдалтай тул энэхүү журмаар Монгол Улсын Эрүүгийн хууль⁶⁴-ийн 20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, 20.8 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах, 20.9 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших, 20.10 дугаар зүйл. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэсэн дөрвөн гэмт хэргийг мөрдөн шалгахдаа үйл ажиллагаандаа баримтлах шаардлагатай юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 4 гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа албан хаагч нь Монгол Улсын Үндсэн Хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг удирдлага болгон Цагдаагийн байгууллагын үйл ажилланааны журам-код 311-ийг үйл ажиллагаандаа баримтлан ажиллах шаардлага тулгарч байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн мөрдөн шалгахдаа гэмт хэргийн төрөл ангилалтыг харгалзан мөрдөгчид нь чиглэл тус бүрээр мөрдөх ерөнхий аргачлалд тулгуурлах нь гэмт хэргийг бүрэн дүүрэн илрүүлэх, нуугдмал гэмт хэргийг илрүүлэх, нуугдмал гэмт явдалтай тэмцэхэд ач холбогдол нь оршдог. Иймд дараах нөхцөл байдлыг энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахдаа анхаарвал зохионо. Үүнд:

⁶³ ЦБҮАЖКод эмхэтгэл 2017, УБ.,

⁶⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016 он, №7

Мансууруулах үйлчилгээтэй ургамлын тариалалт, тархацтай холбоотой гэмт хэргийг мөрдөх ажиллагаанд.⁶⁵

- Хар тамхи, мансууруулах бодис агуулсан ургамал хууль бусаар тариалдаг газруудыг нэрлэнэ үү? Уг газрын ерөнхий байдал, зорчин очих зам, ойр орчмын суурин газар, ямар төрлийн ургамалыг ямар хэмжээний талбайд тариалдаг эсэх;
- Хар тамхи, масруулах бодис агуулсан ургамал тариалсан хүний талаарх мэдээлэл, Хар тамхийг ямар этгээдүүд боловсруулдаг, хаана байрлан амьдарч орогнож байгаа газрыг тодорхойлох, мөн тэдний хүрээлэл;
- Дээр дурьдсан ургамалын үрийг ямар аргаар ямар нөхцөлөөр хаанаас ямар этгээдүүдээс олж авдаг;
- Тариалангийн талбайг хамгаалалтанд байлгадаг эсэх. Хэрэв хамгаалалтад байдаг бол ямар хүч, хэрэгслээр хамгаалдаг;
- Тухайн газрыг хариуцдаг албаны ажилтан хууль бус ургацын талаар мэддэг үү? Тухайн хууль бус тариалалтыг устгах ажил явагдаж байсан уу? Хэрэв тийм бол ямар хүчээр хэзээ, мөн ямар үр дүн гарсан;
- Хар тамхины агууламжтай ургамалыг хураасан ургацыг хаана хадгалдаг вэ? Хадгалах газар руу яаж тээвэрлэдэг вэ? Тээвэрлэх явцад хэрхэн хамгаалдаг;
- Хар тамхины агууламжтай ургамалыг хэн хаана боловсруулдаг вэ? Боловсруулах газар руу яаж тээвэрлэдэг, яаж хамгаалдаг;
- Хар тамхины агууламжтай ургамалыг хэн худалдаж авдаг вэ? Хаашаа яаж юугаар тээвэрлэдэг вэ? г.м.

Хууль бус лабораторид хар тамхины агууламжтай ургамлыг боловсруулахтай холбоотой гэмт хэрэг мөрдөх ажиллагаа.⁶⁶

- Хар тамхи мансууруулах бодисыг боловсруулдаг хууль бус лабораторийн байршлын талаар мэдээлэл байгаа эсэх? Хар тамхи мансууруулах бодисыг боловсруулдаг тоног төхөөрөмжийг хэн суурилуулдаг, ямар төхөөрөмж хэрэглэдэг вэ?
- Ямар төрлийн хар тамхи, мансууруулах бодис тухайн лабораторид боловсруулдаг бөгөөд хэр их хэмжээтэйгээр үйлдвэрлэдэг, хар тамхи боловсруулах зориулалттай түүхий эд болон дайврыг хаанаас болон ямар төрлийг зөөвөрлөдөг талаар.
- Хэн тус лабораторийг эзэмшдэг, ямар хүмүүс ажилладаг болон хэн уг газрыг санхүүжүүлдэг талаар;
- Ямар төрлийн хар тамхи, мансууруулах бодис хууль бус лабораторид үйлдвэрлэгдэж байгаа, ямар хэмжээтэй болон хаанаас, ямар мансууруулах бодис агуулсан түүхий эд ба прекурсоруд бэлтгэхэд ашиглаж байгаа;
- Ямар этгээд уг лаборатори ажиллуулдаг, ямар этгээд уг газар ажилладаг болон ямар этгээд энэхүү үйлдвэрлэлийг санхүүжүүлдэг;
- Үйлдвэрлэгдэж буй бодисын цэвэр байдал болон ямар хэлбэрээр үйлдвэрлэгддэг “ нунтаг, кристал, шингэн, капсул, таблетка, цаасанд шингээдэг эсвэл өөр хэлбэрээр боловсруулдаг” гэх зэрэг;
- Ямар аргаар болон технологиор хийдэг;
- Ажиллаж байгаа этгээдтэй хэрхэн харилцдаг талаар;
- Лабораторийг хэрхэн ямар техникээр хамгаалдаг болон ямар нуувчлалын арга хэрэглэдэг ба байраа хэдий хугацаагаар өөрчилдөг бөгөөд хэн байршил өөрчлөх талаар шийд гаргадаг;
- Түүхий эдийг хэрхэн авчирдаг болон ямар аргаар бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрээс гаргадаг. Зөөврийн машины төрөл, улсын бүртгэлийн дугаар, жолооч нарын овог, нэр, эзэмшигч. Тээвэрлэдэг маршрут ба эцсийн ямар цэгт хүргэж өгдөг;
- Бэлэн болсон бүтээгдэхүүний данс хөтөлдөг эсэх;
- Ямар аргаар хуучин тоног төхөөрөмж болон химийн гаралтай түүхийн эдийн хаягдлаас салдаг болон ямар төрлийн химийн хаягдал гарч байгаа
- Өөр уг лабораторийн талаар ямар мэдээлэл байгаа г.м.

Хууль ёсны дагуу мансууруулах бодисын эргэлтээс алга болсон хар тамхи, мансууруулах бодисын гэмт хэрэг мөрдөх ажиллагаа.⁶⁷

⁶⁵ Т.Дамбийням нар. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагаа /Тэргүүн дэтэр/ УБ., 2016 он. 386 дахь тал

⁶⁶ Т.Дамбийням нар. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагаа /Тэргүүн дэтэр/ УБ., 2016 он. 387 дэх тал

- Ямар төрлийн эмнүүд болон ямар зориулалтаар мансууруулах бодис хийгдэхэд ашиглагддаг. Хэн, хаана эмчилгээний зориулалтаар мансууруулах бодис үйлдвэрлэдэг
- Ямар арга замаар уг эмүүдийг гаргаж авдаг. Хэрэв хулгайлагдаж байгаа бол хэн, хаанаас, хэзээ, ямар арга замаар хулгайлдаг эсвэл хуурамч эмийн жороор авдаг бол хэн, хэрхэн хийж байгаа талаар;
- Хууль бусаар эм олгодог эмч, эм зүйч нарын нэрсийг мэдэх эсэх болон тэдгээрийн үүрэг, сонирхол;
- Хэн, ямар аргаар хууль бус үйл ажиллагаагаа нууцлахын тулд тайланг өөрчлөөд байгаа
- Хууль бус үйл ажиллагаанд оролцож байгаа зуучлагч нарын нэрс;
- Эмч болон эм зүйч нар хууль бусаар зарж, борлуулаад хуурамч жор нэмж олох боломж байгаа эсэх, хэрэв байгаа бол ямар эх сурвалжаас авч байгаа болон ямар аргаар;
- Эмч, эм зүйч хууль бусаар мансууруулах төрлийн эмийг дараа нь ямар нэг боловсруулалтгүйгээр хар тамхи болгож ашиглах боломжтой бодисыг хажуудаа шууд хэрэглэхийг шаарддаг эсэх;
- Эрүүл мэндийн байгууллагын хөлсний ажилчид хууль бус эмийн үйл ажиллагаанд оролцдог эсэх хэрэв тийм бол хэн, ямар үүрэгтэйгээр болон ашиг, сонирхол;
- Ямар аргаар хууль бус үйл ажиллагаагаа нууцалдаг талаар г.м.

Улсын хилээр хууль бусаар хар тамхи, мансууруулах бодис нэвтрүүлэх, түгээх болон хадгалах гэмт хэрэг мөрдөх ажиллагаа:⁶⁸

- Хаанаас болон ямар аргаар хар тамхи зөөвөрлөдөг болон хаанаас, хэнээс хар тамхины түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн худалдан авдаг ба борлуулдаг;
 - Хэн, хаана, хэнд түүхий эд болон бүтээгдэхүүнд мөнгө төлдөг болон тээврийн хэрэгслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
 - Хар тамхи, мансууруулах бодис тээвэрлэхэд зориулж тусгайлан тээврийн хэрэгсэлд нэмэлт, өөрчлөлт хийсэн эсэх, ямар өөрчлөлт хийсэн;
 - Хар тамхи, мансууруулах бодис тээвэрлэх маршрут эцсийн очих цэг болон арга “дагалдаж явдаг хамгаалалт гэх зэрэг”, хүч болон ямар тоног төхөөрөмж дагалдах явцад ашигладаг гэх зэрэг;
 - Хар тамхи, мансууруулах бодисын түүхий эд болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн хадгалдаг газар, агуулах байгаа эсэх, ямар этгээд уг газар, агуулахыг эзэмшдэг, мөн хамгаалалтын талаар, түүнчлэн хэн боодол баглаа хариуцдаг;
 - Хар тамхи, мансууруулах бодис тээвэрлэхэд тусгай курьер буюу тээвэрлэгч ажилладаг эсэх, хэн ямар журмаар тэдгээрийг элсүүлдэг;
 - Тээвэрлэгч нар хар тамхи, мансууруулах бодис хэрхэн нуувчилж тээвэрлэдэг болон тэдгээрийн маршрут, ашигладаг тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн талаар;
 - Тээвэрлэгч хэдэн төгрөгийн шан, урамшуулал авдаг, дагалдаж хамгаалалтын хүмүүс явдаг эсэх эсвэл давхар даатгадаг эсэх;
 - Хар тамхи, мансууруулах бодис олж авахад, тээвэрлэхэд болон худалдахад харилцаа холбоог хэрхэн зохион байгуулсан талаар;
 - Яриа, өгүүллийг сонсохоос хамгаалдаг эсэх;
 - Аль боомтоор эсвэл өөр газраар улсын хилийг давуулдаг, яагаад заавал тэр газар;
 - Ямар аргаар түгээлтийг нууцалдаг;
 - Хар тамхи, мансууруулах бодис нийлүүлээд түүний мөнгийг хэрхэн төлдөг, авдаг “баруун зүүнээр, урьдчилгаа авдаг эсэх;
 - Ямар таних дохиогоор болон дуудлагаар түгээгч болон худалдан авагч нар бие бие таньдаг;
 - Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус үйл ажиллагаанд оролцдог төрийн алба хаагч болон бизнес эрхлэгчид байдаг талаар г.м.
- Хар тамхи, мансууруулах бодис худалдах гэмт хэрэг мөрдөх ажиллагаа⁶⁹-нд:

⁶⁷ Т.Дамбийням нар. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагаа /Тэргүүн дэтэр/ УБ., 2016 он 388 дахь тал

⁶⁸ Т.Дамбийням нар. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагаа /Тэргүүн дэтэр/ УБ., 2016 он 388 дахь тал

⁶⁹ Т.Дамбийням нар. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажиллагаа /Тэргүүн дэтэр/ УБ., 2016 он 389 дэх тал

- Ямар аргаар хар тамхи, мансууруулах бодис түгээдэг талаар, гудамж, талбай дээр жижиглэнгээр их, дунд болон бага гарын дилерээр зарагддаг, эсвэл шууд лабораториас орж ирдэг талаар;
 - Хар тамхи, мансууруулах бодис түгээгч шууд үйлдвэрлэгчтэй харилцдаг эсвэл дунд нь зуучлагч байдаг эсэх, хэн борлуулалт хариуцаж хийдэг талаар;
 - Ямар төрлийн хар тамхи, мансууруулах бодис зааж өгсөн этгээдүүд борлуулдаг болон хэмжээ, үнийн талаар;
 - Хар тамхи, мансууруулах бодис хэрхэн борлуулдаг талаар;
 - Хар тамхи, мансууруулах бодис худалдан авдаг хүмүүсийн овог, нэр болон оршин суугаа хаягийн талаар;
 - Хар тамхи, мансууруулах бодис түгээхэд гуравдагч этгээдүүд оролцдог эсэх, оролцдог бол тэдгээрийн талаарх мэдээлэл болоод тэдний үүрэг, сонирхолын талаар;
 - Хар тамхи, мансууруулах бодисын түгээгч болон борлуулагч нарыг хариуцдаг этгээд ба ямар төрлийн хамгаалалт, аюулгүй байдал харилцаа холбоо, нууцлал ашигладаг талаар;
 - Ямар төрлийн хар тамхи, мансууруулах бодис байцаалтанд хэлж өгсөн орон, байранд хэрэглэдэг болон насанд хүрээгүй хүүхэд, залуучууд очдог эсэх очдог бол тэдний тухай дэлгэрэнгүй мэдээллийн талаар;
 - Насанд хүрээгүй хүүхэд, залуучуудыг хар тамхи, мансууруулах бодист донтуулж оруулсан талаар мэдэх эсэх, мэдэж байгаа бол тэдгээрийн овог, нэр болон хар тамхи, мансууруулах бодисонд татан оруулсан этгээдүүдийн талаарх мэдээллийн талаар г.м.
- Энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч байдаггүй онцлогтой учир хэн нэгнээс цагдаагийн байгууллагад хандан гомдол гаргадаггүй тул цагдаагийн байгууллага өөрөө илрүүлэх шаардлагатай.

Хүний бие, тээврийн хэрэгсэл, орон байранд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис байгаа талаарх үндэслэл бүхий мэдээллийг цагдаагийн алба хаагч шалгахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийг удирдлага болгож байна.

Мөн цагдаагийн алба хаагч нийтлэг чиг үүргийнхээ дагуу тухайн ажиллагааг явуулсан бол холбогдох материалыг харьяалах цагдаагийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлдэг. Үргэлжлүүлэн хэргийг хүлээн авч шалгах албан тушаалтан уг эм, бэлдмэл, бодисыг мансууруулах төрлийн бодис мөн эсэх, ямар төрлийн бодис, хэдий хэмжээний агууламжтай болохыг тогтоолгохоор шинжилгээний байгууллагад дүгнэлт гаргуулахаар нэн даруй шилжүүлнэ.

Мансуурагч нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх, эмнэлэг, эмчийн хяналтад мансууруулах сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлийг хэрэглэдэг эсэхийг тогтоолгохоор мэргэжлийн байгууллагад хандаж шинжилгээ хийлгэнэ.

Энэ төрлийн гэмт хэрэгт гадаадын иргэн, харьяалалгүй хүн холбогдон шалгагдахаар бол Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 232-т заасныг баримтална.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодистой холбоотой гэмт хэргийн гэрчийг байцаахаас өмнө тэрээр сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүн эсэхийг тогтоож, Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан хариуцлагын талаар сануулах нь мэдүүлгийг үнэн зөв өгөх гэрч, хохирогч, бусдыг гэмт хэрэг .

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг биедээ авч яваад шалгагдсан хүнээс эм, бэлдмэлийг эмчилгээний зорилгоор хэрэглэж байгаа эсэхийг лавлах ба тухайн хүний энэ байдал нотлогдохгүй бол гэмт хэрэгт сэжиглэн шалгана. Хэрэв эмчилгээний зориулалтаар хэрэглэж байгаа бол дээж авч шинжилгээнд хүргүүлэхийн зэрэгцээ цагдаагийн байгууллагад баривчлагдан шалгагдах хугацаанд эмчийн хяналтад байлгана.

Эмчилгээний зорилгоор хэрэглэж байгаа нь шалгалтаар тогтоогдсон бол эм, бэлдмэлийг тухайн хүнд буцаан олгоно.

Сэжигтэн, яллагдагчийн хань харилцааг тогтоох, гэмт хэргийг бүрэн гүйцэд илрүүлэх, нотлох зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 2.14, 2.15, 3 дахь хэсгүүдэд зааснаар мөрдөгчийн гаргасан саналын дагуу прокурор нь харьяалах мөрдөгчид даалгавар хүргүүлж биелэлтийг хүлээн авна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис биедээ нуусан хүний шулуун гэдэс, залгиур хоолой зэрэг дотор эрхтэнд гадны биет байгаа нь техник хэрэгсэлээр тогтоогдсон бол нарийн мэргэжлийн эмчийг оролцуулж, эмнэлгийн нөхцөлд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 215-т заасныг удирдлага болгон хураан авна.

Энэ төрлийн гэмт хэргийг шалгахдаа иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, нэр төр, алдар хүндийг гутаах, доромжлох, байгууллага, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хүнийг хилс хэрэгт холбогдуулахыг хориглоно.

Цагдаагийн байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг дараах зорилгоор ашиглаж болно. Үүнд:

- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын дээжийн сан бүрдүүлэх, харьцуулалт хийх;
- Зохион байгуулалтай гэмт бүлгийн үйл ажиллагааг илчлэх зорилгоор;
- Мэргэжлийн болон албаны сургалтад ашиглах;
- Албаны эрэлч нохойн нэгжийн сургалтын үйл ажиллагааны чиглэлээр тус тус ашиглахаар зохиулсан байна.

Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг шалган баримтжуулах асуудал энэхүү цаг хугацаанд анхаарал татсаар байна. Иймд эрх бүхий албан хаагч нарт холбогдох хууль, дүрэм, журам, актуудыг талаарх мэдлэгээ дээшлүүлэх тэдгээрийг тухай бүрт нь мөрдөн ажиллах хэрэгцээ шаардлага байсаар байна.

---oOo---

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ**
(БНХАУ, ОХУ-тай байгуулсан гэрээний хүрээнд)

Б.Батцэрэн

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Монгол Улсаас БНХАУ, ОХУ-тай байгуулсан эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний хэрэгжилт, гадаад улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах онцлогын талаар дурдсан.

Түлхүүр үг: Эрх зүйн туслалцаа, эрүүгийн хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Талууд.

Орчин цагт гэмт хэрэг дэлхийн хөгжлийн дагуу даяарчлагдан зөвхөн нэг улсын хэмжээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болж улс, тив дамнан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагааг явуулах шаардлага тавигдсан. Гэвч Монгол Улс эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг төдийлөн олон улстай байгуулаагүй, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан ч гэсэн гэрээний агуулга хуучирсан, гэрээ байгуулсан улс гэрээний үүрэгтэй хайнга хандах, биелүүлэхгүй байна.

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”⁷⁰ гэж эрх зүйн хувьд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг зарим улсын нэгэн адил Үндсэн хуульдаа тусгаж өгсөн.

Монгол Улс “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг үзэглэсэн оноор нь авч үзвэл:

- 1968, 1989, 2000 онд 2 улстай
- 1969, 1972, 1976, 1981, 1988, 1992, 1993, 1995, 1998, 2001, 2018 онд тус бүр 1 улстай
- 1999 онд 3 Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулжээ.

1968-2018 онд нийт 19 бие даасан улс, 1 засаг захиргааны онцгой бүстэй “Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулсан байгаа боловч дээрх гэрээ байгуулсан улсаас задарсан, нэгдсэн гэх мэт шалтгааны улмаас одоо хүчин төгөлдөр гэж хэлж болохоор 16 гэрээ байна. /Үүнд: систимийн өөрчлөлт, улсын нэрний өөрчлөлт зэргийг тусгаагүй болно./ Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн 193 орон, Монгол Улсын Засгийн газрын 244 дүгээр тогтоолын хавсралтад заасан офшор бүсийн 42 улс байгаа гэж үзэхэд манай улсын хувьд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг яаралтай бусад оронтой байгуулах шаардлагатай.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”⁷¹, мөн хуулийн Арван наймдугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Монгол Улсын дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харъяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно”⁷², 18.2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэний харъяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална”⁷³, мөн 18.5 дахь хэсэгт “Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно”⁷⁴ гэж тус тус заасан нь манай улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хирээр эрх зүйн шинэчлэлтэй холбогдуулан оруулсан зүйл хэсэг ойлгож болох юм.

⁷⁰ Төрийн мэдээлэл. 1992 он

⁷¹ Төрийн мэдээлэл. 1992 он

⁷² Төрийн мэдээлэл. 1992 он

⁷³ Төрийн мэдээлэл. 1992 он

⁷⁴ Төрийн мэдээлэл. 1992 он

Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндсэн хуулийн Жаран долоодугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хороо нь гадаад улстай байгуулсан гэрээ болон чухал хэлэлцээрийг соёрхон батлах, цуцлах тухай шийдвэр гаргах”⁷⁵ эрхтэй гэж заасан.

Монгол Улс, ОХУ-тай 1993 онд, БНХАУ-тай 1994 онд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээнд заахдаа бие биенийхээ эсрэг чиглэсэн цэрэг, улс төрийн аливаа байгууллага, эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд харшилсан ямар нэг гэрээ хэлэлцээрийг гуравдахь оронтой байгуулахгүй байх үүрэгтэй гэжээ.

БНМАУ, БНХАУ-ын хооронд байгуулсан Иргэний болон эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий байгууллага бие биедээ хүсэлт тавих буюу эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхдээ өөрийн зохих төв байгууллагаар дамжуулан харилцаж байна.”, 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Төв байгууллага” гэж БНМАУ-ын хувьд БНМАУ-ын Хууль зүй, арбитрын яам, БНМАУ-ын Дээд Шүүхийг; БНХАУ-ын хувьд БНХАУ-ын Шүүх яам, БНХАУ-ын Ардын Дээд Шүүхийг тус тус хэлнэ.”⁷⁶ гэж тус тус заасан.

Монгол Улс, ОХУ-ын эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээний 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэхүү гэрээний зорилгыг биелүүлэх төв байгууллага гэдэгт Монгол Улсын хувьд Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий Прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, ОХУ-ын хувьд –Хууль зүйн яам, дотоод явдлын яам, Улсын Ерөнхий Прокурорын газар тус тус хамаарна. 4 дэх хэсэгт “Хэлэлцэн тохирогч 2 талын хил орчмын хууль сахиулах байгууллагууд зарим асуудлаар өөр хоорондоо шууд харилцаж болохыг төв байгууллагууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ”⁷⁷ гэж төв байгууллагыг ялгамжтайгаар заасан байна. Энэ нь гэрээг хэрэглэхэд хүндрэлтэй, гэрээний үүргийг чухам аль төв байгууллага хэлэлцэн тохирогч талаас шаардах нь ойлгомжгүй байна.

ОХУ-тай байгуулсан гэрээний хувьд Хэлэлцэн тохирогч 2 талын хил орчмын хууль сахиулах байгууллагууд зарим асуудлаар өөр хоорондоо шууд харилцаж болохыг төв байгууллагууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ гэж өнгөц харахад, нааштай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой хугацаа, зардал хэмнэхээр харагдаж байгаа боловч харилцан зөвшилцөөгүй тохиолдолд бие даан тодорхой асуудлаар үйл ажиллагаа явуулах боломжгүй, заавал харилцан зөвшилцсөн бичиг баримт үйлдсэн байх, зөвхөн бичиг баримтад тусгагдсан асуудлаар л харилцаж болохоор харагдаж байна.

БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагаас өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу үйлдсэн буюу гэрчилсэн баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өөр ямар нэгэн баталгаагүйгээр хэрэглэж болно.” 2 дахь хэсэгт “Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагын үйлдсэн албан ёсны баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Талын эрх бүхий байгууллагас үйлдсэн адилтгах баримт бичгийн нэг адил хүчин төгөлдөр байна”⁷⁸ гэж гэрээнд заасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүсэлт хүлээн авч гүйцэтгэсэн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаа нь даалгавар өгөгч талын хувьд шууд нотлох баримтаар үнэлж болох эсэх нь эргэлзээтэй. Харин ОХУ-тай байгуулсан гэрээний хувьд бичиг, баримтын нотлох чадварын талаар огт дурдаагүй байна.

Дүгнэлт

Бүгд Найрамдах Хятад Улсын хувьд гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх, хойрго хандах зэрэг асуудал ажиглагдаж байна. Харин Оросын Холбооны Улсын хувьд газар нутгийн онцлогоос хамаарч эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу мөрдөн байцаагчийн даалгавар явуулахад уг даалгаварт төдийлөн ач холбогдол өгөхгүй байх, мөн хоёр улсын хувьд зөвхөн гэрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа эрх

⁷⁵ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндсэн хууль Бээжин хот 1932.12.04

⁷⁶ БНМАУ, БНХАУ-ын хооронд Иргэний болон Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ 1989.08.31 Улаанбаатар хот

⁷⁷ Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, Иргэний ба Эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ 1999.04.20 Улаанбаатар хот

⁷⁸ БНМАУ, БНХАУ-ын хооронд Иргэний болон Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ 1989.08.31 Улаанбаатар хот

бүхий байгууллагын төв байгууллагаар нь дамжуулан тухайн хэлэлцэн тохирогч талд явуулж байгаа аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шат дамжлага ихтэй цаг хугацааны хувьд удааширч байна.

Мөн Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний агуулга хуучирсан, хэт ерөнхий шинжтэй байна. Мөн гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх талаар эрх бүхий байгууллагаас шаардах боломжтой байтал энэ талаар явуулсан бичиг баримт байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Санал

- Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг дэлхийн улсуудтай нэн даруй байгуулах;
- Гэрээний заалтууд харилцан адилгүй байгааг анхаарч аль болох тодорхой, цаг хугацаа, зардал багатай шийдвэрлэх боломжтой болгох;
- Гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрхээ төв байгууллагууд буюу Засгийн газар эдлэх. Хэрэв гэрээний үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүй гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд бичгээр тайлбар авах;
- Бичиг, баримтын нотлох чадварын талаар тусгах, гэрээний хүртээмжид анхаарах;
- Гэрээнд “Харилцах хэл” гэсэн зүйлд харилцан тохирогч хоёр талын албан ёсны хэл болон шаардлагатай тохиолдолд Англи, Орос зэрэг НҮБ-ын албан ёсны хэлээр оруулсан орчуулгын хамт хавсаргах гэж тусгах;

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндсэн хууль. Бээжин хот. 1932
- БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ. 1989
- Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээ. 1999

---o0o---

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

Ш.Чулуун

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн албан хаагч нэг бүрийн тусгай хэрэгслийг гэмт этгээд, зөрчил гаргагчид хэрхэн, ямар арга, хэлбэрээр хэрэглэх аргачлал, ямар хууль эрхийн актыг баримтлах, аюулгүй байдлаа хангаж ажиллах талаар санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Нэг бүрийн тусгай хэрэгсэл, гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, эрх зүйн зохицуулалт, хэрэглэх үндэслэл

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэхдээ бусдын хөдөлгөөнийг хорих, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, эсэрүүцэл довтолгооныг таслан зогсоох зорилгоор нэг бүрийн тусгай хэрэгслийг холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэл, журмын дагуу албаны үйл ажиллагаанд ашиглана.

Цагдаагийн алба хаагч зарим тохиолдолд өөрийн болон бусад хүмүүсийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хор уршиг учруулах аюултай тулгардаг. Ийм үед цагдаагийн албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ цагдаагийн тусгай хэрэгслийг хуулинд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх зайлшгүй шаардлага бий болдог. Тэр дундаа цагдаагийн алба хаагч нь нэг бүрийн тусгай хэрэгслийг өдөр тутмын үйл ажиллагаандаа шаардлага тулгарсан тохиолдолд хэрэглэхээр тогтмол биедээ авч явдаг.

Алба хаагч үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд тэдгээрийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ⁷⁹ гэж Цагдаагийн албаны тухай хуулинд тодорхой тусгаж өгчээ.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ биелүүлэхдээ хуулинд заасан үндэслэл журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх эрхтэй байна.

Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна гэжээ.⁸⁰ Үүнд:

- Гав;
- Хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;
- Резинэн бороохой;
- Цахилгаан бороохой/цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу/;
- Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- Резинэн ба хуванцар сумтай буу ;

Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэнэ.⁸¹

Үүнд:

- Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй халдлагыг таслан зогсоох;
- Гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах;
- Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах;

⁷⁹Цагдаагийн албаны тухай хуулийн 60-р зүйлийн 60.1 дэх заалт

⁸⁰Цагдаагийн албаны тухай хуулийн 51-р зүйлийн 51.1 дэх заалт

⁸¹Цагдаагийн албаны тухай хуулийн 52-р зүйлийн 52.1 дэх заалт

- Баривчлагдсан хүнийг эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад албадан хүргэх, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх;
- Хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;
- Сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;
- Албаны болон бусдын орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- Олон нийтийн арга хэмжээний үед нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй;
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах;
- Тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;
- Энэ хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан үндэслэл бүхий бүх тохиолдолд⁸²
Доор дурдсанаас бусад тохиолдолд жирэмсэн, насанд хүрээгүй, тахир дутуу, өндөр настай, гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- Цагдаагийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэглэн эсвэл бүлэглэн довтолсон;
- Галт зэвсэг, эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсэргүүцсэн;
- Амиа хорлож болзошгүй бол;

Цагдаагийн алба хаагч нь албан үүрэг гүйцэтгэлийн онцлогоос хамааралтайгаар нэг бүрийн тусгай хэрэглэх эрхийг нь дараах байдлаар ялгамжтай зааглаж өгсөн байна. Тухайлбал:

- Жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулсан Шуурхай удирдлагын штаб /Цаашид “Удирдлагын штаб” гэнэ/-ын даргын зөвшөөрөлгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
- Дээр дурдсан үндэслэлээс бусад тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг тухайн нөхцөл байдалд тохируулан цагдаагийн алба хаагч бие даан гаргана⁸³ гэж хуулинд тусгайлан зааж өгчээ.

Нэг бүрийн тусгай хэрэгслийн төрлүүдээс албаны үйл ажиллагаанд түгээмэл ашигладаг зарим тусгай хэрэгслийн талаар дэлгэрүүлэн авч үзье. Үүнд:

Гав

“Монгол хэлний товч тайлбар толь бичиг”⁸⁴-т гав гэдэг үгийн утгыг: Урьдын цагт ялт хүний хоёр гарын бугуйгаар холбож агдлах төмөр хэрэглэл, гарт нь гав торгож, хүзүүнд нь дөнгө өмсгө ... гэж тайлбарлажээ.

Энэ тайлбараас авч үзэхэд гэмт хэрэг үйлдсэн болон сэжиглэгдсэн этгээд, зөрчил гаргасан хүний хууль бус үйлдлийг таслан зогсоох, баривчлах, саатуулах, аюулгүй байдлыг хангах, учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэн хамгаалах зорилгоор гавыг хэрэглэхээр зааж өгсөн байна.

Өнөөдөр цагдаагийн албанд дараах төрлийн гавыг цагдаагийн төрөл мэргэжлийн алба нь өөрийн үйл ажиллагааны онцлог нөхцөл байдлаас шалтгаалж ашиглаж байна. Үүнд:

- Гарны гав /бугуй/
- Хөлний гав / хөлийн нарийн шилбээр эсхүл өвдөгний дээгүүр тушах/
- Хурууны гав /эрхий хуруу/
- Нэг удаагийн гав

⁸² Цагдаагийн албаны тухай хуулийн 58-р зүйлийн 58.1 дэх заалт

⁸³ Цагдаагийн албаны тухай хуулийн 52-р зүйлийн 52.3 дахь заалт

⁸⁴ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966., 136 дахь тал

- Гарны гав /бугуй/
- Хурууны гав /эрхий хуруу/

Цагдаагийн алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа гавыг хэрэглэх тохиолдол түгээмэл байдаг бөгөөд түүнийг хэрэглэх тал дээр тодорхой аргачлал болон дадал, ур чадварыг тухайн алба хаагч нь эзэмшсэн байвал зохино. Өөрөөр хэлбэл, нэг талаас холбогдох хууль тогтоомжинд заасан үндэслэл журам, аргачлалыг зөв баримтлан ажиллах нөгөө талаас гавыг хэрэглэх ур чадвар, дадлыг эзэмших зорилгоор тусгайлсан сургалт дадлагыг хийсэн байх шаардлагатай юм.

Цагдаагийн албанд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хэрэглэх ажиллагаа нь тухайн этгээдийн үйл ажиллагааг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй үед хийгддэг албадлагын тусгай шинж чанартай онцгой арга хэмжээ юм.

Иймд алба хаагчаас албадлагын арга хэмжээг зөв зохистой хуулийн хүрээнд хэрэглэх, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүй байхаас урьдчилан сэргийлэх, эрхээ хэтрүүлэн хэрэглэхгүй байх зорилтыг хангах үндсэн зарчмыг баримтлан ажиллах талаар дотоодын эрх зүйн актанд тусгайлан зааж өгсөн байна.

Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор бусад эрх зүйн дэд актуудад шинэчлэл хийгдсэн. Энэхүү ажлын хүрээнд цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар шинэчлэгдэн батлагдаж албаны үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг, хэрэглэх зааврыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална⁸⁵ гэж хуулинд заажээ.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаал⁸⁶-ыг цагдаагийн байгууллага, алба хаагч нь алба, үйл ажиллагаандаа шаардлагатай нөхцөл байдал бий болсон үед баримтлан мөрдлөг болгон ажиллаж байна.

“Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-т алба хаагч нь гавыг хэрхэн яаж, ямар арга хэлбэрийг сонгож хэрэглэх, ямар зүйл дээр анхаарч ажиллах гэх зэрэг алба хаагчийн үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлж зааглаж өгсөн заалт, хэсгийг тусгайлан оруулсан юм. Тухайлбал, Алба хаагч гавны бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг шалгах ажлын хүрээнд доорхи заалтыг баримтлан гүйцэтгэхээр тусгагдсан байна. Үүнд:

- 2 цагираг, бугуйвч чөлөөтэй эргэж байгаа эсэх
- Цагираг, бугуйвчийн зуух төхөөрөмж бүрэн бүтэн байгаа эсэх
- Түлхүүрийг хийж, цагийн зүүний эсрэг болон цагийн зүүний дагуу эргүүлж, цоожлогч бүрэн бүтэн байгаа эсэх зэргийг тус тус шалгаж үзнэ гэжээ.⁸⁷

Өөрөөр хэлбэл тухайн этгээдэд хэрэглэх гав нь дээр дурдсан шалгуурыг хангасан эвдрэл, гэмтэл, гацаагүй хэвийн ажиллагаатай байхыг үндсэн шаардлага болгож анхааруулсан байна.

Цагдаагийн алба хаагч нь ямар төрлийн гавыг ашиглаж байгаагаас хамаарч тухайн гавыг дараах аргаар хэрэглэсэн байвал зохистой юм⁸⁸. Үүнд:

- Хурууны гавыг эрхий хурууны 1-р үений хойд хэсгээр, хоёр эрхий хурууг хооронд нь буюу 2 хүний эрхий хурууг хооронд холбож биений урд нь ба ард нь гавлаж болно.
- Гарны гавыг 2 гарын бугуйн хэсгээр хооронд нь буюу өөр хүнтэй гавлаж болно. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх үед гарыг нь өөртэйгөө холбон гавлаж болох бөгөөд тээвэрлэх үед гар буюу хөлийг нь авто машины суудал, тэвш, бусад эд зүйлтэй холбон гавлаж болно.
- Хөлний гавыг хөлний нарийн шилбээр хөлийг хооронд нь буюу 2 хүний хөлийг холбон гавлаж болно. Мөн үл хөдлөх зүйлээс холбон гавлаж болно.

Хэдийгээр яг ийм зүйлд хүнийг гавлаж болно, болохгүй гэж тодорхой зааж өгөх нь хүндрэлтэй боловч таны хүнлэг зан чанар, хууль, журамд нийцүүлэн орчноо зөв мэдрэн юунаас, ямар хугацаанд гавлах вэ гэдгээ зөв мэдрэмжтэй сонгох шаардлагатай болдог.

⁸⁵ Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 47-р зүйлийн 47.4 дэх хэсэг

⁸⁶ ХЗДХС, УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдөр баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

⁸⁷ “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.5 дахь заалт

⁸⁸ Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019. 103 дахь тал

Хамгийн гол нь нэгэнт гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргасан, орчин тойрондоо буюу нийгэмд аюултай, эсвэл оргон зайлах үндэслэлтэй байвал та гав хэрэглэх хэрэгтэй.

Тэгэхдээ аль болох ойр ойрхон шалгаж, гар нь түлэгдэх, хайрагдах, холгох, шигдэж орох зэргийг урьдчилан тооцсон байх хэрэгтэй. Зарим тохиолдолд цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн байж болох сэжигтэй этгээдийг төрийн байгууллагад хүргэх явцдаа удаан хугацаанд, чанга гавласнаас болоод хүний гар хөхөрч гэмтэх явдал гардаг.

Мөн гавтай хүнийг түр хугацаагаар орхихдоо хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахааргүйгээр үл хөдлөх зүйлээс гавлаж болно. Ингэхдээ алба хаагч нь тухайн этгээдийн үйл хөдлөл, ажиллагаанд хяналт тавьсан байх шаардлагатай юм.

Цагдаагийн алба хаагч нь дотоодын эрх зүйн актанд заасан бүх төрлийн гавыг хэрэглэхдээ өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, холбогдох хууль болон зааврыг баримталж ажиллах, эрхээ хэтрүүлэхгүй байх зорилгоор дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж мөрдөж ажиллавал зохино.⁸⁹ Тухайлбал,

- Хүйтний улиралд хуруу болон гарны гавыг хэрэглэхдээ хүний биеийн ил хэсэг хайрагдахаас болгоомжлох /Ханцуй болон бээлийний гадна талаар жийрэглэсэн байдлаар хэрэглэх/
- Гав хүний биед шигдэж орох, чангарах зэргийг анзаарч хянаж байх /Хэдийгээр таны гав бүрэн бүтэн ажиллагаатай боловч гавласан хүнээ хяналтгүй, шалгах ажиллагааг удаан хугацаанд хийгээгүй, мөн тухайн өрөө тасалгааны температур, байгаль цаг агаарын байдал гэх зэрэг нөхцлийг тооцож үзэх /
- Гав хэрэглэхдээ заавал түгжиж хэрэглэх /Тухайн этгээдийн бугуйнд гавыг тохируулах, зориулалтын түлхүүрээр түгжих, түгжсэний дараа түлхүүрийг салган авч гавны цагираг, бугуйвч дээр дарж шалгах/
- Хүнийг тээврийн хэрэгсэл дотор холбож гавлахдаа донсолгоонд татагдаж гэмтэхээс сэргийлэх /Холбож гавлах хэсэг, орчин нөхцлөө зөв тооцох/
- Сэжигтэн буюу яллагдагчийг гавлаад дагуулж явахдаа урд нь ба чанх ард нь явж болохгүй зөвхөн баруун зүүн хажууд нь эсвэл баруун хойно нь буюу зүүн хойно нь явах. Аль болохоор аль нэг гараас нь барьж зугатаах болон бүдэрч унахаас хамгаалж явах /Нэг талаас алба хаагч өөрийн аюулгүй байдлаа хангах нөгөө талаас тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндийг учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх/
- Гавтай этгээд өөрөө гавлаа чангалж судаснуудыг боож үхжүүлдэг тул анхаарч байх гэх мэт /Гав хэрэглэсэн тохиолдолд алба хаагчийн хяналтанд байх шаардлагатай/

Бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч бүү

Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд, эсхүл сэжигтэй этгээдийг аюул учруулахгүйгээр хяналтад авахад биеийн хүч хэрэглэх боломжгүй гэж цагдаагийн алба хаагч үзсэн бол резинэн бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч бүүг хэрэглэж болно.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүгээ гүйцэтгэхдээ дараах төрлийн резинэн бороохойг албандаа ашиглаж байна. Тухайлбал,

 <p>80 см урттай хатуу шахмал резинэн бороохой</p>	 <p>100 см урттай хатуу төмөр голтой резинэн бороохой</p>	 <p>Г хэлбэрийн бариултай шахмал резинэн бороохой</p>	 <p>80 см урттай, үзүүр хэсэгтэй булзуутай. Пүрштэй шахмал резинэн бороохой</p>
---	--	--	---

Бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч бүү хэрэглэх

- Бороохойг хувцастай болон нүцгэн биеийн яс, булчин дагуу чиглүүлж ороолгох, цохих, хатгах, бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зэргээр хэрэглэнэ.
- Бороохойг зайнаас биеийн хөдөлгөөнтэй хослуулан хэрэглэх бөгөөд хэт ойрын

⁸⁹ Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019. 105-106 дахь тал

зайнаас довтолж буй тохиолдолд гар, хөлийн цохилттой хослуулан хэрэглэвэл зохино.

- Бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй, аль болох гэмтэл, шарх үүсгэхгүй байхыг эрмэлзэнэ.
- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж, эсхүл цагдаагийн алба хаагчийн амь бие, эрүүл мэндэд хохирол учруулахаар довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний тус газарт цохихгүй байхыг эрмэлзсэн байвал зохино гэж холбогдох зааварт зааж өгсөн байна.⁹⁰

Өөрөөр хэлбэл тухайн нөхцөл байдалд тохируулан ялгамжтай байдлаар хэрэглэх, аль болох бага хохирол учруулахыг алба хаагчид анхааруулж өгчээ.

Цагдаагийн алба хаагчийн резинэн бороохойг хүний биед хэрэглэхийг зөвшөөрдөг дараах хэсгүүд байдаг. Тухайлбал:

- Дал хавсарч цохих
- Гар, хөлийн булчингийн хэсэг
- Зузаан гуяны хэсэг орчимд⁹¹

Гар, хөлийн булчингийн болон зузаан гуяны хэсэг орчимд резинэн бороохойг хэрэглэхдээ дагууд нь гуядаж ороолгох маягаар цохино. Учир нь хүний арьс, мах, булчин, шөрмөсний ширхэг дагуу байдалтай байдаг.

Тиймээс хөндлөн цохивол эдгээр дурдсан хүний биеийн хэсэгт арьс, мах, булчин, шөрмөс тасрах, хөхрөх, няцрах, яс хугарах гэх зэрэг хүнд бэртэл, гэмтэл авч улмаар хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах эрсдэл бий болно.

Резинэн бороохойг хүний биед хэрэглэхийг хориглох тохиолдлууд:

Зөвшөөрснөөс бусад хүний биеийн хэсэг нь хориглох нөхцлийг бүрдүүлдэг байна.

Тухайлбал:

- Хүний толгойны хэсэг;
- Цээж хэвлийн хэсэг;
- Гарын сарвууны хэсэг;
- Эмзэг эрхтэн;
- Гар, хөлийн булчин болон зузаан гуяны хэсэгт хөндлөн цохих;

Цагдаагийн алба хаагч дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд бороохойг хэрэглэхийг хориглоно. Үүнд:

- Тусгай хэрэгслийг хэрэглэсний үр дүнд дахин хэрэглэх үндэслэл арилсан;
- Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүн;
- Хүүхэд /насанд хүрээгүй/;
- Ухаангүй согтуу хүн;
- Өндөр настан;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- Бэртэл гэмтэл нь илэрхий мэдэгдэж байгаа хүний тухайн гэмтэл дээр хэрэглэх;

Цахилгаан гүйдлээр цохигч хэрэгсэл

				
<p>Гар чийдэнтэй /том/ Хүчдэлийн эх үүсвэр 7.2 Вольт</p>	<p>JP-351-II Гар чийдэнтэй, тогонд чийдэнтэй, цэнэглэдэг. залгаж Хүчдэлийн эх үүсвэр: 7.2 вольт</p>	<p>JP-512 Гар чийдэнтэй /дунд эх Хүчдэлийн үүсвэр: 7.2</p>	<p>Гар чийдэнтэй, жижиг хэмжээтэй</p>	<p>Хэмжээ: 24x46x140 м < 1.9 (цахилгаан чичиргээнд) < 0.8А (гэрэлтүүлэгт)</p>

⁹⁰Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.13 дахь хэсэг

⁹¹Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019. 108 дахь тал

Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигчийг дараах байдлаар хэрэглэхээр зааварт нарийвчлан зааж өгчээ.⁹² Үүнд:

- Хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигчийг хэрэглэх зорилгоо тодорхойлж, хүний биед хувцасны гадна талаас цахилгаан үелзлийг нэг газарт 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар хүргэн, байрлалыг сольж хэрэглэх бөгөөд энэ хугацаа нь араатан амьтанд 10 секундээс илүүгүй байхаар тооцогдоно.
- Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгоо тодорхойлж, цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед чиглүүлэн хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж хэрэглэх бөгөөд энэ хугацаа нь араатан амьтанд 5 секундээс илүүгүй байхаар тооцогдоно.
- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд боломжтой бүх тохиолдолд хүний биеийн ил харагдах хэсэгт хэрэглэхгүй байна.
- Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны үйлчлэл нь хүний биеийн булчинлаг хэсэг зангирах, өвдөлт өгөх, мэдрэлийн систем түр сарних хэлбэрээр 5 минут үйлчлэх бөгөөд 20 минутын дараа үйлчлэл бүрэн арилна.⁹³

Цахилгаан гүйдлээр цохигч болон цахилгаан гүйдлээр цохигч бууны хэвийн ажиллагаа, унтраалгыг шалгаж, ажиллуулах бөгөөд бороо, устай газарт хэрэглэхээс зайлсхийх, чийгтэй газарт хадгалахыг хориглоно.

Хүлэг

Цагдаагийн алба хаагч дараах тохиолдолд хүлэг буюу ороох цамц хэрэглэж болно.

Үүнд:

- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан амиа хорлож болзошгүй бол;
- Сэтгэл мэдрэлийн өвчний улмаас өөрийгөө жолоодох чадвараа алдсан буюу согтууруулах ундаа хэрэглэсэн этгээд догшин хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол;
- Түр саатуулах байргүй газарт гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээд оргон зайлж болзошгүй, эсвэл догшин хэрцгий авирлаж бусдад хохирол учруулахаар бол;

Хүлгийг хүний гар, биед шигдэхээргүй, сунадаггүй, үрж гэмтэл учруулахгүй эдлэлээр хийнэ. Өөрөөр хэлбэл нарийн мяндсан юмуу гар биед шигддэг, резинэн болон олсон төрлийн ширүүн материалтай уяа биш зөөлөн даавуун эдлэлтэй хийгдсэн уяа байна.


Хоёр гарыг урд нь ба ард нь болон хөлийг зөөлөн эдээр холбон тугавчилж үзүүрийг хөврөхөөр уяж, хоёр гарыг бугуйгаар, эсхүл эрхий хуруунуудыг холбон хүлнэ. Энэ үед хүлгийг уг этгээд өөрөө тайлах боломжгүй байхад анхаарна. Өөрөөр хэлбэл 2 гарыг зөвхөн бугуйн хэсгээр урд нь ба ард нь холбох эсвэл эрхий хурууг хооронд нь 1 ба 2-р үений дунд хэсгээр урд нь ба ард нь холбон хүлнэ.⁹⁴

Хүний гарын эрхий хурууг хооронд нь холбон хүлэхэд тухайн этгээдийн гутлын үдээсийг ашиглан хүлж болно. Учир нь гутлын үдээс нь хүний гар, биед шигдэхээргүй, сунадаггүй, үрж гэмтэл учруулахгүй эдлэлээр хийгдсэн зөөлөн материалтай уяа байдаг.

⁹²Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт "Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"-ын 3.14 дэх хэсэг

⁹³Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт "Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"-ын 3.15 дахь хэсэг

⁹⁴Мөн тэнд 22 дахь тал



Шаардлагатай бол сандал дээр даруулах болон багана зэрэг зүйлтэй холбож хүлж болно. Энэ үед холбож хүлсэн зүйл нь унаж дарагдах, цохигдохоос сэрэмжилсэн байна. Тухайн холбон хүлсэн зүйл нь тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байвал зохино.

Хүлэг хэрэглэхэд анхаарах зүйл:

- Хүлэгтэй хүнийг тээврийн хэрэгслийн арын суудалд урагш харуулан суулгаж, хамгаалах бүсийг бүсэлнэ. Шаардлагатай бол хаалганы багана зэрэг зүйлтэй холбож болно.

Ороох цамц


Ороох цамцыг даавуун эдлэлээр 2 метр урт ханцуйтай хийнэ. Дараах аргачлалын дагуу ороох цамцыг хүнд хэрэглэнэ.

Ороох цамцыг хүний урд талаас өмсгөж, арын гурван бүчийг хөврөхөөр уяж, ханцуйтай гарыг урд нь зөрүүлэн, ханцуйг хоёр суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлэн урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулах ба суган доогуур оруулан ар тийш татаж, нуруун дээр нь зөрүүлээд урагш эргүүлэн хоёр гарын булчинг даруулан, суган доогуур оруулж үзүүрийг зөрүүлэн буцааж ар нуруунд хөврөхөөр уяна гэж нарийвчлан заажээ.⁹⁵

Ороох цамцыг шууд болон шаардлагатай тохиолдолд хэрэглэж болох эсэх тухай эмнэлгийн магадлагаа урьдчилан гаргуулах буюу эсхүл эмч байлцуулна.

Ороох цамцыг хэрэглэсэн тохиолдолд харгалзан хянаж байгаа алба хаагч өөрийн хяналтандаа байлгах шаардлагатай. Учир нь тухайн этгээдийн хөдөлгөөн хэдийгээр хязгаарлагдсан ч бүрэн гүйцэд хязгаарлагдаагүйн улмаас амиа хорлох, эрүүл мэндээрээ хохирох нөхцөл бүрдэх тул аюулгүй байдлыг сахиж ажиллах зайлшгүй шаардлагатай юм.

⁹⁵ Мөн тэнд 28-29 дэх тал



Тухайн этгээдэд ороох цамцыг хэрэглэсэн ч эсэргүүцэл нь таслан зогсоогдоогүй бол өөр тусгай хэрэгсэлтэй ээлжлэн хэрэглэнэ. Тухайлбал: Гав, хүлэг гэх мэт.

Гэмт хэрэг үйлдсэндээ харамсах, нэр хүндээ унагасандаа гутрах зэрэг болон амиа хорлох оролдлого хийсэн хүнийг өөр бусад оролдлого хийхээс сэрэмжлэн бүрэн хяналтанд авах ёстой болдог бөгөөд ороох цамц, хүлэгтэй хүнд өндрөөс унаж осолдох, цонхоор үсрэх боломж олгохгүй байхыг анхаарах шаардлагатай.

Нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу

Хууль зүйн сайдын А/126 тоот тушаалд нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисыг дараах нэр томъёогоор тодорхойлж өгсөн байна.⁹⁶ Үүнд:

“**Нулимс асгаруулагч**” -Хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байдаг/

“**Амьсгал боогдуулагч**” -Амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодис гэж тус тус тусгайлан заажээ.

Цагдаагийн албаны үйл ажиллагаанд олон төрлийн загвар, хэмжээтэй нэг хүнд болон олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр /газ/, гранат, сум шидэгч төхөөрөмжийг хэрэглэж байна.

Эдгээр тусгай хэрэгслүүд дотроос цагдаагийн өдөр тутмын хэв журам сахиулах, эргүүл, харуул, хамгаалалтын үйл ажиллагаанд ОХУ-д улсад үйлдвэрлэсэн ИЖ-79-8, ИЖ-78-8 загварын хийн бууг төв, орон нутгийн цагдаагийн байгууллага, алба хаагч нь түгээмэл албандаа ашигладаг.

⁹⁶Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”-ын 1.3.2, 1.3.5 дахь заалт



Тус хийн буу нь ашиглахад хялбар, авч явахад хөнгөн, ямар ч үед гацахгүй ажилладаг сайн талтайгаас гадна буцаах механизмын тусламжтайгаар автоматаар ажилладаг юм. Автомат үйл ажиллагаагаар буудсаны дараа гол төмрийг чөлөөлж, цохигч чавхийг дараагийн ажиллагаанд сойж, ээлжийн сумыг дайзнаас саадгүй шилжүүлдэг үйл ажиллагааны цогц юм. Өөрөөр хэлбэл, сум хооронд ямар нэгэн нэмэлт ажиллагаа шаардагдахгүй. Бүх сумаар буудаж дууссаны дараа замаг замаг баригчинд баригдан арын байрлалд түгжигддэг онцлогтой. Бууг ажиллах үед аюулгүй байдлыг хангаж дарцаг хэлбэртэй найдвартай ажиллагаатай механизмыг /гал хамгаалагч/замганд хийж угсарч өгсөн байдаг.⁹⁷

Хийн бүүг ашиглах журам:

Буудахад бэлтгэх ажиллагаа

- Дайзыг 8 ш сумаар цэнэглэх
- Сумтай дайзыг буунд угсрах
- Замгийг татуургаар хамгийн арын байрлалд сойно

Буудсаны дараа:

- Дайзыг буунаас салгах
 - Дайзанд сум үлдсэн эсэхийг шалгах
 - Бууны аюулгүй байдлыг шалгах
 - Хагас задаргаа хийх
 - Арчиж цэвэрлээд тослох
 - Бууны эвлүүлгээг хийгээд ажиллагааг шалгах
 - Замгийн хамгаалалт буюу гал хамгаалагчийг хаах
- Хийн бууны сумыг ямар бодисоор цэнэглэснийг нь дараах 2 аргаар мэдэж болно.

Үүнд:

- Сумны пластмасан тагны өнгө
- Сумны хонгионы ёроолд бичигдсэн үсэглэл /англи/

Сумны пластмасан тагны өнгө нь:

- Шар өнгөтэй бол амьсгал боогдуулагч бодисоор цэнэглэсэн сум
- Улаан, цэнхэр, ягаан, цагаан өнгөтэй бол нулимс асгаруулагч бодисоор цэнэглэсэн сум
- Ногоон өнгөтэй бол дуут дохионы сум байна.

Сумны хонгионы ёроолд бичигдсэн үсэглэл /англи/ нь:

- CS гэсэн үсэгтэй байвал амьсгал боогдуулагч бодисоор цэнэглэсэн сум
- CN гэсэн үсэгтэй байвал нулимс асгаруулагч бодисоор цэнэглэсэн сум
- PS гэсэн үсэгтэй байвал амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч бодисыг давхар агуулсан байна.
 - o Нулимс асгаруулагч бодис нь хүнд үйлчлэхдээ нүд, хамрын хөндийг гүн хорсгож, их хэмжээний нулимс асгаруулна. Харин амьсгал боогдуулагч бодис нь хордуулах бодис бөгөөд нүдний салст бүрхүүл болон амьсгалын замыг

⁹⁷ Н.Ганбадрал. Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл. УБ., 2002. 25 дахь тал

хүчтэй цочроож их хэмжээний нулимс асгарах, хамар, багалзуур хорсож цээжний хөндийгөөр өвдөх үйлчилгээг үзүүлнэ.

Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг давхар агуулсан бодис нь дээрхи үйлчлэлийг давхар агуулахаас гадна зовхи анилдах, хүндээр ханиалгуулах, дотор муухайрах, огиулах шинж тэмдгийг үзүүлнэ.

Дээрхи бодисуудыг битүү орчинд их хэмжээгээр хэрэглэх нь хүнийг гүн хордлогонд оруулах, ухаан алдуулах, цаашлаад үхэлд хүргэх аюултай нөхцлийг бүрдүүлдэг байна.

Иймд битүү өрөө тасалгаанд хийн буугаар буудсан тохиолдолд тухайн өрөө тасалгааг түргэн орхин гарч аль болох цонх хаалгыг онгойлгон агаарын солилцоо хийлгүүлэн хэвийн болгох арга хэмжээг авбал зохино.

Агаарын солилцоо муу орчинтой тухайн өрөө тасалгаанд сэнс залгаж агаарын солилцоог сайжруулж болно.

Гадаа задгай талбайд хийн буугаар буудлага хийхдээ алба хаагч салхины чигийг сайтар анхаарч салхины дээд талаас нь буудахыг анхаарах хэрэгтэй.

Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийн үйлчлэл нөлөөлсөн хүний эсэргүүцэл, довтолгоо зогссон тохиолдолд түүнд бодисын үйлчилгээг саармагжуулах боломж олгоно.

Өөрөөр хэлбэл тухайн этгээд эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болсон үед та өөрийн болон орчны аюулгүй байдлыг сахин хамгаалсны дараа түүнд нүүр гараа угааж арчих, цэвэрлэх боломжийг олгосон байвал зохино.

Хийн бүү, сумыг хэрэглэхэд дараах зүйлийг анхаарсан байна. Үүнд:

- Сумыг зөвхөн зориулалтын саванд авч явах /Үйлдвэрийн пластмасан сав эсвэл бууны дайз/
- Сумны ашиглалтыг хугацааг анхаарах /Ашиглалтын хугацаа нь 3 жил байна./
- Сумыг тоос шороо, бохирдох зүйлээс сайн хамгаалж ил галд ойр болон бусад шатах тослох материалтай цуг хадгалахгүй бөгөөд +5-аас +40 градусын температуртай байр саванд хадгалах
- Хийн буугаар буудлага үйлдэхдээ гарыг шулуун байлгах
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа буутай харьцсан гараа нүүрний хэсэг, ялангуяа нүдэндээ хүргэж болохгүй
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа буутай харьцсан гараа спирт болон спиртэн төрлийн уусмалаар арчих, бүлээн усаар угаах
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа бууны эд ангиудыг салгаж спирт болон спиртэн төрлийн уусмалаар арчиж цэвэрлэх, ялангуяа бууны гол төмрийг спиртийг уусмалаар угаах
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа цэвэрлэх боломжгүй тохиолдолд битүү хайрцаг саванд юмуу эсвэл гялгар уутанд хийж түр хадгалах
- Бодис хүний нүдэнд орсон үед бүлээн усны урсгалд угаах энэ нь хангалтгүй тохиолдолд 3-4%-ийн новокайны уусмал, 1%-ийн атропины уусмалыг 1*1 хэмжээтэйгээр найруулж түүний холимогоор цэвэрлэнэ.

Хийн бүү, сумыг дараах тохиолдолд ашиглахыг хориглоно. ⁹⁸Үүнд:

- Гэмтэл гацаатай буу, сумыг хэрэглэх
- Хугацаа дууссан, байлдааны болон өөр төрлийн сум ашиглах
- 1 метрээс ойр зайд хүний нүүр лүү шууд чиглүүлэн буудах /Хүний эрүүл мэндэд хохирол учруулах магадлал өндөр/
- 0.5 метрээс дотогш зайд буудлага үйлдэх /Сумны хуванцар пластмасан таг нь 0.5 метр зайд бууны гол төмрөөс шидэгдэн гардаг тул хүний биед шигдэх ялангуяа нүдэнд хүнд гэмтэл учруулах магадлал өндөр/
- Салхины эсрэг чиглэлд буудах /Гадаа задгай талбайд хийн буугаар буудлага хийхдээ алба хаагч салхины чигийг сайтар анхаарах/
- Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүн
- Хүүхэд /насанд хүрээгүй/
- Ухаангүй согтуу хүн
- Өндөр настан

⁹⁸ Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019. 115 дахь тал

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

Тухайн этгээдийн гаргасан хэрэг, зөрчлийн байдлаас шалтгаалж түүнд ямар төрлийн хийн бууны сумыг хэрэглэвэл илүү үр дүнтэй болохыг тооцон буудлага үйлдэх нь нэг талаас цагдаагийн алба хаагчийн хийн бууг ашиглах мэргэжлийн ур чадварыг илтгэн харуулах, нөгөө талаас тухайн этгээд нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хэдий боловч түүнд аль болох бага хохирол учруулахыг эрмэлзэх, хүнийн эрхийг дээдлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа байна.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагч нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох аливаа сөрөг үйлдлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн албаны тусгай хэрэгслийг хэрэглэхдээ ашиглах аргачлал, анхаарах зүйл болон холбогдох аюулгүй ажиллагааны зааварчилгааг сайтар судлан албанд мөрдлөг болгон баримтлан ажиллах шаардлагатай. Ингэснээр алба хаагч нь хууль, эрх зүйн баталгаагаар хангагдах, өөрийн аюулгүй байдлаа хангах үндсэн нөхцлийг бүрдүүлнэ.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж:

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09
- ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
- Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

- Н.Ганбадрал. Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл., УБ., 2002
- Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019
- Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966
- Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд. УБ.,1990.09.07

ТӨР, ЗАХИРГАА, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

СОНГУУЛИЙН МАРГААНЫ ХАРЪЯАЛЛЫН АСУУДАЛ

Н.Мөнхзул

ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор,
дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Хүн төрөлхтний дийлэнх хувийн эдэлдэг улс төрийн эрхийн нэг нь сонгуулийн эрх, ялангуяа сонгох эрх гэж үзэж болно. Энэхүү эрхийг хангах баталгаа нь сонгууль мөн бөгөөд энэ нь ардчилсан Үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болдог. Дэлхийн улс орнуудын хөгжлийн түүхэн чиг хандлагаас үзвэл чөлөөт шударга сонгууль нь ардчилсан төрийн үндэс юм.⁹⁹

Монгол Улсад Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг анх 1992 онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулж, Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны эрх зүйн үндсийг тавьсан бөгөөд 2005, 2011 онуудад батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиуд нь тухайн цаг үеийн нийгэм, эдийн засгийн болоод сонгууль зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан Улсын Их Хурлын сонгуулийн харилцааг зохицуулж ирсэн.¹⁰⁰

Сонгуулийн харилцааг Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хамааруулах ба эдгээр хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

Түлхүүр үг: Сонгууль, маргааны харьяалал, сонгуулийн маргаан, хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил

Үндсэн хэсэг

Сонгуулийн маргаан нь Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргаан, Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах маргаан, Эрүүгийн хэргийн шүүхэд харьяалагдах гэмт хэрэг, зөрчил, эрх бүхий албан тушаалтанд харьяалагдах зөрчил, эрх бүхий албан тушаалтанд харьяалагдах маргаан, тэрчлэн төрийн албан хаагч сонгуулийн хууль зөрсөн маргаан, гэмт хэрэг, зөрчил зэргийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм.

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяаллыг дараах байдлаар тогтоож өгчээ.¹⁰¹

д/д	Шийдвэрийн төрөл	Хаана	Гомдол, шаардлага
1	Сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэртэй холбоотой	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд	Гомдол гаргана
2	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэртэй холбоотой	Сонгуулийн ерөнхий хороонд	Гомдол гаргана
3	Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан	Үндсэн хуулийн цэц	Иргэн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий албан тушаалтан хүсэлт гаргана
4	Сонгуулийн ерөнхий хорооны бусад шийдвэртэй холбогдох маргаан	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар,	Нэхэмжлэл
5		Улсын дээд шүүх давж заалдах журмаар	Гомдол

Үндсэн хуулийн зохицуулалт.

⁹⁹ Б.Нармандах., Үндсэн хуулийн эрх зүй, УБ, 2017

¹⁰⁰ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал

¹⁰¹ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйл

Сонгуулийн үйл явц, үр дүнтэй холбогдсон маргаан үүсвэл, түүнийг хуульд зааснаар Сонгуулийн төв байгууллага шийдвэрлэх бөгөөд түүний шийдвэрийг хууль бус гэж үзвэл Үндсэн хуулийн Цэцэд хандан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулна.¹⁰²

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх”, 2.2 дахь хэсэгт “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” маргааныг Үндсэн хуулийн цэцэд харъяалуулж уг асуудлаар иргэний өргөдөл, мэдээлэл, эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр дунд суудлаар хэлэлцэж дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулахаар зохицуулсан. Дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц их суудлын бүрэлдэхүүнээр дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргаснаар хууль, зарлиг, тогтоол, шийдвэр хүчингүй болдог онцлогтой.

Эрүүгийн хуулийн зохицуулалт¹⁰³

Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэсэн арван дөрөвдүгээр бүлгээр¹⁰⁴ зохицуулж, мөрдөн шалгах ажиллагааг Тагнуулын байгууллага¹⁰⁵ хэрэгжүүлж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна. Сонгуулийн гэмт хэргийн үйлдлийн шинжийг дараах байдлаар хуульчилсан.

Объект	Субъект	Үйлдлийн шинж	Объектив шинж	Субъектив шинж	Оногдуулах ял
14.5 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх гэмт хэрэг					
Иргэний сонгох, сонгогдох эрх	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Иргэний сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд Сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа үйл ажиллагаанд	Саад учруулсан	Зориуд (санаатай)	- дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх - нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялын аль нэгийг
Хүндрүүлэх шинж					
Иргэний сонгох, сонгогдох эрх	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Дээрх гэмт хэргийг	Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж Хууран мэхэлж Сонгогчийг эд хөрөнгө, мөнгөөр татаж санал худалдан авч үйлдсэн	Зориуд (санаатай)	- таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялын аль нэгийг
14.6 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх гэмт хэрэг					

¹⁰² www.gec.gov.mn

¹⁰³ С.Гантулга, Б.Энхболд., Эрүүгийн эрх зүй (тусгай анги) сурах бичиг, УБ, 2018, 103-110 дахь тал

¹⁰⁴ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), Төрийн мэдээлэл, УБ, 2016, №7

¹⁰⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг

Сонгууль явуулах талаар тогтоосон журам	18 насанд хүрсэн, сонгуулийн эрхтэй субъект	Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгад	нэгээс илүү удаа санал өгсөн	Санаатай шинж	- дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх - нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялын аль нэгийг
	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна		нэгээс илүү удаа санал өгөхийг зохион байгуулсан		
Сонгууль явуулах талаар тогтоосон журам	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Сонгуулийн саналын хуудас, ард нийтийн санал асуулгын хуудсыг	хууль бусаар бэлтгэсэн	Санаатай шинж	- таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах , - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялын аль нэгийг
			хадгалсан		
			тээвэрлэсэн		
			ашигласан		
14.7 дугаар зүйл. Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах гэмт хэрэг					
Иргэний сонгох, сонгогдох эрх Сонгууль явуулах талаар тогтоосон журам	Сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, эсхүл бусад албан тушаалтан	улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн талаар	сурталчилгаа явуулсан	Санаатай	- таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах - нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ялын аль нэгийг
		сонгогчийн санал өгөх, санал хураах, тоолох ажилд	саад хийсэн	Зориуд (санаатай шинж)	
		бусдыг төлөөлж санал өгөх, саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг	гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх	Зориуд (санаатай шинж)	
		саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авахыг	зохион байгуулсан хатгасан	Санаатай	
		санал хураалтын дүнг	дэмжсэн		
		өөрчилсөн			
14.8 дугаар зүйл. Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг					
Улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүнд, ажил хэргийн нэр хүнд, сонгууль явуулах журам	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж	илт худал мэдээлэл тараасан	Санаатай	- дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх , - нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялын аль

					нэгийг
		Хүндрүүлэх шинж			
Улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүнд, ажил хэргийн нэр хүнд, сонгууль явуулах журам	Төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан		Үйлдсэн	Санаатай	- нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , - зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах , - зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялын аль нэг
14.9 дүгээр зүйл. Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэрэг					
Сонгууль явуулах журам	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилгоор Эрүүгийн хуулийн 14.5, 14.6, 14.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэхэд	бэлтгэсэн зохион байгуулсан	Санаатай	- арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , - хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ялын аль нэгийг

Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.1 дэх хэсэгт ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор "... мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэхийг хориглосон бөгөөд энэ гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг Цагдаагийн байгууллага хэрэгжүүлж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

20.17 дугаар зүйл. Мөрийтэй тоглоом зохион байгуулах					
Хориглосон зохицуулалт	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн байна	1. Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом	зохион байгуулсан	Санаатай	- дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , - хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх , - зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах , - зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ялын аль нэгийг

Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт.

Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил¹⁰⁶ гэсэн 17.1 дүгээр зүйлээр зохицуулсан ба зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна. Хуульд заасан тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийн тодорхой ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр харьяалах нутаг дэвсгэрээс гадна явуулж болно.

¹⁰⁶ Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл

Тухайн зөрчил хэд хэдэн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлийн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага шалган шийдвэрлэнэ. Зөрчил үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, зөрчлийн хэргийг тухайн орон нутагт шалгахад нөлөөлөл үзүүлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон, эсхүл эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргээ хэд хэдэн аймаг, сум, дүүрэгт хэрэгжүүлэх явцад зөрчил илрүүлсэн бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн харьяаллыг прокурор тогтооно.

Сонгуулийн зөрчлийг дараах байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан¹⁰⁷ харьяаллын дагуу шалган шийдвэрлэнэ.

д/д	Зөрчлийн харьяалал	Заалт	Үйлдлийн шинж	Шийтгэл
17.1 дүгээр зүйл.				
1	Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан 17.1 дүгээр зүйлийн 35, 36	7.1.35	Санал хураалтын дүн, сонгуулийн баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, дамжуулахад саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2		7.1.36	Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан явуулж байгаа мэдээллийн ажиллагаанд хуулиар эрх олгогдоогүй хүн, хуулийн этгээд хөндлөнгөөс оролцсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч 7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6, 9, 10, 11, 12, 13, 15 дахь хэсэг, 18.3, 18.5, 18.6, 18.7 дахь заалт, 28, 29, 30, 31, 32, 33, 34	17.1.1	Хүн, хуулийн этгээд сонгуулийн хорооноос мэдээлсэн санал хураалтын урьдчилсан дүнг - илтэд гуйвуулсан, - өөрөөр мэдээлсэн, мэдэгдэл хийсэн бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
4		17.1.2	Сонгуулийн ажилд туслалцаа үзүүлэх, эсхүл сонгуулийн хорооны ажиллах байр, санал авах байрыг үнэ төлбөргүй гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй бол	- хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5		17.1.3	Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулах үүргээ биелүүлээгүй бол	- хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6		17.1.5	Нэр дэвшигчээр бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш нэр дэвшигчээр бүртгэгдсэн этгээд нэр дэвшихээс татгалзсан бол	хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7		17.1.6	Бие даан нэр дэвшигчид нэгдэж сонгууль эрхэлсэн байгууллага байгуулсан бол	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8		17.1.9	Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах журмыг зөрчсөн бол	- хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9		17.1.10	Ухуулах хуудсыг байршуулахдаа цавуу, цавуулаг эд зүйл ашиглан тогтоож гудамж талбай, орчныг бохирдуулсан бол	учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж - хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

¹⁰⁷ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл

			торгоно.
10	17.1.11	Намын далбаа, уриа, таних тэмдгийг байрлуулахыг хориглосон газарт байрлуулсан бол	- хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
11	17.1.12	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах талаар хуулиар тогтоосон журам зөрчсөн бол	хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
12	17.1.13	Сонгуулийн сурталчилгаанд - хуульд заасны дагуу бүртгүүлээгүй цахим хуудас ашигласан, - эсхүл бусдын нэр болон хуурамч цахим хаяг ашигласан бол	- хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
13	17.1.15	Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
14	17.1.18	Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад	- хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
15		18.3.сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт өгсөн, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашигласан;	
16		18.5.хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашигласан;	
17		18.6.чанга яригч ашиглан оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд сонгуулийн сурталчилгаа явуулж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан;	
17		18.7.аливаа шашны зан үйл ашигласан, түүнийг зохион байгуулсан, оролцсон, ивээн тэтгэсэн, шашны холбогдолтой эд зүйл тараасан бол	
18	17.1.28	Сонгуулийн хуульд заасан итгэмжилсэн иргэн хоёроос дээш сонгогчид туслалцаа үзүүлсэн бол	хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
18	17.1.29	Нэр дэвшигч, ажиглагч, улс төрийн албан тушаалтан итгэмжилсэн иргэний үүргийг гүйцэтгэсэн бол	хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
20	17.1.30	Сонгогч нь:	хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
21		30.1.санал авах байрнаас саналын хуудас авч гарсан;	
		30.2.саналын хуудсанд тэмдэглэсэн	

			саналаа болон бусад сонгогчийн тэмдэглэсэн саналыг баримтжуулан зураг авсан, дүрс бичлэг хийсэн, шууд дамжуулсан, бусдад харуулсан;	
22			30.3.саналын хуудсанд зориулалтын бус үзгээр санал тэмдэглэсэн;	
23			30.4.аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар мөнгө, эд зүйл шаардсан, шаардаж авсан бол	
24		17.1.31	Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчийг санал өгөх боломжоор хангах үүргээ биелүүлээгүй бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
25		17.1.32	Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд болон ажиглагч нь сонгуулийн хорооны ажиллах байр болон санал авах байранд сонгуулийн сурталчилгаа, түүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулсан бол	- хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
26		17.1.33	Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэсэн нь <u>эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол</u>	- хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
27		17.1.34	34.Санал авах өдөр: 34.1.согтууруулах ундаагаар үйлчилсэн, худалдан борлуулсан;	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
28	34.2.олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан;			
29	34.3.гадаа болон битүү талбайд худалдаа, үйлчилгээний төв ажиллуулсан бол			
30	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20	17.1.14	Үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан зөрчил гаргасан цахим хуудас болон тухайн мэдээ, мэдээллийг өөрийн сүлжээнд хаагаагүй бол	- хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
31		17.1.15	Эрх бүхий байгууллагаас баталсан цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам зөрчсөн бол	- хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
32		17.1.17	Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийсэн бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
33		17.1.20	Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад оролцсон, эсхүл сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө	- хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

			хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлсэн, нийтэлсэн бол	
34	Татварын улсын байцаагч 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24	17.1.21	Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
35		17.1.22	Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид хандив өгсөн, эсхүл тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгсөн бол	хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж - хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
36		17.1.24	Мөнгөн бус хандив өгөх талаар хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол	хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж - хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
37	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч 17.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 16.7 дахь заалт, 19 дэх хэсэгт	17.1.8	Сонгуулийн сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол	хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
38		17.1.16.7	Хүн, хуулийн этгээд ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор: 16.7.харилцаа холбоо болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулсан нь <u>эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол</u>	- хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
39		17.1.19	Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргасан, эсхүл гаргахгүй байхаар амлалт авсан, гэрээ байгуулсан бол	- хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
40	Монголбанкны хянан шалгагч 17.1 дүгээр зүйлийн 26	17.1.26	Сонгуулийн зардлын данс байршуулсан банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол	- хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
41	Улсын бүртгэлийн хяналтын	17.1.4	Хуульд зааснаас бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг олшруулсан, эсхүл тараасан бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун

	улсын байцаагч 17.1 дүгээр зүйлийн 4			мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
42	Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч 17.1 дүгээр зүйлийн 25, 27	17.1.25	Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол	- хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
43		17.1.27	Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол	хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
44	Эрүүгийн хэргийн шүүх 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт (Зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ)	17.1.7	Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь <u>эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол</u>	- хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
45		17.1.16	Хүн, хуулийн этгээд ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор:	- хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
46			16.1.бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн;	
47			16.2.нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, хонжворт сугалаа зохион байгуулсан, ивээн тэтгэсэн;	
48			16.3.сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулсан, амралт, сувилалд амраасан, сувилуулсан;	
49			16.4.ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн;	
50			16.5.хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэргээр бусдад давуу байдал олгосон, амлалт өгсөн;	
51			16.6.сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулсан;	
52			17.1.18	
				18.1.хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан;
			18.2.зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн;	

53		18.4.нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс тусдаа мөрийн хөтөлбөр гаргаж ашигласан;	
54	17.1.23	Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн хандивыг буцаан шилжүүлээгүй бол	хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж - хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, - хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17.1.7, 17.1.16, 17.1.18.1, 2, 4, 17.1.23 дахь зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх ердийн журмаас гадна тусгай журмыг баримтлан явуулах бол 17.1.15 дахь зөрчил нь цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч шалгах давхар харъяаллыг тогтоосон. Давхар харъяалалтай холбоотой маргаан үүсвэл прокурор журмын дагуу харъяаллыг тогтооно.

Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалт¹⁰⁸.

Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ба Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг Нийслэлийн захиргааны давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

Захиргааны акттай холбоотой маргааны хувьд дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн эсвэл холбогдох захиргааны байгууллага нь дээд шатны захиргааны байгууллага, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд нэхэмжлэл гаргана. Харин захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нэхэмжлэлийг шууд шүүхэд гаргана.¹⁰⁹

Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг, захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.¹¹⁰

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар Сонгуулийн хороод шатлан захирагдах зарчмаар ажиллах ба дээд шатны сонгуулийн хорооны бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг доод шатны сонгуулийн хороо биелүүлэх үүрэгтэй. Дээд шатны сонгуулийн хороо нь доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.

Урьдчилан шийдвэрлэх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог. Гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан тухайлсан хууль байвал түүнийг, байхгүй бол ерөнхийлөн зохицуулсан хуулийг хэрэглэх зохицуулалтын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх дараах журмыг тогтоосон.

Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон гэр бүлийн гишүүний мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсхүл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийн гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг үндэслэн гомдол гаргасан иргэний мэдээллийн талаар лавлагаа гаргах ба сонгогчийн мэдээлэлтэй холбогдсон өөрчлөлтийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад оруулах тул энэ хугацаанаас өмнө шийдвэрлэнэ.

¹⁰⁸ Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл. 2015, №28

¹⁰⁹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14, 112 дугаар зүйл

¹¹⁰ Захиргааны ерөнхий хуулийн 37.1, 59.1

Харин доод шатны сонгуулийн хорооны шийдвэр, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаар дээд шатны сонгуулийн хороонд шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор гомдол гаргах бөгөөд зохих шатны сонгуулийн хороо гомдлыг хүлээж авснаас хойш ГУРВАН хоногийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид хариуг бичгээр мэдэгдэнэ. Ингэснээр захиргааны хэргийн шүүхэд хандах урьчилсан нөхцөл хангагдах юм.

Дүгнэлт

Сонгуулийн маргаан нь Үндсэн хуулийн цэцэд харъяалагдах маргаан, Захиргааны хэргийн шүүхэд харъяалагдах маргаан, Эрүүгийн хэргийн шүүхэд харъяалагдах гэмт хэрэг, зөрчил, эрх бүхий албан тушаалтанд харъяалагдах зөрчил, эрх бүхий албан тушаалтанд харъяалагдах маргаан, тэрчлэн төрийн албан хаагч сонгуулийн хууль зөрсөн маргаан, гэмт хэрэг, зөрчил зэргийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм.

Сонгуулийн маргааны харъяаллыг тогтоохдоо дараах нийтлэг нөхцөл байдлуудыг харгалзан тогтоосон байна. Үүнд:

- үйлдэл, эс үйлдэл;
- эрх зүйн хэм хэмжээний эсрэг чиглэсэн байх;
- гэм буруу;
- нийгэмд учруулах хор аюул;
- хохирол учирсан байх;
- хууль тогтоомжид тусгагдсан байх.

Түүнчлэн маргааны харъяаллыг тогтоохдоо шийдвэр гаргаж байгаа субъект, шийдвэрийн төрөл, зөрчлийн шинж байдал зэргийг харгалзан тогтоосон байна.

Мөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1 дэх хэсгийн “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн зохицуулалтын хүрээнд сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэхгүй, хэлэлцэхгүй, хянахгүй байх орон зайг хааж, хүний улс төрийн эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлж өгсөн байна.

---oOo---

ШҮҮХ БОЛОН АРБИРТ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ ОНОЛЫН АСУУДАЛ

*Ж.Нямдулам
ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Монгол Улсад Шүүх болон Арбитрт иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэх асуудлын эрх зүйн зохицуулалт, практик хэрэглээ, тэр дундаа хэрэг хянан шийдвэрлэх явцад талуудын гаргаж өгөх нотлох баримтын хууль зүйн хүчин чадал, түүнийг арбитрч хэрхэн үнэлэх, нотолгооны шинж болох эсэх асуудлын онолын болон хууль зүйн маргаантай асуудлыг тусгасан болно.

Түлхүүр үг: Арбитр, арбитрч, нотлох баримт, шүүх, шүүхийн өмнөх шат, хууль зүйн хүчин чадал, хууль ёсны нотлох баримт, хуурамч нотлох баримт.

Улс орны эдийн засгийн хөгжлийн хурдац, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ тэлэхийн хирээр улс дамнасан худалдаа, хөрөнгө оруулалт эрчимтэй хөгжиж байна. Үүнийг дагаад бизнесийн маргаанаа талууд зардал, чирэгдэл ихтэй, цаг хугацаа их шаарддаг шүүхийн аргаар бус, харин мэргэшлийн, хөндлөнгийн, хараат бус этгээдээр буюу арбитраар шийдвэрлүүлэх хандлага ч мөн дэлхий даяар нэмэгдэж байна. Манай улсад ч сүүлийн 10-аад жил Арбтрын үйл ажиллагаа эрчимжиж, бизнесийн байгууллагууд шүүхээр бус арбитраар хэрэг маргаанаа шуурхай шийдвэрлүүлэх нь нэмэгдэж байна. 2016 оноос хойш Монгол Улсад нийтдээ 269 хэрэг арбитраар хянан шийдвэрлэсэн байна.¹¹¹



Иргэний шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхэд талууд шүүгчээ сонгох, маргаан шийдвэрлэх ажиллагааны журам, аргыг сонгох боломжгүйгээс гадна шүүхээс тогтоосон хатуу шаардлага, тодорхой цаг хугацаа, цаг хугацааг дэгийн дагуу хэдэн сар, жил ч үргэлжилж болох давж заалдах, хяналтын гээд олон шат дамжлагыг давах шаардлагатай тулгардаг.

Тиймээс бизнесийн маргааныг иргэний шүүхээс гадуур хянан шийдвэрлэх арбитрын тогтолцоо манай улсад чухал төдийгүй түүнийг таниулан ойлгуулах, нийтэд сурталчилах асуудал чухал юм.

2016-2019 оны хооронд арбитраар хянан шийдвэрлэсэн хэрэг маргааныг гэрээний төрлөөр нь авч үзвэл¹¹²


¹¹¹ Монгол Улсад Арбитр үүсч хөгжсөний 90 жилийн ойг угтсан Арбитрчдын өдрийн хэлэлцүүлгээс ... 2019.10.21. МҮХАҮТ

¹¹² Монгол Улсад Арбитр үүсч хөгжсөний 90 жилийн ойг угтсан Арбитрчдын өдрийн хэлэлцүүлгээс ... 2019.10.21. МҮХАҮТ



ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ МАРГААН

/ГЭРЭЭНИЙ ТӨРЛӨӨР/



Гэрээний төрлөөр хамгийн өндөр хувьтай нь худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, зээлийн гэрээ, түрээсийн гэрээ, тэр дундаа үл хөдлөх хөрөнгө түрээслэх гэрээ зонхилох хувь эзэлж байна.

Арбитр нь маргагч талуудын чөлөөт тохиролцооны үндсэн дээр шуурхай, харьцангуй бага зардал, хялбар процессоор хянан шийдвэрлэх боломжийг талуудад олгодог онцлогтой. Өөрөөр хэлбэл маргаанаа шийдвэрлэх арбитрчаа сонгох, тодорхой үндэслэл байвал арбитрчаасаа татгалзах, маргаан шийдвэрлэх ажиллагааны журмыг тохиролцох, арбитрын ажиллагаа явуулах газар, хэлээ сонгох, мөн маргаанаа шийдвэрлэх хэлбэрээ сонгох гэдэг нь талуудын хувьд чөлөөт сонголт байдаг. Энэ нь бизнес эрхлэгчдийн цаг зав, зардал мөнгийг хэмнээд зогсохгүй бизнесийн нэр хүндээ хамгаалах чухал ач холбогдолтой юм.

Арбитрын ажиллагааны онцлог нь:

- Шүүх арбитрын ажиллагаанд оролцож үл болно. /Тусгайлан зааснаас бусад тохиолдолд/;
- Арбитр нь байнгын эсвэл түр байж болно;
- Арбитрын хэлэлцээрийг бичгээр хийнэ;
- Талууд арбитрчийн тоог харилцан тохиролцож тогтоох эрхтэй;
- Арбитрын ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ба аль ч тал нь өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдана;
- Талууд арбитрын ажиллагааны журмыг хуулийн хүрээнд өөрийн үзэмжээр тохиролцон тогтоож болно;
- Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл болох үйл баримт, шийдвэрлүүлэх асуудлын хамт, хариуцагч нь тэдгээртэй холбоотой тайлбараа зохих бүрдүүлбэрийн хамт тус тус талуудын тохиролцсон, эсхүл арбитраас тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй;
- Талууд нэхэмжлэл, эсхүл тайлбартаа хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн нотлох баримтыг хавсаргах, эсхүл цаашид нэмж гаргаж өгөх баримт бичиг, бусад нотлох баримтын талаар дурдана;

- Арбитрын бүрэлдэхүүний тодорхойлсон асуудлаар дүгнэлт гаргуулахаар нэг, эсхүл хэд хэдэн шинжээч томилж болно,¹¹³

Арбитрын үйл ажиллагаанд голлон анхаарах асуудал нь талуудын гаргаж тавих нотлох баримт, мөн шинжээчдийг оролцуулж дүгнэлт гаргуулах асуудал бөгөөд талууд аль аль нь өөрсдийн ашиг сонирхолыг хамгаалсан өөрийн талд ашигтай хотолгоог гаргаж тавих, арбитрч түүнийг шууд үнэлж, ашигдах нь нэг талын ашиг сонирхолд давуу байдал олгох нь тодорхой юм. Тиймээс нотлох баримт гараж тавих, шинжээч оролцуулах, түүнийг үнэлэх асуудал нь онолын хувьд маргантай асуудал юм.

ОХУ-ын эрдэмтдийн сүүлийн үеийн ном зохиолуудад Арбитрын профцессын асуудлыг хөндөхдөө нотолгоо, нотлох баримтыг үнэлэх асуудалд харилцан адилгүй онолын байр суурьтай байна.

Манай улсын тухайд арбитрын үйл ажиллагаанд баримтлах гол эрх зүйн акт нь Монгол Улсын Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга юм. Уг хуулийг МУ-ын Их хурал 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан бөгөөд 2017 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилсэн. Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа 2006 онд нэмэлт, өөрчлөлт орсон Загвар хуульд үндэслэн, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Арбитрын тухай хуулийн дэвшилтэт зохицуулалтыг хадгалан, Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцын дагуу Монгол Улсын хүлээсэн үүргийг үргэлжлүүлэн бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, улмаар Монгол Улс НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Олон улсын худалдааны арбитрын тухай Загвар хуулийг нутагшуулсан улс орон болох нөхцөлийг бүрдүүлэх гол зорилтыг удирдлага болгосон байна.

Арбитрын шинэ хууль нь хөрөнгө оруулалтын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад арбитрын шийдвэрийг гүйцэтгэх, нотлох баримт бүрдүүлэх, түр арга хэмжээ авах гэх зэргээр шүүхтэй холбогдох олон тохиолдолд олон улсын стандартад нийцсэн, иж бүрэн, тодорхой эрх зүйн орчинг бүрдүүлж өгч байгаагаараа онцлог зохицуулалттай болсон.

Мөн МОУҮА-ын арбитрчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот тогтоолоор баталсан Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм юм. Манай улсын хувьд Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын болон үндэсний арбитр нь НҮБ-ын дээрх дүрэмд тулгуурлан боловсруулсан Хэрэг шийдвэрлэх дүрмийн дагуу арбитрын ажиллагааг явуулдагаараа олон улсын жишгээс хол зөрөхгүй ч басхүү Арбитрын шинэ хуульд нийцүүлэн шинэчлэх, илүү боловсронгуй болгох шаардлага бий. Тухайлбал, олон улсын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглагдах Олон улсын барын холбооноос гаргасан чухал зааварчилгаа бүхий баримт бичгүүд байдаг. Эдгээр нь нотлох баримт бүрдүүлэх, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, мөн арбитрчийн болон өмгөөлөгчийн ёс зүйн талаар чухал эх сурвалж болдгийн хувьд цаашид олон улсын арбитрын ажиллагаанд түлхүү хэрэглэх тал дээр анхаарах шаардлагатай.

Дүрмийн 20 дугаар зүйлд нэмэлт материал, нотлох баримт гаргах ба цуглуулах асуудлыг зохицуулсан бөгөөд арбитрын бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааны байдлыг шалгах бөгөөд шаардлагатай бол талуудаас нэмэлт материал шаардах бөгөөд эдгээрийг арбитрт ирүүлэх хугацааг тогтооно.

Арбитрын хэргийн нотлох баримт нь:

- талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээдийн тайлбар;
- гэрчийн мэдүүлэг;
- бичмэл /гэрээ хэлэлцээр, протокол, тодорхойлолт, төлбөрийн даалгавар, тооцооны баримт, тооцоо нийлсэн акт, хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлэг, чанарын сертификат гэх мэт/;
- электрон хэлбэр дэх баримтууд;
- шинжээчийн дүгнэлт;
- эд мөрийн баримт, үзлэгийн тэмдэглэл;

¹¹³ Под редакцией заслуженного деятеля науки РФ, профессора М.К. ТРЕУШНИКОВА. Арбитражный процесс: учебник подготовлен коллективом кафедры гражданского процессуального факультета МГУ им. М.В. Ломоносова и рекомендован Учебно-методическим объединением по юридическому образованию вузов России. М., 2006. С.55-56.

Арбитрын хуралдааны үед шинэ нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай гэж үзвэл арбитрын бүрэлдэхүүн арбитрын хуралдааныг хойшлуулж болно. Мөн нотлох баримт бүрдүүлэхэд шүүх болон бусад байгууллагаас туслалцаа авч болох талаар зохицуулалт хийсэн байна.

Дүрмийн 20.7-д талууд, тэдгээрийн төлөөлөгч, гуравдагч этгээд нь хуурамч нотлох баримт гаргах буюу хууль бус аргаар цуглуулахыг хориглоно. Ийм арга хэлбэрээр гаргасан нотлох баримт нь нотлох чанараа алдах бөгөөд арбитрын шийдвэрийн үндэслэл болохгүй гэжээ.

Гэвч талуудын нотлох баримтын хуурамч, мөн хууль бусаар цуглуулсан болохыг тогтоох асуудал өөрөө эргэлзээтэй юм. Өөрөөр хэлбэл хууль ёсны байх, хууль ёсоор цуглуулсан, хууль зөрчиж цуглуулсныг тогтоох асуудал эргэлзээтэй. Тухайлбал, иргэний хэргийн оролцогч шүүхэд зүгээр нэг баримт гаргаж өгөхийн тулд гаргаж өгч байгаа биш харин тэрээр өөрийн шаардлага, татгалзлын үндэслэлийг нотлох, өөрийн ашиг сонирхолд нийцсэн баримтыг шүүхэд гаргаж өгдөг. Өөрөөр хэлбэл, нотлох баримтаар дамжуулан хэргийн оролцогч өөрийн ашиг сонирхлыг шүүхэд илэрхийлж байгаа гэсэн үг. Энэ үүднээс авч үзвэл шүүх аливаа этгээдийн гаргаж ирсэн баримтад эргэлзэхгүйгээр итгэх, түүнийг үнэлэхгүйгээр шийдвэрийн үндэслэл болгох нь нэг талын ашиг сонирхолд хөтлөгдөх, шүүхийн хөндлөнгийн байр суурийг алдах ноцтой үр дагаварт хүргэдэг.

Шүүх өөрөө санаачилгаар нотлох баримт бүрдүүлдэггүй явдал нь эрх зүйн маргааныг тасалж, хуулийн дагуу хянан шийдвэрлэдэг байгууллагын хөндлөнгийн, хараат бус байр суурийн хамгийн гол илэрхийлэл юм. Энэ байдлын дараагийн илэрхийлэл нь шүүх талуудын гаргаж өгсөн аливаа тайлбар, үндэслэл, нотлох баримтад эргэлзэх эрхтэй, тэдгээрийг дэнсэлж, үнэлсний эцэст өөрийн шийдлийг гаргах үүрэгтэй байдаг явдал юм.

Иргэний хэрэгт цугларсан нотлох баримтын дотор хэргийн оролцогчийн гаргаж өгөөгүй нотлох баримт байдаг. Тухайлбал, хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.-д зааснаар шүүхийн бүрдүүлсэн баримтууд, мөн хуулийн 133 дугаар зүйлд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэж буй хэргүүдэд хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.-д заасны дагуу зохигч биш этгээдийн гаргасан нотлох баримт, шүүх санаачилгаар явуулсан ажиллагааны үр дүнд бий болсон баримтууд (жишээ: ИХШХШТХуулийн 138 дугаар зүйл).

Хуульд эдгээр баримтыг хэрхэн үнэлэх талаар тусгайлсан зохицуулалт хийгээгүй нь энэ баримтыг шүүх огт үнэлэхгүй гэсэн үг биш юм. Шүүх өөрөө хийсэн үзлэг, туршилт, өөр шүүхийн биелүүлсэн даалгавар, шүүхийн үүрэг болгосноор хэргийн оролцогч биш этгээдээс ирүүлсэн баримт зэрэгт хэргийн оролцогчийн ашиг сонирхол байдаггүй тул тэдгээрийг үнэлэхэд хуулийн тусгайлсан зохицуулалт байх шаардлагагүй юм. Эдгээр баримтыг үнэлэхэд шүүхийн баримталдаг үндсэн зарчмууд үйлчилнэ.

Эрүүгийн хэргийн нотлох баримт, түүнийг цуглуулах үнэлэх асуудал нь мөн тусгай хуулиар зохицуулагдах бөгөөд, нотлох баримтыг тал бүрээс үнэлнэ. Энэ нь хэргийн оролцогч хэн алины гаргаж буй үндэслэл, баримтыг анхаарах, нотлох баримтыг аль нэг талын байр сууриас биш харин маргааныг таслах хөндлөнгийн байр сууриас судлаж, үнэлэхийг хэлж байгаа болно. Маргааны эцсийн шийдвэрлэлтэд сонирхолгүй байх явдал нь шүүхэд нотлох баримтыг тал бүрээс үнэлэх боломжийг олгодог.

Нөгөө талаар нотлох баримтыг тал бүрээс үнэлнэ гэдэг нь хэрэгт цугларсан нотлох баримтыг бүрэн дүүрэн судалж, үнэлнэ гэсэн үг юм. Хэрэгт авагдсан нотлох баримт бүрийн талаар шүүх үнэлгээ өгсөн байх шаардлагатай. Энэхүү үнэлгээ нь тухайн нотлох баримтын хамаарал, ач холбогдол, зөвшөөрөгдсөн байдлаас шалтгаалан өөр өөр байх боловч үнэлэгдэхгүй орхигдох ямар ч нотлох баримт байх учиргүй. Хэрэгт цугларсан нотлох баримт маргааныг хянан шийдвэрлэхэд хангалтгүй гэж үзвэл шүүх нэмэлт баримт гаргуулах талаар зохигчдод санал болгох боломжтой бөгөөд энэ ажиллагааг хууль зөрчсөн гэж үзэхгүй.

Нотлох баримтыг үнэлж буй шүүх тухайн баримтыг бусад нотлох баримттай хэрхэн дүйцэж байгаа, тэдгээрийн хооронд ямар уялдаа холбоо байгаа, баримтууд бие биенээ үгүйсгэж байгаа эсэх, нэг үйл баримтыг давхар нотолж байгаа эсэхийг тус тус шалгадаг тул “бодитойгоор харьцуулан үзэх” гэсэн ойлголт нотлох баримтыг тал бүрээс үнэлэх ажиллагааны хэсэг болдог.

Шүүхийн практикаас үзэхэд шүүхүүд зохигчдын гаргасан зарим нотлох баримтын талаар ямар нэгэн дүгнэлт өгөхгүй байх, нэг талын баримтыг нөгөө тал баримтаар үгүйсгэсэн байхад түүнийг нь үнэлэхгүй байх, эсрэг талаас үгүйсгэгдээгүй баримтыг шүүх өөрөө үгүйсгэх,

баталсан, үгүйсгэсэн хоёр баримтыг хоёуланг нь биш харин аль нэгийг нь л үнэлэх зэргээр нотлох баримтыг тал бүрээс үнэлэх хуулийн зарчмыг зөрчих алдаа түгээмэл гаргадаг¹¹⁴.

Арбтраар хэрэг маргааныг хянан шийдвэрлүүлэх сонирхол нь мэргэшсэн арбтрч байдагт оршино. Өөрөөр хэлбэл талуудын маргааныг эвлэрүүлэн зуучлах эсвэл шийдвэрлэх асуудлаар тухай асуудалд мэгэшсэн, зарим тохиолдолд шинжээч хийх арбтрч талуудын гаргасан нотлох баримтын бодит байдлын тухай үнэн мэдээлэл агуулж буй байдалд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй. Үнэн зөв биш нотлох баримт хэргийн нөхцөл байдлыг тогтоох, эсхүл үгүйсгэх чадваргүй байна. Тийм ч учраас нотлох баримтын үнэн зөв байдал заавал шалгагдах ёстой юм. Тухайлбал, нотлох баримтын үнэн зөв байдал мэдээллийн эх сурвалжийн шинж чанар, цугларсан бүх нотлох баримтын хоорондын уялдаа холбоо, харьцуулсан судалгаа зэргээс шалтгаална.

а/ Мэдээллийн эх сурвалжийг шалгах.

Гэрч хэргийн оролцогчидтой ямар харилцаатай болохыг тогтоох нь мэдээллийн эх сурвалжийн чанарыг шалгах нэг арга. Бичмэл нотлох баримтад засвар, тод бус дарагдсан тамга, дугаар, огнооны зөрүү г.м. байдлыг шалгах нь мөн энэ шалгалтад хамаарна.

б/ Бусад нотлох баримттай харьцуулах.

Нотлох баримтууд хоорондоо зөрүүтэй байх, бие биенээ үгүйсгэх нь нотлох баримтын үнэн зөв байдалд эргэлзээ төрүүлэх үндэслэл болно. Уг эргэлзээ арилаагүй тохиолдолд нотлох баримтыг үнэн зөв гэж үзэх боломжгүй

в/ Бүх нотлох баримтыг шинжлэн судлах.

Хэрэгт цугларсан бүх нотлох баримтыг тал бүрээс нь судлан шинжилсний дүнд үнэнд нийцэхгүй нотлох баримтыг тодорхойлж болно.

Дүгнэлт

Олон улсын эдийн засаг талаас ач холбогдол өгвөл дэлхийн улс орнууд хөрөнгө оруулагчдыг татахын тулд өөрийн улсдаа аль болох гадаад хөрөнгө оруулалтын болон гадаадын бизнесийн таатай орчинг бий болгож өрсөлддөг. Таатай орчин гэдэгт хэрэг маргааныг шуурхай, хараат бус, мэргэжлийн өндөр түвшинд хянан шийдвэрлэх тогтолцоо буюу Арбитр зүй ёсоор ордог.

Манай улс 90 жилийн түүхтэй энэ салбар хөгжлийн аль шатанд байгааг эргэн харж, дэлхийн ихэнх улс орон арбитрын талаарх хууль тогтоомжийг батлах, шинэчлэх, олон улсын чиг хандлагад нийцүүлэх гэж идэвхтэй ажилласны үр дүнд өнөөдөр арбитрын шүүхгүй улс орон гэж бараг үгүй болжээ. Гагцхүү бид Арбитрыг иргэдэд зөв сурталчилах, өргөн нэвтрүүлэх, соёл нэвтрүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй байна.

Арбитр бол олон улсад хууль зүйн үйлчилгээний чухал хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн. Монгол Улс болон дэлхийн 150 гаруй улс орон Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх тухай 1958 оны Нью-Йоркийн конвенцид нэгдэн орсон хувьд дэлхийн ихэнх улс оронд Монголын арбитрын шийдвэр хүлээн зөвшөөрөгдөж, биелэгдэх ёстой. Нэгэнт Арбитрын хууль тогтоомж олон улсын стандартад нийцэж байгаа тул түүнийг хэрэгэлэх туршлага, чадвартай, мэргэшсэн, олон улсад өрсөлдөх чадвартай арбитрчээ нийтэд таниулах, мэдээллийн санг өргөтгөх шаардлагатай байна.

¹¹⁴ УДШ-ийн зөвлөмж. 2018.10.10-ны тогтоол. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд нотлох баримт үнэлэх шүүгчийн ажиллагаа.

Ном зүй

1. ИХШХШТ Хууль.
2. Монгол Улсын Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга.
3. МОУУА-ын Арбитрчдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсан Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм.
4. УДШ-ийн зөвлөмж. 2018.10.10-ны тогтоол. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд нотлох баримт үнэлэх шүүгчийн ажиллагаа.
5. Б.Батзориг. Нотолгооны онол. Гарын авлага. УБ., 2013.
6. Монгол Улсад Арбитр үүсч хөгжсөний 90 жилийн ойг угтсан Арбитрчдын өдрийн хэлэлцүүлгээс ... 2019.10.21. МҮХАҮТ
7. Под редакцией заслуженного деятеля науки РФ, профессора М.К. ТРЕУШНИКОВА. Арбитражный процесс: учебник подготовлен коллективом кафедры гражданского процесса юридического факультета МГУ им. М.В. Ломоносова и рекомендован Учебно-методическим объединением по юридическому образованию вузов России. М., 2006.

---oOo---